



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвсүрэнгийн НАРАНБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-48-59, Факс: 32-70-16
E-mail: naranbayar@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.07.22 № УИХ-03/8685
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Хурлын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төсөл, холбогдох тайлан хавсаргав.

Хавсралт хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

П.НАРАНБАЯР

Ч.АНАР

Ж.ГАЛБАДРАХ

П.ГАНЗОРИГ

Л.ГАНТӨМӨР

Б.ЖАВХЛАН

С.ЛҮНДЭГ

О.НОМИНЧИМЭТ

Ч.НОМИН

2026000218



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвсүрэнгийн НАРАНБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-48-59, Факс: 32-70-16
E-mail: naranbayar@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026. 07. 08 № 442-03/8550
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д заасны дагуу өргөн мэдүүлэх тов тогтоолгохоор хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас хуулийн төсөлд санал, дүгнэлтийг авахаар 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-03/4691 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хариу ирүүлээгүй тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 дахь хэсэгт заасны дагуу тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бусад холбогдох байгууллага, иргэдээс санал авч бүрдүүлбэр ханган хүргүүлж байна.

Иймд хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч дэлгэрэнгүй танилцуулга болон холбогдох бусад материалыг хавсаргав.

Хавсралт 220 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

П.НАРАНБАЯР



2026000316



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвсүрэнгийн НАРАНБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-48-59, Факс: 32-70-16
E-mail: naranbayar@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026. 04.30 № 469-03/4691
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл”-ийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

Тус хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, саналаа ирүүлэхийг хүсье.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох тайлан судалгааг хавсаргав.

Хавсралт 112 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



П.НАРАНБАЯР

2026000137



**МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

Ц.Жигжиджавын гудамж 7/1, Бага тойруу, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: (976-51) 26 15 44,

Цахим шуудан: info@supremecourt.mn

2026.06.30 № **05/2457**

танай _____-ны № _____-т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.НАРАНБАЯР ТАНАА**

Танаас 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн УИХ-03/6746 тоот албан бичгээр санал авахаар ирүүлсэн Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанд танилцуулсан болохыг үүгээр уламжилж байна.


ДАРГА



С.ЗАЯАДЭЛГЭР

151602200810

151605700802



.. нэгдсэн мэдээллийн системийн үйлчилгээний тусламжтайгаар
мэдээллийн системийн үйлчилгээний тусламжтайгаар
мэдээллийн системийн үйлчилгээний тусламжтайгаар
мэдээллийн системийн үйлчилгээний тусламжтайгаар
мэдээллийн системийн үйлчилгээний тусламжтайгаар

МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН
МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН

МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН
МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН

МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН
МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН
МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН

МОНГОЛЫН ЭРХ БУСГААРИЙН ШУЛГАН



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
Цахим шуудан: gro@prosecutor.mn,
Цахим хуудас: www.prosecutor.mn

2026. 06. 22 № 2/2535


танай 2026. 06. 09-ны № 344-03/6695-Т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН П.НАРАНБАЯР ТАНАА**

Таны 2026 оны 06 дугаар сарын 09-ний
өдрийн УИХ-03/6693 дугаартай албан бичигтэй
танилцлаа.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог
зохицуулах тухай хуулийн төсөл болон бусад
дагалдах хуулийн төсөлд тусгайлан гаргах саналгүй
болно.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ М.ЧИНБАТ



• 15011900720



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД
С.АМАРСАЙХАН ТАНАА

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

15150 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
5-р хороо Хуульчдын ордон 17 давхар 1701 тоот
Монголын Хуульчдын холбооны байр
Веб: www.mglbar.mn, И-мэйл: info@mglbar.mn
Утас: 70116364, Факс: 70116364

2026.06.16 № 1/463
танай 2026.05.11-ны № 1/2424 -г

Хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 1/2424 дугаартай албан бичгээр ирүүлсэн, Монгол Улсын Их хурлын гишүүн П.Наранбаяраас санаачлан боловсруулсан "Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай" анхдагч хуулийн төсөлд Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчдаас ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлж байна.

"Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай" анхдагч хуулийн төсөл болон түүнийг дагалдах нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг агуулгаас үзэхэд уг төсөл нь хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах сайн зорилготой боловч Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй зарим хууль тогтоомж, тухайлбал, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Үндсэн хууль (Хүний эрхийн хязгаарлалт), болон Зөрчлийн тухай хуулийн хэрэгжих боломж (гадаадын этгээдэд хариуцлага тооцох механизм)-той эрх зүйн хувьд зөрчилдөж, хийдэл үүсгэх эрсдэлтэйгээс гадна зарим зохицуулалтын тодорхойгүй байдал нь практикт хэрэгжихэд хүндрэл үүсгэхүйц байна.

Иймд Монголын Хуульчдын Холбоо нь цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг эрсдэлээс сэргийлэх хуулийн төслийн суурь үзэл баримтлалыг дэмжиж байгаа боловч уг харилцааг бие даасан шинэ хуулиар бус, одоо үйлчилж буй хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь хууль зүйн хувьд үндэслэлтэй, үр нөлөөтэй гэж үзэж байна.

Хавсралт 3 хуудастай.

Хувийг: Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярт ✓

ЕРӨНХИЙЛӨГЧ



М.МӨНХБАТ

01000218

Монголын Хуульчдын холбооны
Ерөнхийлөгчийн 2026 оны 06 сарын
16-ны өдрийн 1/463 дугаар тоот
албан бичгийн хавсралт

8119414

"НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ" ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяраас санаачлан боловсруулсан "Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай" хуулийн төсөл болон түүнд холбогдох материалыг нээлттэй байршуулсан бөгөөд Хуульчдын Холбооны гишүүн хуульчдаас ирүүлсэн үндэслэл бүхий саналуудыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

Хуулийн төслийн эх бичвэрт хэл, найруулгын болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд холбогдох асуудал

1. Төслийн 1.1 дэх хэсгийн найруулгыг засах, тухайлбал "зохицуулах" үгийг давтаж хэрэглэсэн байна.
2. Төслийн 5.1.4-т "хуульд заасан бусад нөхцөлүүд" гэсэн нь ямар хуулийн ямар нөхцөл болох нь тодорхойгүй бөгөөд "нөхцөлүүд" гэж олон тооны дагавар хэрэглэсэн нь хууль тогтоомжийн эх бичвэрт тавигдах шаардлагад нийцээгүй байна.
3. Төслийн 5.3.1-т "хэрэглэгчийн нас баталгаажуулахад иргэний үнэмлэх эсхүл бусад баримт ашиглах сонголттой байх," гэсэн нь "бусад баримт" гэдэг нь хэт ерөнхий, ямар баримт бичгийг зөвшөөрөх нь тодорхойгүй тул субъектив тайлбар хийх боломж олгож байна.
4. Төслийн 5.4-т "Насны хязгаартай нийгмийн сүлжээ эрхлэгч нь хэрэглэгчийг танин мэдэх зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллаж болно." гэж заасан нь "холбогдох байгууллага, албан тушаалтан" гэж хэнийг ойлгох нь тодорхойгүй, мөн "хамтран ажиллаж болно" гэсэн нь заавал биелүүлэх шинжгүй, үзэмжээр шийдэх боломж олгосон.
5. Төслийн 8.2-т "Энэ хуулийг зөрчсөн Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулахаас өмнө мэдэгдэл хүргүүлнэ." гэж заасан нь мэдэгдлийг хэдий хугацааны өмнө хүргүүлэх, үйлчилгээ эрхлэгч хариу тайлбар, арга хэмжээ авах хугацаа тодорхой заагаагүй нь үйлчилгээ эрхлэгчийн болон хэрэглэгчийн эрхийн зөрчил үүсгэхээр байна.
6. Төслийн 9.1-т "Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг зөрчиж байгаа талаар ирүүлсэн гомдол, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна." гэж заасан нь төрийн албан тушаалтан (нийгмийн ажилтан, хууль сахиулагч) болон хувийн хэвшлийн этгээдийг (нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч) нэг заалтад

хамтатган, гомдол шалгах чиг үүргийг тодорхойгүй хуваарилсан, хэн нь ямар арга хэмжээ авах нь мөн адил тодорхойгүй байна. Иймээс төрийн байгууллага болон хувийн хэвшлийн хүлээх үүрэг, гомдол хүлээн авч шийдвэрлэх харьяаллыг зааглан тусдаа заалт болгон оруулах.

7. Төслийн 9.2-т "Энэ зүйлд заасан гомдол, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн утас, цахим шуудан ажиллуулж болно." гэж заасан ба "ажиллуулж болно" гэсэн үзэмжээр шийдвэрлэх хэллэг хэрэглэсэн нь яаралтай тусламжийн сувгийг ажиллуулахгүй байх боломж олгож хуулийн хийдэл үүсгэсэн байна. Тухайлбал, санхүүжилт байхгүй гэх шалтгаанаар яаралтай тусламжийн утсыг ажиллуулахгүй байснаас хуулийн үндсэн зорилго биелэхгүй буюу хүүхэд цахим дарамтад өртсөн тухайгаа цаг алдалгүй мэдээлж чадахгүй хохирох эрсдэлтэй.

Хуулийн төсөл дэх харилцан уялдаагүй, хэрэгжүүлэх процесс, хүлээлгэх хариуцлага тодорхойгүй буюу төрийн байгууллага, үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгчийн хууль ёсны асран хамгаалагчдыг хууль хэрэгжүүлээгүй үндэслэлээр үзэмжээр шийтгэх нөхцөл үүсгэх эрсдэлтэй зохицуулалтууд:

8. Төслийн 5.3.3-т нас баталгаажуулах зорилгоор ашигласан мэдээллийг "нэн даруй устгах" хуулийн үүрэг хүлээлгэсэн байна. Гэвч хэрэв тухайн сошиал платформ нь Зөрчлийн тухай хуулийн нэмэлтээр хүүхдэд бүртгэл үүсгэсэн гэж буруутгагдан шалгагдвал өөрийгөө буруугүй гэдгийг нотлох (тухайн хэрэглэгч хуурамч иргэний үнэмлэх ашигласан эсэх, эсвэл систем хэрхэн шалгасныг баримтжуулах) нотлох баримтгүй болох эрсдэлтэй. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад хуулиар мэдээлэл цуглуулах, хадгалах доод болон дээд хугацааг нарийвчлан зохицуулдаг бөгөөд "нэн даруй устгах" нь эргээд хуулийн хэрэгжилтийг хянахад саад учруулж болзошгүй. Түүнчлэн мэдээллийг устгасан эсэхэд тавих хяналт тодорхойгүй байгаа нь хувь хүний мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл учруулахаар байна.
9. Төслийн 6.1-д аливаа этгээд "Насны хязгаартай нийгмийн сүлжээнд 16 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэх боломжоор хангахгүй байх, эсхүл өөрийн бүртгэлтэй хаягийг ашиглуулахгүй байх үүрэгтэй." гэж заасан боловч энэхүү үүргийн биелэлтэд тогтмол хяналт тавих эрх бүхий этгээд тодорхойгүй, зөвхөн гомдол, мэдээллийн мөрөөр арга хэмжээ авахаар тусгасан нь хууль хүн бүрт тэгш үйлчлэх зарчимтай нийцэхгүй байна.
10. Төслийн 8.1.5-д "Энэ хуулийг зөрчсөн тухай ирүүлсэн гомдол, мэдээллийг үндэслэн энэ хуульд заасан арга хэмжээ аваагүй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх" гэж заасан нь зөвхөн дотоодын энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгчид хамаарах боломжтой ба гомдол, мэдээллийн мөрөөр тэдэнд авах нийгмийн сүлжээний хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ нь учруулсан хор хохиролтой хэрхэн уялдах нь тодорхойгүй байна. Мөн хуулийн төсөлд гадаад улсад үйл ажиллагаа явуулдаг, үндэстэн дамнасан

(Facebook, YouTube, TikTok гэх мэт) нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн асуудал тусгагдаагүй нь хууль тэгш үйлчлэхгүй байх эрсдэл үүсгэж байна. Учир нь Монгол Улсын хууль тогтоомжоор гадаадад байршилтай, Монголд албан ёсны төлөөлөгчийн газаргүй хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулиар шууд торгууль ногдуулах, түүнийгээ биелүүлж хураан авах эрх зүйн болон практик боломж бага. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн "шийтгэл гарцаагүй байх", "хэрэгжихүйц байх" зарчимтай зөрчилдөхөөс гадна үндэсний үйлчилгээ үзүүлэгчдээ ялгаварлан гадуурхах, хясан боох хэрэгсэл болох эрсдэлтэй юм.

11. Энэ хуулийг зөрчсөн нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээ авах эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд шууд олгосон байна. Энэ нь бусад суурь хуулиудаар хүний эрх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарлах, хаах зэрэг эцсийн шийдвэрийг хараат бус шүүхийн байгууллага, эсхүл прокурорын хяналт дор хэрэгжүүлдэг бол энэ төслөөр зохицуулах хороонд хэт өргөн хэмжээний, шүүхийн бус журмаар хандалт хаах эрх мэдэл олгосон нь захиргааны байгууллагын эрх мэдлийн зааг ялгаа, бусад салбарын хуулийн процесстой зөрчилдөх эрсдэлтэй байна.

Хавсралтаар хүргүүлж буй саналуудыг хуулийн төслийн хэлэлцүүлгийн шатанд тусган, төслийг чанаржуулах арга хэмжээ авахыг хүсье.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН П.НАРАНБАЯР
ТАНАА

**МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН
ХОЛБОО**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Г.Чагдаржавын гудамж 32/2, Сав плаза, 18 давхарт
РД: 1626124, Утас/Факс: (+976) 7012-6861.
И-мэйл: info@umguulul.mn, Вэбсайт: www.umguulul.mn

2026. 06.23 № 04/34

танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөлд
санал хүргүүлэх тухай**

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөлтэй танилцаж, Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой харьцуулан судалж үзээд дараах саналыг хүргүүлж байна.

Энэхүү хуулийн төсөл нь хүүхдийг цахим орчны эрсдэл, дарамт, зохисгүй агуулга, цахим гэмт хэргээс хамгаалах, нийгмийн сүлжээний орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилго дэвшүүлсэн нь өнөөгийн нийгмийн бодит хэрэгцээ, олон улсын чиг хандлагатай нийцэж байна. Ялангуяа хүүхдийн мэдээллийн аюулгүй байдал, нас баталгаажуулах тогтолцоо, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг бие даасан хуулиар зохицуулах нь ач холбогдолтой байна.

Хүний эрх, хүүхдийн эрх, мэдээллийн эрх чөлөө болон техник, технологийн бодит нөхцөлтэй уялдуулах шаардлагатай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 4.1.1 болон 5.2-т "16 нас хүрээгүй хүүхдэд нийгмийн сүлжээнд бүртгэл үүсгэхийг хориглоно" гэж тусгасан нь хүүхдийн мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, цахим орчинд оролцох эрхийг бүхэлд нь хязгаарласан шинжтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйл, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 13 дугаар зүйлд хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэйг баталгаажуулсан байдаг. Иймд бүх төрлийн нийгмийн сүлжээнд насны хатуу хориг тогтоохоос илүү эцэг эхийн хяналт, хүүхэд хамгааллын тохиргоо, насанд тохирсон хэрэглээний зохицуулалт бүхий ялгамжтай механизм тусгах шаардлагатай байна.

2. Хуулийн төслийн 5.3.1, 5.3.2-т хэрэглэгчийн насыг иргэний үнэмлэх болон бусад баримтаар баталгаажуулах талаар тусгасан боловч энэ нь хүүхэд болон иргэдийн хувийн мэдээлэл алдагдах, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналтгүй боловсруулалт хийх эрсдэл үүсгэж болзошгүй байна. Түүнчлэн олон улсын нийгмийн сүлжээний платформууд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу техникийн интеграц хийх бодит боломж хязгаарлагдмал байх эрсдэлтэй байна. Нас баталгаажуулах ажиллагааны технологийн стандарт, мэдээлэл хамгаалах баталгаа, хяналтын механизмыг илүү тодорхой зохицуулах шаардлагатай байна.

3. Хуулийн төслийн 5.1-д "насны хязгаартай нийгмийн сүлжээ"-ний ойлголтыг тодорхойлсон боловч "хуульд заасан бусад нөхцөлүүд" гэж нээлттэй байдлаар тусгасан нь хуулийн тодорхой байх зарчимд нийцэхгүй байна. Ямар платформ уг хуульд хамаарахыг захиргааны байгууллагын өргөн хүрээний тайлбараар шийдэх

боломж үүсэж болзошгүй тул шалгуур, нөхцөлийг хуульд илүү тодорхой тусгах шаардлагатай байна.

4. Хуулийн төслийн 7.1.3, 8.1.5-д төрийн байгууллага нийгмийн сүлжээний жагсаалт батлах, хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах арга хэмжээ авах талаар тусгасан боловч ямар үндэслэл, хугацаа, журмаар хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Энэ нь мэдээллийн эрх чөлөө, интернетийн чөлөөт орчинд хэт өргөн хүрээний хязгаарлалт тогтоох эрсдэлтэй бөгөөд шүүхийн хяналтгүйгээр хэрэгжвэл Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрхэд халдах нөхцөл үүсгэж болзошгүй байна.

5. Хуулийн төслийн 6.1-д "өөрийн бүртгэлтэй хаягийг ашиглуулахыг хориглоно" гэж тусгасан боловч уг үйлдлийг хэрхэн тогтоох, ямар этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Практикт хүүхэд эцэг эхийн гар утас, бүртгэл ашиглах тохиолдол түгээмэл байдаг тул хэрэгжилтийн бодит боломж, хяналтын механизмыг нарийвчлан боловсруулах шаардлагатай байна.

6. Хуулийн төслийн 8.1.5-д "хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээ" гэх ойлголтыг хэрэглэсэн боловч энэ нь техник, эрх зүйн хувьд тодорхойгүй байна. Интернет платформын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох асуудал нь Харилцаа холбооны тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон олон улсын интернетийн зохицуулалттай уялдах шаардлагатай тул ямар арга хэмжээг ямар байгууллага, ямар үндэслэлээр хэрэгжүүлэхийг тодорхой болгох шаардлагатай байна.

Хүүхдийн цахим боловсрол, эцэг эхийн оролцоо, урьдчилан сэргийлэх сургалт, платформын өөрийн зохицуулалт зэрэг урьдчилан сэргийлэх бодлогын арга хэмжээнээс илүү хориглох болон хязгаарлах зохицуулалт давамгайлсан байна. Олон улсын туршлагаас харахад хүүхдийг цахим орчноос бүрэн тусгаарлах бус, аюулгүй хэрэглээний боловсрол олгох, эрсдэлээс хамгаалах ур чадвар эзэмшүүлэх бодлого илүү үр дүнтэй гэж үздэг тул энэ чиглэлийн зохицуулалтыг нэмэлтээр тусгах шаардлагатай байна.

Иймд уг хуулийн төсөл нь хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах зорилго, үзэл баримтлалын хувьд ач холбогдолтой боловч хүний эрхийн баталгаа, мэдээллийн эрх чөлөө, техник технологийн хэрэгжилтийн бодит нөхцөл, олон улсын платформын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нас баталгаажуулах механизм, хандалт хязгаарлах үндэслэл, төрийн байгууллагын бүрэн эрх, хүүхдийн эрх хамгаалах процесс зэрэг зохицуулалтыг илүү тодорхой, тэнцвэртэй боловсруулах шаардлагатай байна гэж үзэж байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.СОЛОНГО



БАТЛАВ:

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН**

Д.НАРАНБАЯР

2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

ТУС764 9023051393 9067164

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” хэмээн зааж, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг хуульчлан баталгаажуулсан бөгөөд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 24 дүгээр зүйлийн 1-д “Аливаа хүүхэд яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй” гэж, Хүүхдийн эрхийн тухай конвенц “хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай” талаар дурдаад, тус конвенцын 16 дугаар зүйлийн 1-д “Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй” гэж, 19 дүгээр зүйлийн 1-д “Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг эрх бүхий асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээг авна” гэж тус тус заасан байна.

Ийнхүү Монгол улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийн дагуу Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд тус хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэр бүлийн орчинд, хуулийн этгээд хуульд заасан эрх эдэлж, үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаална” гэж, 25.3-т “Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно” гэж тус тус хуульчилсан.

Мөн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7.1-д “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй” гэж, 7.3-т “Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, хувийн мэдээлэл, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.3.2-т “Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.5-д “Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ” гэж, 2.2.4.4-т “Хүүхэд, залуучуудыг сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт боловсруулж, мөрдөнө” гэж, 4.1.1.4-т “Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, цахим орчин дахь ялгаварлал, хүчирхийллээс хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлжээ.

Иймд дээрх хууль, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд нийгмийн сүлжээг ашиглахад хүүхдэд насны хязгаарлалт тогтоож, цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт, хариуцлагын үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

1.2. Практик шаардлага:

Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа (2020)-нд дурдсанаар 7-12 настай хүүхдүүдийн 50 хувь, 13-18 настны 77 хувь нь фейсбүүк хэрэглэдэг бөгөөд тэдгээрийн 87 хувь нь ямар нэг хэлбэрийн цахим халдлагад өртсөн байна.

Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам (2021) судалгаагаар өсвөр үеийнхний 92 хувь нь интернэт хэрэглэдэг бөгөөд хүүхдэд учрах эрсдэлд хамгийн их нөлөөтэй (68.2%) хүчин зүйлээр интернэт орчныг тодорхойлсон байна. Мөн судалгаанд оролцсон хүүхдүүдийн 14.6 хувь нь цахим орчинд хүчирхийлсэн, басамжилсан, садар самуун агуулгатай үйлдэл хийхийг тулгасан шаардлагад өртөж байжээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийсэн “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал ба зохицуулалт” (2021) судалгааны тайланд дурдсанаар судалгаанд оролцсон 13-18 насны нийт хүүхдийн 71 хувь нь өдөр бүр цахим орчинд давтамжтай нэвтэрдэг бөгөөд 96 хувь нь фейсбүүк, 89 хувь нь фейсбүүк мессенжер ашигладаг гэсэн байна. Мөн 13-18 насны хүүхдүүд гэртээ интернэтэд ороход аав, ээжийн эзгүйд орох хандлага өндөр буюу 89 хувьтай байна.

Цахим орчин дахь ялгаварлан гадуурхалтаас үүдэн хүүхдүүд өөртөө итгэлгүй болох, нийгмийн харилцаанд орохоос айж эмээх, улмаар амиа хорлох шалтгаан нөхцөлийг бий болгож байна. Мөн цахим орчинд бусадтай харилцаа тогтоож, улмаар гэмт хэргийн хохирогч болох тохиолдол ч нэмэгдсээр байна.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийн зөрчилд хамаарах зөрчлийг заасан ч цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн шинжтэй зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна. Цагдаагийн байгууллагын мэдээлэл, судалгаанаас үзэхэд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлээр 2015-2019 оны хооронд нийт 860 зөрчил бүртгэгдэж байсан бол 2024 онд 2192 болж нэмэгдсэн байна.

Орчин үеийн цахим технологийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудлаар олон улсын байгууллагууд ихээхэн анхаарал хандуулж, олон төрлийн арга хэмжээ зохион байгуулах болсон бөгөөд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас өмнө гаргасан "Цахим орчин дахь хүүхдийг хамгаалах тухай зөвлөмж"-ийг шинэчилж, "Цахим орчин дахь хүүхэд" гэсэн нэртэйгээр 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр дахин гаргасан байна.

Тус зөвлөмжийн зорилго нь нэг талаас хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах бол нөгөө талаас цахим орчноос хүүхдэд өгч болох боломж, ашиг тусыг дэмжих, энэ хоёр харилцан хамаарал бүхий хүчин зүйлийн хоорондын тэнцвэрийг бүрдүүлэхэд чиглэжээ. Шинэчлэгдсэн зөвлөмжид цахим орчны нарийн төвөгтэй байдлаас үүдэлтэйгээр хүүхдийн хувийн нууц, хувийн мэдээллийг хамгаалах хэрэгцээ, шаардлага нэн чухлаар тавигдаж байгааг хүлээн зөвшөөрч, олон талын оролцогчдын хүлээх үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна.

Манай улсын хувьд Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлээр хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалалтай холбоотой харилцааг зохицуулж байгаа боловч "цахим орчинд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах, цахим гэмт хэргээс тухайлбал, цахим орчин дахь бэлгийн хүчирхийлэл, зүй бус зар сурталчилгаа, хуурамч мэдээ, мэдээллээс хамгаалах, сөрөг агуулгатай контентын хандалтыг хязгаарлах, арилгахтай холбоотой цогц харилцааг тусгайлан зохицуулаагүй байна. Түүнчлэн, тодорхой насны хязгаарлалттайгаар нийгмийн сүлжээний платформыг ашиглах талаар хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна.

Австралийн Засгийн газар цахим орчин дахь сөрөг нөлөөллөөс хүүхдийг хамгаалах зорилгоор 2024 оны 11 дүгээр сард "Нийгмийн сүлжээний доод насны хязгаарыг тогтоох"-той холбоотой хуулийг баталсан бөгөөд 16-аас доош насны хүүхдийг нийгмийн сүлжээнд нэвтрэхийг хориглосон.

Тодруулбал, Австралийн хүүхдүүдийн 80 хувь нь Youtube, TikTok, Instagram, Snapchat зэрэг платформыг ашигладаг бөгөөд насны хязгаарлалтгүй, хяналтын механизм хангалтгүй зэргээс шалтгаалан насанд хүрээгүй хүүхэд аливаа шүүлтүүргүйгээр мэдээ, мэдээлэл авах, гэмт хэргийн хохирогч болж байгаа тул ийнхүү хуулиар зохицуулах арга хэмжээ авч буйгаа зарлажээ.

Тус хуулийн дагуу нийгмийн сүлжээний платформ хөгжүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд 16-аас доош насны хүүхдийг нэвтрүүлэхгүй, хаяг үүсгэхгүй

байх үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргээ биелүүлээгүй бол торгуулийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Нөгөө талаар энэ нь тухайн хүүхэд болон эцэг, эхэд ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй байх талаар мөн дурджээ.

Харин Франц Улсын хувьд 15-аас доош насны хэрэглэгч нийгмийн цахим сүлжээнд нэвтрэхэд заавал эцэг, эхийн зөвшөөрөл авахыг шаарддаг байна. Энэ мэтчилэн АНУ, Австрали, Япон, Итали, БНСУ, Швед, ОХУ, ИБУИНВУ, БНХАУ зэрэг улс орнууд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх бодлогоо тодорхойлж, нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудыг баталжээ.

Иймд дотоод хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд хүүхэд нийгмийн сүлжээний платформыг ашиглахад тодорхой насны хязгаар тогтоож, хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ мэдээлэл, зар сурталчилгаанд өртөхөөс сэргийлэх, цахим гадуурхал, дарамт зэрэг цахим орчны эрсдэлт нөхцөлд орохоос хамгаалах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.11-д "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамран батална" гэж заасны дагуу уг журмыг хожуу буюу 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталсан байх бөгөөд журмын хэрэгжилтийн талаарх мэдээлэл байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг захиргааны хэм хэмжээний акт гарган зохицуулахыг хязгаарлах бодлого баримталж байгаа энэ цаг үед дээрх асуудлыг журмаар бус хуулийн хүрээнд нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна.

Эдгээр практик нөхцөл, шалтгааны улмаас цахим орчинд хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахимаар урхихах, дээрэлхэх, дарамтлах зэргээр эрсдэлт нөхцөл өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хортой агуулгаас хүүхдийг хамгаалах, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн боловсруулах шаардлага үүсэж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн төслийн зорилго нь нийгмийн сүлжээнд 13 нас хүрээгүй хүүхдийг бүртгэхийг хориглох, 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдийг нийгмийн сүлжээний хэрэглээнээс үүдэлтэй эрүүл мэнд, сэтгэл зүй, хүмүүжил, төлөвшилд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил, халдлага болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсад хүүхдийн насны ангилалд үндэслэн нийгмийн сүлжээний хэрэглээнд технологийн хамгаалалтын зохицуулалт бий болгох эрх зүйн орчин одоогоор бүрдээгүй байгаа тул Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах

тухай хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл байх бөгөөд нийт 6 бүлэг, 20 зүйлээс бүрдэнэ.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт болон баримтлах зарчим, хоёрдугаар бүлэгт нийгмийн сүлжээний технологийн хамгаалалтын арга хэмжээ, зохицуулалттай нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээ, гуравдугаар бүлэгт эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, боловсролын сургалтын байгууллага, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгчийн эрх, үүрэг, дөрөвдүгээр бүлэгт төрийн байгууллагуудын чиг үүрэг, тавдугаар бүлэгт гомдол, мэдээлэл хүлээн авах, шилжүүлэх, зургаадугаар бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон бусад зохицуулалтыг тус тус тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх ба 13 нас хүрээгүй хүүхдийг нийгмийн сүлжээнд бүртгэхийг хориглож, 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлснээр хүүхдийг нийгмийн сүлжээнээс шалтгаалсан эрсдэл, зөрчил, халдлагад өртөхөөс сэргийлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал:

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй уялдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн сүлжээнд хүүхдийн
оролцоог зохицуулах тухай
хуулийн төслийн талаар*

Монгол Улсад хүүхдийн цахим орчин дахь оролцоо, нийгмийн сүлжээний хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд үүнийг дагаад хүүхдүүд цахим дарамт, цахим залилан, хувийн мэдээллийн зөрчил, зохисгүй агуулгад өртөх, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт холбогдох эрсдэл нэмэгдэж байна.

Өнөөгийн байдлаар хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байгаа боловч нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хүүхдийн нас баталгаажуулалт, нийгмийн сүлжээний хэрэглээ, аюулгүй байдал, хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалахтай холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Иймд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахим орчны сөрөг нөлөөлөл, дарамт, мөлжлөг, гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах, нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагыг тодорхой болгох зорилгоор Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийн хамт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн зорилт нь хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээтэй холбоотой харилцааг зохицуулах, хүүхдийг цахим дарамт, донтолт, заналхийлэл, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох, төрийн байгууллагуудын чиг үүрэг, хамтын ажиллагааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөл нь Монгол Улсад хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээг зохицуулах чиглэлээр боловсруулж буй анхдагч бие даасан хууль бөгөөд төслийг нийт 6 бүлэг, 20 зүйлтэйгээр боловсруулж, дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан.

Нэгдүгээр бүлэгт, Хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томьёог тодорхойлж, нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангахад баримтлах зарчмыг тусгасан.

Хоёрдугаар бүлэгт, Нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээ хийх, тус үнэлгээнд үндэслэн авч хэрэгжүүлэх хүүхдийн насны онцлогт тохирсон хамгаалалтын арга хэмжээг тодорхойлсон. Нийгмийн сүлжээний эрсдэлд

үндэслэн:

- 13-аас доош насны хүүхдийг нийгмийн сүлжээнд бүртгэл үүсгэхийг хориглох;
- 13-16 насны хүүхдэд насанд тохирсон зохистой хэрэглээний болон аюулгүй байдлын хамгаалалтын тохиргоотой ашиглуулах зохицуулалтыг тусгасан.

Дээрх технологийн хамгаалалтын арга хэмжээтэй уялдуулан хуулийн төслийн гуравдугаар бүлэгт нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангахад оролцогч дараах талуудын эрх, үүргийг тусгасан:

- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг;
- Боловсролын сургалтын байгууллагын чиг үүрэг;
- Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг;
- Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг;
- Нийгмийн сүлжээ хэрэглэгчийн эрх, үүрэг.

Дөрөвдүгээр бүлэгт, нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулж, аюулгүй байдлыг хангахад оролцогч төрийн эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон.

- Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг;
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг;
- Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэг.

Тавдугаар бүлэгт, нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдал зөрчигдсөн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг тусгасан.

Хуулийн төслийг боловсруулахтай холбоотойгоор холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улсын туршлагыг харьцуулан судалж, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамтай хамтран дараах судалгаа, хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа. Үүнд:

1. Хүүхэд, эцэг эх асран хамгаалагч, мөн багш, нийгмийн ажилтан, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдээс нийт 11,234 оролцогчийг хамруулсан 4 бүлгийн судалгаа;
2. Олон улсын туршлага, хэм хэмжээ, нийтлэг стандарт болон гадаад орны хууль, эрх зүйн харьцуулсан судалгаа;
3. Улаанбаатар хотын 9 дүүргийн сургуулийн 13-16 насны 1100 гаруй сурагчдын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг;
4. Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 175 сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нарын төлөөлөл болох 3,000

гаруй оролцогчийг хамруулсан хэлэлцүүлэг;

5. Орон нутгийн төрийн өмчийн 542 ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нарын төлөөлөл аймаг, сумдын төв цэгүүдээс нэгдэн оролцсон хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан.

Мөн Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэхээр боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын D.PARLIAMENT.MN цахим сүлжээнд иргэд, олон нийтийн саналыг авахаар байршуулсан бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус цахим хуудсаар дамжуулан 660 иргэн танилцжээ. Түүнчлэн хуулийн төсөлд Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбооноос санал авахаар хүргүүлж, ирсэн саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх саналын товъёог бэлтгэн хавсаргасан болно.

Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын дунд явуулсан судалгаанаас үзэхэд судалгаанд оролцсон нийт хүүхдийн 46 хувь нь өдөрт 2–4 цаг, 30 хувь нь 4 болон түүнээс дээш цаг интернэт ашигладаг. Интернэт ашигладаг гол зорилго нь нийгмийн сүлжээнд нэвтрэх гэж нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 73 хувь нь хариулсан бол нийгмийн сүлжээнээс сөрөг захидал авч байсан эсэхэд 78 хувь нь тийм, хувийн мэдээллээ хамгаалах тохиргоо хэрэглэдэг эсэхэд 40 хувь нь үгүй болон тохиргооны талаар мэдэхгүй гэж тус тус хариулсан. Харин судалгаанд хамрагдсан эцэг, эх, асран хамгаалагч нараас хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавьдаг эсэхийг асуухад 40 хувь нь хяналт тавьдаг, 10 хувь нь огт хяналт тавьдаггүй, 50 хувь нь хааяа хяналт тавьдаг гэж хариулжээ. Мөн таны хүүхэд нийгмийн сүлжээнд дарамт, шахалтад өртөж байсан уу? гэсэн асуултад 43 хувь нь мэдэхгүй гэж тус тус хариулснаас дүгнэхэд нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, учирч болзошгүй аливаа эрсдэлээс хамгаалах асуудлыг хуульчилж зохицуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Монголын Хуульчдын холбоо болон Монголын Өмгөөлөгчдийн холбооноос тус хуулийн төслийг хүүхдийг цахим орчны эрсдэл, дарамт, зохисгүй агуулга, цахим гэмт хэргээс хамгаалах, нийгмийн сүлжээний орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилго дэвшүүлсэн нь өнөөгийн нийгмийн бодит хэрэгцээ, олон улсын чиг хандлагатай нийцэж байна гэж дүгнэн, хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа талаар санал ирүүлсэн нь тус хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг илэрхийлж байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр баталсан АНУ, Австрали, Япон, БНСУ, ОХУ, БНФУ, БНХАУ, Сингапур, Казакстан, Малайз, Норвеги, ХБНГУ, ИБУИНВУ, Эстони зэрэг улсын хууль тогтоомж, мөн олон улсын байгууллагуудаас гаргасан судалгаа, зөвлөмжүүдийг судалж хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан.

Олон Улсын Харилцаа Холбоо (ITU)-ны байгууллага “Хүүхдийг нийгмийн сүлжээнд хамгаалах удирдамж”¹-ийг 2020 онд шинэчлэн гаргасантай зэрэгцэн дээрх болон бусад улс, орнуудад нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулж, цахим хэрэглээг хязгаарлах, нийгмийн сүлжээнд хүүхдийн бүртгэлийг зохицуулах зэрэг эрх зүйн зохицуулалтуудыг бий болгож эхэлсэн байна. Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо 2021 онд Хүүхдийн эрхийн конвенцын ерөнхий тайлбар №25-ыг батлахдаа хүүхдийн эрхийг дижитал орчинд хэрхэн хамгаалах талаар дэлгэрэнгүй зааварчилгаа² оруулжээ. Үүнд хүүхдийг нийгмийн сүлжээнд аливаа хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хувийн нууцыг хадгалах, насанд нь тохирсон мэдээлэл, үйлчилгээ авах эрхийг хангах зэрэг асуудлыг хөндсөн байна.

Харин бусад улс орнуудын хувьд нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч /платформ/-ийн үйл ажиллагааны хүрээ, үйлчилгээний төрөл, хүүхдэд учруулж болзошгүй эрсдэлийн түвшинд үндэслэн ялгамжтай зохицуулалт хийх хандлага түгээмэл байна. Тухайлбал, Их Британийн Цахим аюулгүй байдлын хууль (Online Safety Act, 2023), Европын холбооны Цахим үйлчилгээний тухай хууль (Digital Services Act, 2022) болон Австралийн Цахим аюулгүй байдлын хууль (Online Safety Act, 2021)-д нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид эрсдэлийн үнэлгээ хийх, насны баталгаажуулалт хэрэглэх, хортой агуулга болон алгоритмын нөлөөллийг бууруулах, хүүхдэд ээлтэй аюулгүй тохиргоог анхнаас нь бий болгох үүрэг хүлээлгэж байна.

Иймд хуулийн төсөлд нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийг эрсдэлийн түвшнээр ангилах, эрсдэлийн үнэлгээнд суурилсан зохицуулалт хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалтыг тодорхойлон тусгасан.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөлтэй хамт дараах хуулиудад нэмэлт оруулахаар хуулийн төслүүдийг боловсрууллаа. Үүнд:

1. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр 13 нас хүрээгүй хүүхдэд нийгмийн сүлжээний бүртгэл үүсгэсэн бол нийгмийн сүлжээ эрхлэгч хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэсийг бүрдүүлэхээр тусгав.

2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр тус хуулийн 7 дугаар зүйл хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хэрэглэгчийг нэг удаа танин мэдэх зорилгоор мэдээлэл авч болохыг хуульчилав.

3. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөөр хуулийн зарим зохицуулалтын дагаж мөрдөх хугацааг үе шаттайгаар тогтоож, Монгол Улсаас нийгмийн сүлжээний хэрэглэгчийн

¹ https://www.itu.int/dms_pub/itu-s/opb/gen/S-GEN-COP.EDUC-2020-PDF-E.pdf

² General comment No. 25 (2021) on children's rights in relation to the digital environment | OHCHR

насыг баталгаажуулах ажлыг зохион байгуулах хугацааг тодорхойлохоор тус тус тусгав.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар хүүхдийн мэдээллийн аюулгүй байдал сайжирч, цахим орчин дахь эрсдэл, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдэхийн зэрэгцээ нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, эцэг эх, асран хамгаалагчдын хариуцлага нэмэгдэж, хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоо боловсронгуй болох ач холбогдолтой.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй бөгөөд холбогдох байгууллагуудын одоогийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой юм.

-----oOo-----

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн сүлжээнд хүүхдийн
оролцоог зохицуулах тухай
хуулийн төслийн талаар*

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” хэмээн зааж, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг хуульчлан баталгаажуулсан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын¹ 24 дүгээр зүйлийн 1-д “Аливаа хүүхэд яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй.” гэж, Хүүхдийн эрхийн тухай конвенцын² удиртгалд “хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай.” талаар дурдаад, тус конвенцын 19 дүгээр зүйлийн 1-д “Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг эрх бүхий асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд аливаа хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээг авна.” гэж заасан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос 2021 онд баталсан “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх 25 дугаар Нэмэлт тайлбар” (General Comment No.25)-ын 23-т “Оролцогч улсууд нь цахим орчныг Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Нэмэлт тайлбарт заасан эрхтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийг шинэчилнэ.” гэж заасан ба хүүхдийн эрх цахим орчинд мөн адил бүрэн хэрэгжих бөгөөд улс орнууд хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах хууль, бодлогын тусгай зохицуулалт бүрдүүлэх үүрэгтэйг тодорхойлсон.

Тус тайлбар нь хүүхдийн хувийн мэдээллийн хамгаалалт, хүүхдэд ээлтэй нууцлалын анхдагч тохиргоо (privacy by default), насанд тохирсон хамгаалалтын механизм, хортой агуулга болон алгоритмын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, платформ буюу үйлчилгээ эрхлэгчийн хариуцлага, аюулгүй байдлыг системийн загварчлалд анхнаас нь шингээх (safety by design) зэрэг зарчмыг хэрэгжүүлэх

¹ Хүүхдийн эрхийн конвенц, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 44/25 дугаар тогтоолоор баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

² Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос 2021 онд баталсан “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25

шаардлагыг онцлон дурдсан. Мөн хүүхдийн хувьсан хөгжиж буй чадавхын зарчмын агуулгыг онцлон тусгасан бөгөөд энэ нь хүүхдийн ур чадвар, танин мэдэхүй, өөрийн үйлдлийн үр дагаврыг ойлгох чадвар нь нас, тархины хөгжлийн үе шат бүрээр аажмаар төлөвшдөг болохыг илэрхийлдэг. Нийгмийн сүлжээнд хүүхэд эцэг, эх, асран хамгаалагчийн шууд хяналтаас гадуур бие даан оролцох боломжтой байдаг тул хүүхдийн хөгжлийн онцлогийг энэ орчинд тусгайлан харгалзан үзэх шаардлагатай гэж тэмдэглэсэн.

Хүүхдийн цахим орчин дахь эрсдэл, боломж нь нас, хөгжлийн үе шатнаас хамааран харилцан адилгүй байдаг тул улс орнууд хүүхдийг хамгаалах болон цахим орчинд оролцоог нь дэмжих бодлого, арга хэмжээг боловсруулахдаа хүүхдийн нас, хөгжлийн онцлогийг харгалзан үзэх ёстой. Үүний зэрэгцээ, салбар бүрийн хамгийн сүүлийн үеийн судалгаа, нотолгоонд тулгуурлан хүүхдийн насны онцлогт нийцсэн хамгаалалтын арга хэмжээг боловсруулах шаардлагатайг онцолсон.³

Мөн Хүүхдийн эрхийн тухай конвенц болон түүний Нэмэлт протоколуудад заасан эрхийг цахим орчинд хангах зорилгоор оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжоо олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн тогтмол хянаж, шинэчилж байх үүрэгтэй. Хууль тогтоомж нь технологийн хурдацтай хөгжил, шинээр үүсэж буй нөхцөл байдлаас хоцрох ёсгүй бөгөөд цахим орчинтой холбоотой төрийн байгууллага, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд хүүхдийн эрхийн нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай гэж заасан. Энэ нь цахим орчинтой холбоотой хууль тогтоомж, төсвийн хуваарилалт, захиргааны шийдвэр бүрт хүүхдийн эрхийг тусгах, хамгаалах зорилготой юм.

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах харилцааг 1989 оны Хүүхдийн эрхийн конвенц зэрэг Монгол Улсын олон улсын гэрээ, мөн Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг дотоодын тодорхой хууль тогтоомжоор зохицуулж байна.

Монгол Улсад хэрэгжиж буй зохицуулалтууд нь олон улсын платформуудыг хариуцлагажуулах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх технологийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт хийгээгүй байна. Эдгээр нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг тандан судлах хүрээнд хийсэн судалгаанд дүгнэсэн нийгмийн сүлжээн дэх хүүхдэд чиглэсэн эрсдэл, сөрөг үр дагаврыг дагуулсаар байгаа нь тус хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлж байна.

³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооноос 2021 онд баталсан "Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25

Иймд Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль /анхдагч хууль/ -ийн төслийг 6 бүлэг, 20 зүйлтэйгээр боловсруулсан.

Нэр томъёоны тухайд:

“Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль” гэх нэр нь нэг талаас зохицуулалтын хамрах хүрээг хэт өргөсгөхөөс зайлсхийж, нөгөө талаас Хүүхэд хамгааллын тухай ерөнхий зохицуулалт бүхий хуулийн зохицуулах харилцаанаас ялган, хүүхдийн аюулгүй байдлыг хангах технологийн хамгаалалтын нарийвчилсан тогтолцоог хуульчлах зорилгыг илэрхийлнэ.

Энэ хуулийн төслийг анхлан боловсруулах хүрээнд “нийгмийн сүлжээ” гэх ойлголтоос өргөнөөр томъёолбол мэдээний сайт, цахим худалдаа, үүлэн үйлчилгээ, тоглоом, форум, хайлтын систем, боловсролын платформ зэрэг олон төрлийн үйлчилгээ хамаарах нөхцөл үүсгэдэг бөгөөд ингэснээр:

- хүүхдэд бодитоор өндөр эрсдэл учруулж буй үйлчилгээ рүү чиглэсэн бодлого сулрах;
- эрсдэлийн үнэлгээ, хяналт, тайлагналын тогтолцоо хэт олон субъектэд тархах;
- төрийн байгууллагад бодит хэрэгжилтээс давсан зохиомол ачаалал үүсэх;
- технологийн болон хүний нөөцийн хувьд хэрэгжүүлэх боломжгүй болох;
- платформын эрсдэлийн түвшинд суурилсан ялгамжтай зохицуулалт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх зэрэг сөрөг үр дагавар бий болдог гэж судлаачид, олон улсын байгууллагууд тэмдэглэсэн байдаг.⁴

Мөн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаанаас үзэхэд нийгмийн сүлжээ нь Монгол Улсад тулгамдаж буй асуудал, бодит эрсдэл үүсгэж буй нь тогтоогдсон байна. Иймээс хуулийн төслийн хүрээнд “нийгмийн сүлжээ” гэх ойлголтыг: “хэрэглэгч бүртгэл үүсгэн оролцох, өөрийн болон бусдын үүсгэсэн зураг, дүрс бичлэг, дуу, бичвэр зэрэг агуулгыг нийтлэх, түгээх, сэтгэгдэл бичих, хуваалцах, бүлэг үүсгэх, харилцах боломж олгодог цахим хэрэглүүр /аппликэйшн/, цахим хуудас болон түүнтэй адилтгах үйлчилгээ” гэж тодорхойлж байгаа нь хүүхдэд хамгийн өндөр эрсдэл дагуулдаг хэрэглэгч контент үүсгэх боломж (user-generated content), холбогдон харилцах боломж (interaction), алгоритмаар түгээх загварлчлал (algorithmic amplification) бүхий үйлчилгээний хэсгийг төвлөрүүлэн хамруулж буй давуу талтай. Харин “хүүхдийн аюулгүй байдлыг хангах” гэх томъёоллын тухайд энэ нь “хүүхдийн эрх”, “хүүхэд хамгаалал” гэх ерөнхий хүрээний зохицуулалтаас ялгах зорилготой ойлголт юм. Монгол Улсад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон гэмт хэрэг, зөрчилд холбогдох хууль тогтоомжуудаар хүүхдийн эрх, хамгааллын суурь зарчим, төрийн байгууллагын бүрэн эрх, гэр бүл, боловсрол, нийгмийн хамгааллын харилцааг

⁴ UNICEF, *Child Rights Impact Assessment in the Digital Environment* (2022); OECD, *Children in the Digital Environment* (2021); European Commission, *Better Internet for Kids Strategy* (BIK+) (2022).

ерөнхий байдлаар зохицуулсан.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь хүүхдийн эрх зөрчсөн үйлдлийг дахин тодорхойлох, эсхүл материаллаг хариуцлагын шинэ тогтолцоо бий болгоход бус нийгмийн сүлжээний үйлчилгээний технологийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүрэг, урьдчилан сэргийлэх хамгаалалтын механизм, эрсдэлийн удирдлагын тогтолцоог нарийвчлан зохицуулахад чиглэж байгаа болно.

Тодруулбал, хуулийн төсөл нь:

- нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээ;
- аюулгүй байдлын анхдагч тохиргоо;
- эцэг эхийн хяналтын тохиргоо;
- хүүхдийн нас баталгаажуулалт;

• мэдээлэх, гомдол гаргах механизм гэх зэрэг хүүхдэд зориулсан технологийн хамгаалалтын арга хэмжээ, нийгмийн сүлжээний үйлчилгээний аюулгүй ажиллагааны “system design” болон “safety-by-design” зохицуулалтыг төвлөрүүлэн хуульчлах зорилготой.

Иймд энэхүү хуулийн төсөл нь материаллаг эрх зүйн хориглолт, хариуцлагын зохицуулалтыг давхардуулахгүйгээр, харин хүүхдэд эрсдэл учруулах нөхцөл, орчин, технологийн архитектурыг бууруулах урьдчилан сэргийлэх чиглэлийн тусгайлсан зохицуулалтын шинжтэй болно.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах хуулийн зорилго болон нэр томъёог тодорхойлсон.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын зарчим болон нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангахад баримтлах дараах зарчмуудыг тодорхойлсон.

Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих зарчим:

Энэхүү зарчим нь хүүхэдтэй холбоотой аливаа хууль тогтоомж, бодлого, захиргааны болон хувийн байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд хүүхдийн эрх, аюулгүй байдал, хөгжил, сайн сайхан байдлыг нэн тэргүүнд харгалзан үзэх олон улсын хүүхдийн эрхийн суурь зарчим юм. Энэхүү зарчмыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүүхдийн талаар хэрэгжүүлэх төрийн болон хувийн нийгмийн хамгааллын байгууллага, шүүх, захиргааны байгууллага, хууль тогтоох байгууллагын аливаа үйл ажиллагаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг (best interests of the child) нэн тэргүүнд харгалзан үзнэ”⁵ гэж тодорхойлсон.

⁵ Хүүхдийн эрхийн конвенц, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 11 дүгээр сарын 20 -ны өдрийн

Хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ авах зарчим: Энэ зарчим нь нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч болон холбогдох этгээдээс авч хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээ нь хүүхдийн эрх, мэдээлэл авах эрх чөлөө болон технологийн хэрэглээнд хэт халдахгүйгээр, тухайн эрсдэлийн шинж чанар, түвшинд нийцсэн, зайлшгүй бөгөөд пропорциональ байх шаардлагыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл хамгаалалтын арга хэмжээ нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилготой уялдсан, үндэслэлтэй, хэрэгжих боломжтой байхыг шаардана.

Эрсдэлээс сэргийлсэн байх зарчим: Энэхүү зарчмын хүрээнд нийгмийн сүлжээний үйлчилгээ, түүний функц, агуулга, хэрэглэгчийн харилцаа, алгоритмын ажиллагаанаас хүүхдэд учирч болзошгүй эрсдэлийн түвшинг үнэлж, түүнд тохирсон хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалтын тогтолцоог баримтална. Ингэснээр бүх үйлчилгээнд ижил түвшний хатуу шаардлага тавих бус, хүүхдэд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн бодит түвшинд үндэслэн ялгамжтай зохицуулалт хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах зарчим: Энэ зарчим нь хүүхдийн бүртгэл, байршил, харилцаа холбоо, хэрэглээний мэдээлэл болон бусад хувийн мэдээллийг хууль бусаар цуглуулах, ашиглах, түгээх, боловсруулах эрсдэлээс хамгаалах суурь шаардлагыг тогтоож буй. Түүнчлэн хүүхдэд зориулсан аюулгүй байдлын анхдагч тохиргоо (privacy-by-default), өгөгдлийн минималчлал, насны онцлогт тохирсон мэдээллийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Хамтын оролцоог хангах зарчим: Хүүхдийн нийгмийн сүлжээний аюулгүй байдлыг хангах асуудал нь зөвхөн төрийн байгууллагын дангаараа хэрэгжүүлэх чиг үүрэг биш бөгөөд нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, эцэг эх, асран хамгаалагч, боловсролын байгууллага, иргэний нийгэм, хүүхэд өөрөө болон бусад оролцогч талуудын хамтын оролцоонд тулгуурлан хэрэгжих шаардлагатай тул энэхүү зарчмыг тусгасан болно. Энэ нь урьдчилан сэргийлэлт, мэдээлэл солилцоо, гомдол шийдвэрлэлт, хүүхдийн цахим боловсрол болон хамгаалалтын тогтолцоог илүү үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болно.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль тогтоомжийн эрэмбэ, түүнийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасан. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах хангах тухай хуулиар зохицуулаагүй хүүхэд хамгааллын харилцааг Хүүхэд хамгааллын тухай хуулиар зохицуулна.

Хоёрдугаар бүлэг. Нийгмийн сүлжээний эрсдэл ба хамгаалалт

Хуулийн төслийн хоёрдугаар бүлгээр нийгмийн сүлжээний үйлчилгээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах технологийн хамгаалалтын арга хэмжээ, эрсдэлийн үнэлгээний зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төслийн хүрээнд нийгмийн сүлжээний үйлчилгээ бүр ижил түвшний эрсдэлтэй гэж үзэхгүй бөгөөд үйлчилгээний онцлог, хэрэглэгчийн оролцоо, түгээгдэж буй агуулга, алгоритмын ажиллагаа зэрэг хүчин зүйлээс шалтгаалан хүүхдэд үзүүлэх эрсдэлийн түвшин харилцан адилгүй байна гэж үзсэн. Иймд эрсдэлийн түвшинд суурилсан оновчтой зохицуулалт хэрэгжүүлэх зорилгоор “зохицуулалттай нийгмийн сүлжээ” гэх томъёоллыг хийж, хүүхдэд өндөр эрсдэл учруулж болзошгүй үйлчилгээний хувьд тусгай хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан.

Энэ хүрээнд 13 насанд хүрээгүй хүүхэд нийгмийн сүлжээ ашиглах, бүртгэл үүсгэхгүй байх зохицуулалтыг тусгаж, 13–16 насны хүүхдийн хэрэглээнд зориулсан технологийн хамгаалалтын арга хэмжээг хуульчилсан.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөлд **13 болон 13-16 нас хүрээгүй хүүхэд** гэж насны хязгаар тогтоосон нь хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах, насанд тохироогүй мэдээлэл, үйлчилгээ, цахим дарамт, мөлжлөг, гэмт хэрэг, хувийн мэдээллийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэрэгцээ, шаардлагаас үүдэлтэй.

АНУ-ын Үндэсний сэтгэцийн эрүүл мэндийн хүрээлэн (National Institute of Mental Health)-ийн судалгаагаар 13 насанд хүрээгүй хүүхдийн тархины хөгжил, танин мэдэхүй, өөрийгөө хянах болон эрсдэлийг үнэлэх чадвар бүрэн төлөвшөөгүй байдал нь хүүхдийн шийдвэр гаргалт, импульс хянах, урт хугацааны үр дагаврыг тооцоолох үүрэгтэй тархины урд хэсэг (prefrontal cortex)-ийн хөгжил өсвөр насны сүүл үе хүртэл үргэлжилдэг бол шагнал, сэтгэл хөдлөлийн хариу урвалтай холбоотой лимбик систем илүү эрт идэвхждэг байна.⁶ Үүний улмаас бага насны хүүхэд допамины өдөөлтөд суурилсан урамшууллын механизм (dopamine-based reward system)-аар ажилладаг лайк дарах (like), хуваалцах (share), хязгааргүй үзэх (endless scroll), алгоритмын санал болголтын арга (algorithmic recommendation) зэрэг донтуулах шинжтэй платформын нөлөөнд өртөмтгий, цахим дарамт, итгэл олж авах замаар бэлгийн хүчирхийлэлд татан оруулах үйлдэл (grooming), хортой агуулга, хувийн мэдээлэл алдах эрсдэлийг бодитоор үнэлэх чадвар сул байдаг.⁷ АНУ-ын COPPA зохицуулалт нь 13 наснаас доош хүүхдийн хувийн мэдээллийг эцэг эхийн зөвшөөрөлгүй цуглуулахад тусгай шаардлага тавьдаг бөгөөд өнөөдрийн олон платформын 13 насны босго үүнтэй холбоотойгоор тогтсон байдаг.⁸

Харин 13–16 насны хүүхдийн хувьд нийгмийн сүлжээг бүрэн хориглох нь хүүхдийн мэдээлэл авах, боловсрол эзэмших, үзэл бодлоо илэрхийлэх, нийгмийн оролцоонд оролцох болон харилцах эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж олон улсын байгууллага, судлаачид үздэг.⁹

Австрали улс 16-аас доош насны хүүхдийн нийгмийн сүлжээний

⁶ National Institute of Mental Health, The Teen Brain: 7 Things to Know, 2024.

⁷ UNICEF, Policy Brief on Online Platform Regulation and Child Safety, 2025.

⁸ Federal Trade Commission, Children's Online Privacy Protection Rule (COPPA), 1998.

⁹ UNICEF, Policy Guidance on AI for Children and Child Rights in the Digital Environment, 2021–2024., United Nations Committee on the Rights of the Child, General Comment No.25 (2021) on children's rights in relation to the digital environment, 2021.

хэрэглээг бүрэн хаах зохицуулалт хэрэгжүүлсэн боловч практик хэрэгжилтийн явцад хүүхдүүд VPN, эцэг эхийн бүртгэл, нас баталгаажуулалтыг тойрох бусад арга ашиглан хаалтыг төвөггүй давж байгаа талаар судалгаа, тайлан гарсаар байна. Тухайлбал 2026 онд хийгдсэн судалгаагаар 12–15 насны хүүхдийн 60 гаруй хувь нь хориг хэрэгжсэний дараа ч нийгмийн сүлжээг VPN болон бусад аргаар үргэлжлүүлэн ашиглаж, хязгаарлалтыг тойрон гарч байгааг тэмдэглэсэн байна.¹⁰ Мөн Австралийн болон олон улсын судлаачид насны хатуу хориг нь дангаараа үр дүнтэй хамгаалалт болж чадахгүй, харин хүүхдүүдийг илүү зохицуулалтгүй, эрсдэлтэй орчин руу шилжүүлэх, эсхүл онлайн орчинд учирсан эрсдэлийн талаар мэдээлэхээс айх нөхцөл үүсгэж болзошгүйг анхааруулжээ.

11

Түүнчлэн хүүхэд, өсвөр насныхны хувьд нийгмийн сүлжээ нь зөвхөн эрсдэл бүхий орчин бус, харилцаа, дэмжлэг, сэтгэл зүйн тусламж авах хэрэгсэл болдог талаар судалгаанд дурдсан. Австралийн Хүүхдийн тусламжийн үйлчилгээний төв (Kids Helpline) болон сэтгэл зүйн байгууллагуудын мэдээлснээр зарим өсвөр насныхан нийгмийн сүлжээний хоригийн дараа дэмжлэг авдаг орчноосоо тусгаарлагдаж, сэтгэл гутрал, амиа хорлох бодолтой холбоотой хямралын шинжтэйгээр тусламж хүссэн тохиолдлууд бүртгэгдсэн байна.¹² Иймд олон улсын чиг хандлага нь нийгмийн сүлжээг бүрэн хориглох арга хэмжээнээс илүүтэйгээр платформын аюулгүй загварчлалын шаардлага, алгоритмын зохицуулалт, насанд тохирсон хамгаалалтын тохиргоо, эцэг эхийн оролцоо, сэтгэл зүйн дэмжлэг болон цахим боловсролыг хамтад нь хэрэгжүүлэх “эрсдэлд суурилсан, тэнцвэртэй зохицуулалт”-д чиглэж байна.¹³

Харвардын их сургуулийн Хүүхдийн хөгжлийн төв (Harvard Center on the Developing Child)-ийн судалгаагаар 13–16 насанд хүүхдийн нийгмийн оролцоо, харилцаа, мэдээлэл авах, суралцах, өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ эрчимтэй нэмэгддэг боловч тархины өөрийгөө хянах, сэтгэл хөдлөлөө зохицуулах, нийгмийн дарамтыг даван туулах чадвар бүрэн төлөвшөөгүй хэвээр байдаг байна.¹⁴ Судалгаагаар өсвөр насныхан “peer validation” буюу бусдын үнэлэмжид илүү мэдрэмтгий байдаг тул алгоритмаар эрчимтэй түгээх (algorithmic amplification), бусадтай өөрийгөө харьцуулах (social comparison), донтуулах шинжтэй хэрэглээний загварчлал (addictive engagement design)-ын нөлөөнд илүү өртөмтгий байдаг гэж үздэг.¹⁵ Иймээс Европын холбооны Цахим үйлчилгээний тухай хууль (Digital Services Act, 2022) нь насанд хүрээгүй хэрэглэгчид ашиглах боломжтой платформд “өндөр түвшний нууцлал, аюулгүй байдал, хамгаалалт” хангах үүргийг хуульчилж, хүүхдэд чиглэсэн хэрэглэгчийн зан төлөвт суурилсан сурталчилгаа, алгоритмыг хориглосон байна.

Иймд 13–16 насанд нийгмийн сүлжээг ашиглуулах, аюулгүй байдлын

¹⁰ Molly Rose Foundation, Survey on Australia’s Under-16 Social Media Restrictions, 2026; Fortune, Australian teens say social media ban is futile and look to VPNs, 2026.

¹¹ Scott J. Fatt C Jasmine Fardouly, Debate: Social media in children and young people – time for a ban Child

¹² Molly Rose Foundation, Written Evidence Submitted to UK Parliament on Social Media Ban Risks, 2026.

¹³ UNICEF, Child Rights in the Digital Environment; United Nations Committee on the Rights of the Child, General Comment No.25, 2021.

¹⁴ Harvard Center on the Developing Child, Brain Development During Adolescence, 2024.

¹⁵ National Library of Medicine, Social Media and Adolescent Mental Health, 2025.

анхны тохиргоо, танихгүй хүнтэй холбогдох боломжийг хязгаарлах болон байршил хуваалцах тохиргоог идэвхгүй болгох, хориотой, хүүхдэд хортой агуулгыг харуулахгүй байх, эцэг эхийн хяналт, алгоритмын эрсдэлийг бууруулах гэх зэрэг хамгаалалтын арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд 13–16 насны хүүхдийн хэрэглээнд зориулсан технологийн хамгаалалтын дараах арга хэмжээг хуульчилсан:

- эцэг, эх, асран хамгаалагчийн хяналтын боломж;
- хүүхдийн хувийн мэдээлэл, байршлын нууцлалыг хамгаалах анхдагч тохиргоо;
- хориотой, хүүхдэд хортой агуулгын харагдац, түгээлт, алгоритмын санал болголтыг хязгаарлах;
- танихгүй хэрэглэгчтэй харилцах болон шууд дамжуулалтын боломжийг хязгаарлах;
- мэдээлэх, гомдол гаргах, агуулгыг хаах технологийн механизм;
- хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн бусад хамгаалалтын арга хэмжээ зэрэг “safety-by-design” зарчимд суурилсан хамгаалалтын тогтолцоог хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Мөн дээрх зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор нас баталгаажуулалтын арга, хэрэгслийг ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Хуулийн төсөлд нийгмийн сүлжээний үйлчилгээний эрсдэлийг үнэлэх тогтолцоог тусгайлан зохицуулж, хэрэглэгчийн цар хүрээ, системийн загварчлал, агуулгын шинж, хэрэглэгч хоорондын шууд харилцааны боломж, мэдээлэл түгэх механизм, гомдол шийдвэрлэлтийн үр нөлөө зэрэг хүчин зүйлд үндэслэн үнэлгээ хийхээр тусгасан. Энэхүү үнэлгээнд үндэслэн хүүхдэд өндөр эрсдэлтэй үйлчилгээний жагсаалтыг тогтоож, зохицуулалттай нийгмийн сүлжээний ангилалд хамруулан хамгаалалтын нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Гуравдугаар бүлэг. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангахад оролцогчдын эрх, үүрэг

Хуулийн төслийн гуравдугаар бүлгээр хүүхдийн нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах хүрээнд оролцогч талуудын эрх, үүрэг, хамтын оролцооны тогтолцоог зохицуулсан.

Хуулийн төсөлд хүүхдийн нийгмийн сүлжээний оролцоо, аюулгүй байдлыг зөвхөн төрийн байгууллагын чиг үүрэг гэж үзэхгүй бөгөөд эцэг эх, боловсролын байгууллага, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгчийн хамтын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувьд хүүхдийн насны онцлогт нийцүүлэн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавих, эрсдэлээс

урьдчилан сэргийлэх, аюулгүй хэрэглээний мэдлэг олгох үүргийг тодорхойлсон. Үүний хүрээнд:

- хүүхдийн ашиглаж буй нийгмийн сүлжээний үйлчилгээний талаар мэдлэгтэй байх;
- хүүхдэд цахим орчны аюулгүй хэрэглээний боловсрол олгох;
- эцэг эхийн хяналтын хэрэгсэл (parental control) болон 18+ контентын шүүлтүүр ашиглах;
- хүүхдийн хэрэглээнд хяналт тавих;
- хориотой, хүүхдэд хортой агуулга болон хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдлыг мэдээлэх зэрэг урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн хүүхдийн нас баталгаажуулах харилцаа холбооны дугаарыг ашиглуулахыг хориглосон нь нас баталгаажуулалтын тогтолцоог бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Боловсролын сургалтын байгууллагын тухайд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид нийгмийн сүлжээний эрсдэл, аюулгүй хэрэглээ, хувийн мэдээллийн хамгаалалттай холбоотой мэдлэг, ур чадвар олгох урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн боловсролын байгууллага нь сургалтын үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөнөөс бусад нийгмийн сүлжээ ашиглахыг хориглосон нь боловсролын орчны мэдээллийн аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой.

Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хувьд хүүхдийн аюулгүй байдлыг хангах технологийн болон зохион байгуулалтын үүргийг тодорхой тусгасан.

Түүнчлэн нас баталгаажуулах зорилгоор ашигласан мэдээллийг нэн даруй устгах, гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглосон нь хүүхдийн хувийн мэдээллийн хамгаалалтыг хангах чухал зохицуулалт болсон.

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн тухайд хүүхдийн нас баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, насны бүлгийн өгөгдлийг хүний хувийн мэдээллийг тодорхойлох боломжгүй хэлбэрээр дамжуулах, нас баталгаажуулах үйл ажиллагаанд хамтран ажиллах чиг үүргийг тусгасан. Энэхүү зохицуулалт нь хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах болон нас баталгаажуулах тогтолцоог техникийн түвшинд хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа юм.

Түүнчлэн нийгмийн сүлжээ хэрэглэгчийн эрх, үүргийг тодорхойлж, хориотой, хүүхдэд хортой агуулгын талаар мэдээлэх, өөрийн бүртгэл болон хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хориотой агуулга нийтлэхгүй, түгээхгүй байх үүргийг тусгасан. Ингэснээр хүүхдийн нийгмийн сүлжээний аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн төрийн хяналт бус, олон талт оролцоонд суурилсан хамтын хариуцлагын тогтолцоогоор хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж

байгаа болно.

Дөрөвдүгээр бүлэг.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах талаар төрийн байгууллагын чиг үүрэг

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлгээр нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагын чиг үүрэг, салбар дундын хамтын ажиллагааны тогтолцоог зохицуулсан.

Хуулийн төсөл нь хүүхдийн нийгмийн сүлжээний аюулгүй байдлыг зөвхөн нэг байгууллагын хариуцах асуудал бус, харин цахим хөгжил, боловсрол, хүүхэд хамгаалал, харилцаа холбоо зэрэг олон салбарын уялдаа холбоотой бодлого, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Иймд төрийн байгууллагуудын чиг үүргийг харилцан уялдаатай, давхардалгүйгээр тодорхойлон тусгасан болно.

Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн сүлжээний болон харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайд сургуулийн орчин дахь нийгмийн сүлжээний аюулгүй хэрэглээний бодлого, журмыг батлах, сургалтын хөтөлбөрт нийгмийн сүлжээн дэх аюулгүй байдлын агуулгыг үе шаттай тусгах, зөвшөөрөгдөөгүй нийгмийн сүлжээний хэрэглээг хязгаарлах, боловсролын зориулалтын программ хангамжийг нэвтрүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү зохицуулалт нь боловсролын орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг системтэйгээр хангах зорилготой юм.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, нийгмийн сүлжээнээс үүдэлтэй эрсдэлд судалгаа, дүн шинжилгээ хийх, үйлчилгээний стандарт боловсруулах, олон улсын санаачилгад нэгдэх зэрэг бодлогын болон салбар дундын зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн холбогдох салбарын мэргэжилтнийг чадавхжуулах сургалтын тогтолцоог бүрдүүлэхээр зохицуулсан болно.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд, эцэг эх, олон нийтэд зориулсан урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөмж, цахим ур чадварын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийн улсын байцаагчийг арга зүйгээр хангах, эрсдэлийн судалгаа хийх, нийгмийн сүлжээнд эрх нь зөрчигдсөн хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг практик хэрэгжилтийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь зохицуулалттай нийгмийн

сүлжээний үйлчилгээ эрхлэгчдийн хуульд заасан үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, эрх бүхий байгууллагын шийдвэрт үндэслэн шаардлагатай технологийн арга хэмжээ авах, шийдвэр, мэдэгдлийг үйлчилгээ эрхлэгчид шуурхай хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү зохицуулалт нь хууль хэрэгжилтийн технологийн хяналтын механизмыг тодорхой болгож байгаа юм.

Энэхүү бүлгээр нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудлыг салангид бус, харин төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо, хамтын ажиллагаанд тулгуурласан нэгдсэн тогтолцоогоор хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн болно.

Тавдугаар бүлэг. Гомдол, мэдээлэл гаргах, хянан шийдвэрлэх ажиллагаа

Хуулийн төслийн тавдугаар бүлгээр нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдал зөрчигдсөн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг тусгасан.

Зургадугаар бүлэг. Бусад зүйл

Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийн дэлгэрэнгүй тайлбар

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөлтэй хамт Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

1. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулиар насны хязгаар тогтоох, насны хязгаартай хэрэглэгчийг танин мэдэх, хуульд хориглосон этгээдийг нийгмийн сүлжээнд нэвтрүүлэхгүй байх үүргийг нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид хүлээлгэхээр байна. Гэвч уг үүргийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхой бус байвал хууль хэрэгжих боломж сулрах, үйлчилгээ эрхлэгчид насны хязгаарын шаардлагыг үл биелүүлэх нөхцөл үүсэх эрсдэлтэй.

Одоогийн Зөрчлийн тухай хуульд 13 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэсэн нийгмийн сүлжээ эрхлэгчид хариуцлага хүлээлгэх тусгай зохицуулалт тусгагдаагүй байна. Иймээс Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах шаардлага тулгарч байна.

Энэ хүрээнд 13 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэсэн бол насны хязгаартай нийгмийн сүлжээ эрхлэгч хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,

хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Ингэснээр нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид хүүхдийн насыг шалгах, насны хязгаарыг мөрдүүлэх, хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг бодитоор хэрэгжүүлэх хөшүүрэг бий болно.

Хуулийн төсөл батлагдсанаар насны хязгаартай нийгмийн сүлжээнд 13 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэх зөрчилд оногдуулах хариуцлага тодорхой болж, хүүхдийг насанд тохироогүй цахим орчноос хамгаалах, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчдийн хариуцлагыг дээшлүүлэх, Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах эрх зүйн нөхцөл бүрдэнэ.

2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулж, аливаа эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангахад насны баталгаажуулалт хийх, хүний хувийн мэдээлэл ашиглах, нөгөө талаар хүний хувийн мэдээллийг хамгаалах зайлшгүй шаардлагатай. Иймд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулж, дээрх асуудлыг шийдвэрлэхээр хуулийн төсөл боловсруулсан болно. Ийнхүү Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр тус хуулийн 7 дугаар зүйл хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хэрэглэгчийг нэг удаа танин мэдэх зорилгоор мэдээлэл авч болохыг хуульчилав.

3. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх бэлтгэл ажлыг тодорхой зохицуулах шаардлага үүснэ. Тухайлбал, хүүхэд ашиглаж буй нийгмийн сүлжээний орчин олон улсын болон дотоодын олон төрлийн платформоос бүрдэж, үйлчилгээ үзүүлэгчийн байршил, эрх зүйн хэлбэр, хэрэглэгч танин мэдэх технологийн боломж харилцан адилгүй байгаа нь хуулийг шууд хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл үүсгэж болзошгүй байна.

Иймд Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөр Монгол Улсаас нийгмийн сүлжээний хэрэглэгч нар насны баталгаажуулалт хийх, насны баталгаажуулалт хийхэд оролцох харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч болон бусад холбогдох байгууллагууд бэлтгэл ажил хангахтай холбоотой заалтыг хуульчилж оруулсан.

Мөн хуулийн хэрэгжилт эхлэхээс өмнө нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид насны хязгаартай хэрэглэгчийг танин мэдэх, хориглосон этгээдийг өөрийн сүлжээнд нэвтрүүлэхгүй байх техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авсан байх нь зүйтэй. Энэ нь хууль хэрэгжиж эхэлмэгц хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалт бодитоор хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдаж, холбогдох төрийн байгууллага, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагааны уялдаа сайжирч, насны хязгаар тогтоох болон хүүхдийг цахим орчинд хамгаалах арга хэмжээ хууль хэрэгжихээс өмнө бүрдэнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ **/Анхдагч хууль/**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон харилцаанд хамаарна.

3.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хэрэглэгчид нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлж буй этгээд нь энэхүү хуулийг нэгэн адил дагаж мөрдөнө.

3.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин сууж байгаа хүүхэд Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

3.4.Энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“зохицуулалттай нийгмийн сүлжээ” гэж энэ хуульд заасан хүүхдийн аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын шаардлагыг хангаагүй, эсхүл шаардлагыг хэрэгжүүлж байгаа боловч хүүхдийн аюулгүй байдалд учруулах эрсдэлийн түвшин өндөр гэж тогтоогдсон нийгмийн сүлжээг;

4.1.2.“насны баталгаажуулалт” гэж хэрэглэгчийн насыг итгэмжлэгдсэн эх сурвалжийн өгөгдөлд үндэслэн үйлчилгээ авах насны босгыг хангаж буй эсэхийг технологийн арга хэрэгслийг ашиглан баталгаажуулах цогц үйл ажиллагааг;

4.1.3.“нийгмийн сүлжээ” гэж хэрэглэгч бүртгэл үүсгэн оролцох, өөрийн болон бусдын үүсгэсэн зураг, дүрс бичлэг, дуу, бичвэр зэрэг агуулгыг нийтлэх, түгээх, сэтгэгдэл бичих, хуваалцах, бүлэг үүсгэх, харилцах боломж олгодог цахим хэрэглүүр /аппликэйшн/, цахим хуудас болон түүнтэй адилтгах үйлчилгээг;

4.1.4.“нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч” гэж энэ хуулийн 4.1.3-т заасан үйлчилгээг нийтэд санал болгож буй этгээдийг;

4.1.5.“харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч” гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.4-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийг;

4.1.6.“хориотой агуулга” гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.15-д заасан агуулгыг;

4.1.7.“хүүхдэд хортой агуулга” гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.16-д заасан агуулгыг;

4.1.8.“эцэг эхийн хяналтын хэрэгсэл” гэж хүүхдийн нийгмийн сүлжээний зохистой хэрэглээг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ашиглах хандалтын хязгаарлалт, зохицуулалт болон шүүлтүүр бүхий техникийн шийдлийг.

5 дугаар зүйл.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангахад баримтлах зарчим

5.1.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангахад дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;

5.1.2.хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ авах;

5.1.3.эрсдэлээс сэргийлсэн байх;

5.1.4.хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах;

5.1.5.хамтын оролцоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ ХАМГААЛАЛТ БА ЭРСДЭЛ

6 дугаар зүйл. Технологийн хамгаалалтын арга хэмжээ

6.1.Нийгмийн сүлжээнд энэ хуульд заасан урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.Нийгмийн сүлжээг 13 насанд хүрээгүй хүүхдэд ашиглуулахыг хориглоно.

6.3.Нийгмийн сүлжээнд 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд дараах урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.3.1.хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээ, түүний хугацаа эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хяналт тавих боломжийг бүрдүүлэх;

6.3.2.хүүхдийн хувийн мэдээлэл, байршил болон бүртгэлийн нууцлалыг хамгаалах анхдагч тохиргоо хэрэгжүүлэх;

6.3.3.хориотой, хүүхдэд хортой агуулгын харагдац, түгээлт, санал болгох алгоритмыг хязгаарлах;

6.3.4.танихгүй хэрэглэгчээс шууд зурвас хүлээн авах боломжийг хязгаарлах;

6.3.5.хориотой, хүүхдэд хортой агуулгыг мэдээлэх, гомдол гаргах, хаах технологийн боломжийг бүрдүүлэх;

6.3.6.хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн бусад технологийн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх.

6.4.Энэ хуулийн 6.2, 6.3-т заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор насны баталгаажуулалт хийнэ.

7 дугаар зүйл.Зохицуулалттай нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээ

7.1.Харилцаа холбооны зохицуулах хороо нь хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд үндэслэн нийгмийн сүлжээн дэх хүүхдийн аюулгүй байдалд учруулж болзошгүй эрсдэлийн түвшнийг тогтоох зорилгоор эрсдэлийн үнэлгээ зохион байгуулна.

7.2.Энэ хуулийн 7.1-т заасан үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж тогтоогдсон нийгмийн сүлжээг зохицуулалттай нийгмийн сүлжээнд хамааруулна.

7.3.Зохицуулалттай нийгмийн сүлжээний эрсдэлийн түвшнийг тогтоохдоо дараах шалгуурыг харгалзан үзнэ:

7.3.1.хэрэглэгчийн цар хүрээ;

7.3.2.системийн загварчлал, ажиллах зарчим;

7.3.3.түгээгдэж буй агуулгын шинж;

7.3.4.танихгүй хүнтэй шууд харилцах боломж;

7.3.5.мэдээлэл тархах боломж;

7.3.6.хэрэглэгчийн гомдол, мэдээллийн шийдвэрлэлт.

7.4.Нийгмийн сүлжээний эрсдэлийг үнэлэх журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.5.Энэ хуулийн 7.2-д заасан зохицуулалттай нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид Харилцаа холбооны зохицуулах хороо мэдэгдэл хүргүүлнэ.

7.6.Зохицуулалттай нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь энэ хуулийн 7.5-д заасан мэдэгдэл хүргүүлснээс хойш 90 хоногт багтаан 6 дугаар зүйлд заасан технологийн хамгаалалтын шаардлагыг хангаж, энэ тухай мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ.

7.7.Нийгмийн сүлжээнд хуульд заасан урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй нийгмийн

сүлжээний үйлчилгээнд Монгол Улсаас хандах хандалтыг хаах хүртэлх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦОО, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХАД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

8 дугаар зүйл.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг

8.1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн насны онцлогт нийцүүлэн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавих, хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалах үүрэгтэй.

8.2.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах талаар дараах эрх, үүрэгтэй:

8.2.1.хүүхдийн ашиглаж буй нийгмийн сүлжээний талаар мэдлэгтэй байх, цахим ур чадвараа дээшлүүлэх сургалт, зөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагаас авах;

8.2.2.хүүхдэд нийгмийн сүлжээний аюулгүй хэрэглээний мэдлэг олгох, эрсдэлээс өөрийгөө хамгаалах талаар зөвлөгөө өгөх;

8.2.3.хүүхдийнхээ ашиглаж буй харилцаа холбооны сүлжээний дугаарыг хүүхдийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт үнэн зөвөөр бүртгүүлэн, хэрэглээнд хяналт тавих;

8.2.4.гэр бүлийн орчинд хүүхдийн ашиглаж буй интернэтийг насанд хүрэгчдэд зориулсан контентын шүүлтүүртэй байхаар тохиргоог идэвхжүүлэх;

8.2.5.эцэг эхийн хяналтын хэрэгслийг ашиглаж хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалах;

8.2.6.хүүхэд нийгмийн сүлжээнээс хэт хамааралтай байхаас урьдчилан сэргийлж, эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;

8.2.7.хориотой, хүүхдэд хортой агуулгад өртөхөөс хамгаалах;

8.2.8.нийгмийн сүлжээнд хориотой, хүүхдэд хортой агуулга нийтэлсэн, түгээсэн, сурталчилсан, эсхүл нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлын талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

9 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагын чиг үүрэг

9.1.Боловсролын сургалтын байгууллага нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, суралцагчид нийгмийн сүлжээний эрсдэл, аюулгүй байдал, зохистой хэрэглээний талаарх мэдлэг, дадал, ур чадвар олгох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй.

9.2.Боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 9.1-т заасан үүргээ биелүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.2.1.эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдлэг олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, зөвлөмж өгөх;

9.2.2.суралцагчдад нийгмийн сүлжээнд ёс зүйтэй байх, бусдыг хүндэтгэх, хувийн мэдээллээ хамгаалах, нууцлал, аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээний талаарх мэдлэг, дадал олгох;

9.2.3. нийгмийн сүлжээнээс үүдэлтэй аливаа сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, эсхүл өртсөн суралцагчид шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээ болон бусад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх;

9.2.4.сургуулийн орчинд нийгмийн сүлжээ ашиглахыг хязгаарлах;

9.2.5.нийгмийн сүлжээнд суралцагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлын талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

9.3.Боловсролын сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа, даалгавар, үнэлгээ, суралцагчтай холбоотой мэдээлэл солилцоход энэ хуулийн 14.1.3-т зааснаас бусад нийгмийн сүлжээг ашиглахыг хориглоно.

10 дугаар зүйл.Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг

10.1.Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч дараах эрх, үүрэгтэй байна:

10.1.1.мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологи ашиглан хэрэглэгчийн насны бүлгийг баталгаажуулан бүртгэх;

10.1.2.нийгмийн сүлжээнд 13 насанд хүрээгүй хүүхдийг бүртгэхгүй байх;

10.1.3.нийгмийн сүлжээнд 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийг баталгаажуулан бүртгэх;

10.1.4.нийгмийн сүлжээнд нийтэлсэн, түгээсэн, сурталчилсан хориотой агуулгыг ажлын 8 цагт багтаан устгах;

10.1.5.эрх бүхий байгууллагын мэдэгдэлд үндэслэн хүүхдэд хортой агуулгад 72 цагийн дотор хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авах;

10.1.6.хиймэл оюун ашиглан бүтээсэн контентод "хиймэл оюун ашиглан бүтээсэн" гэх агуулгатай таних тэмдгийг харагдахуйц байдлаар байрлуулах;

10.1.7.энэ хуулийн 6.3-т заасан технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

10.1.8.нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үүргийн хэрэгжилтийг хангахад шуурхай дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах суурин төлөөлөгч, төлөөлөх байгууллага эсхүл албан ёсны харилцах нэгж томилж, Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;

10.1.9.хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой гомдол, мэдээлэл, эрсдэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор эрх бүхий байгууллагатай шууд харилцах суваг нээх;

10.1.10.Монгол Улсын хэрэглэгчийн тоон мэдээлэл, гомдол шийдвэрлэлт, хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд ашиглаж буй технологийн шинэчлэлийн талаарх тайланг жил бүр Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэх.

10.2.Хэрэглэгчийн насыг баталгаажуулахад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчээс дамжуулсан насны бүлгийн мэдээллийг ашиглана.

11 дүгээр зүйл.Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг

11.1.Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь дараах эрх, үүрэгтэй байна:

11.1.1.харилцаа холбооны сүлжээний дугаарыг 16-аас доош насны хүүхдэд түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт баталгаажуулан олгох;

11.1.2.насны баталгаажуулалтад шаардлагатай мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй болгож солилцох техникийн болон зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах;

11.1.3.насны баталгаажуулалт хийх зорилгоор ашигласан мэдээллийн нууцлалыг хангахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баримтлах;

11.1.4.насны баталгаажуулалтын үйл явц, хүний хувийн мэдээллийн нууцлалыг хангах үйл ажиллагааны талаар хэрэглэгчийг шаардлагатай мэдээллээр хангах;

11.1.5.Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд үндэслэн өөрийн сүлжээнд шаардлагатай технологийн арга хэмжээ авах.

12 дугаар зүйл.Нийгмийн сүлжээ хэрэглэгчийн эрх, үүрэг

12.1.Хэрэглэгч дараах эрх, үүрэгтэй байна:

12.1.1.өөрийн нийгмийн сүлжээний бүртгэлд харилцаа холбооны сүлжээний дугаарыг ашиглан насны баталгаажуулалт хийх;

12.1.2.насны баталгаажуулалтын үйл явц дахь хүний хувийн мэдээллийн нууцлалыг хангах үйл ажиллагааны талаар мэдээлэл авах;

12.1.3.өөрийн нийгмийн сүлжээний бүртгэл, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

12.1.4.хориотой агуулгыг олон нийтийн сүлжээнд нийтлэхгүй, түгээхгүй, сурталчлахгүй байх;

12.1.5.хориотой, хүүхдэд хортой агуулгын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх;

12.1.6.эрх бүхий байгууллагын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

12.2.Аливаа этгээд нийгмийн сүлжээнд хүүхдэд хуурамч бүртгэл үүсгэх боломжоор хангах, эсхүл өөрийн бүртгэлтэй хаягийг ашиглуулахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦОО, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

13 дугаар зүйл.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

13.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудлаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.1.2.нийгмийн сүлжээний болон харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийг энэ хуульд заасан үүргээ биелүүлэхэд хамтран ажиллах;

13.1.3.нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар гадаад улсын төрийн эрх бүхий байгууллага, зохицуулах байгууллага, бодлого хэрэгжүүлэгч байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

13.1.4.хуульд заасан бусад.

14 дүгээр зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

14.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1.боловсролын сургалтын байгууллага, сургуулийн орчинд нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.2.цахим ур чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн сүлжээний аюулгүй байдлыг хангах, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх агуулгыг бүх шатны сургалтын хөтөлбөрт үе шаттайгаар тусгах;

14.1.3.сургалтын үйл ажиллагаа, суралцагчтай холбоотой мэдээлэл солилцох зориулалтын программ хангамж нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

14.1.4.сургалтын үйл ажиллагаа, суралцагчтай холбоотой мэдээлэл солилцоход энэ хуулийн 14.1.3-т зааснаас бусад нийгмийн сүлжээг хязгаарлах ажлыг зохион байгуулах;

14.1.5.энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан Боловсролын сургалтын байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

14.1.6.хуульд заасан бусад.

15 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

15.1.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх, оролцоо, аюулгүй байдлыг хангах талаар төрийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

15.1.2.нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын санаачилгад нэгдэх, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх;

15.1.3.холбогдох төрийн байгууллагатай хамтран нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтэд чиглэсэн мэдлэг олгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

15.1.4.нийгмийн сүлжээнээс үүдэлтэйгээр Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан эрсдэлт нөхцөл бий болох тохиолдол, хүүхдийн нас, бие бялдар, сэтгэхүйн болон сэтгэл зүйн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй агуулга, үйлчилгээ, хэрэглээний хэв шинжид судалгаа, дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангах;

15.1.5.хуульд заасан бусад.

16 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

16.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдал хөндөгдөж, хохирсон тохиолдолд Хүүхэд хамгааллын тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлэх;

16.1.2.нийгмийн сүлжээнээс үүдэлтэй эрсдэлийг судалж, дүн шинжилгээ хийх, нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах санал боловсруулж, дээд шатны байгууллагад уламжлах;

16.1.3.хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зориулсан нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

16.1.4.хүүхэд, залуучуудын оролцооны байгууллага, хуулийн этгээд болон иргэд, олон нийтийн оролцоог хангаж, хамтран ажиллах;

16.1.5.хүүхдийн эрхийн улсын байцаагчид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах;

16.1.6.хуульд заасан бусад.

17 дугаар зүйл.Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэг

17.1.Харилцаа холбооны зохицуулах хороо нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1.нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч болон харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч энэ хуульд заасан үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

17.1.2.нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх;

17.1.3.эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийн талаарх мэдээллийг нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид ирсэн даруй хүргүүлэх.

17.1.4.хуульд заасан бусад.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ

18 дугаар зүйл.Гомдол, мэдээлэл хүлээн авах, шилжүүлэх

18.1.Хүн, хуулийн этгээд нь нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдал зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллага, хүүхдийн яаралтай тусламжийн утсанд гаргана.

18.2.Гомдол, мэдээллийг хүлээн авсан этгээд нь гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж, бүртгэл хөтөлнө.

18.3.Эрх бүхий этгээд нь хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шалгаж, тухайн үйлдэл, үйл ажиллагаа нь энэ хуульд заасан хүүхдийн эрх, аюулгүй байдалд харшилсан эсэх, эрсдэл учруулсан эсэхийг тогтоож шийдвэрлэнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

19 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийг 2027 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.4 дэх заалт нэмсүгэй:

“7.1.4.энэ хууль болон бусад хуульд заасны дагуу нэг удаа хэрэглэгчийг танин мэдэх зорилгоор.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 14 дэх хэсэг нэмсүгэй:

“14. 13 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэсэн бол нийгмийн сүлжээ эрхлэгч хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг 2027 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсаас нийгмийн сүлжээний хэрэглэгч болон нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн насыг баталгаажуулах ажлыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хийнэ.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар
2026 он**

АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ. Асуудалд хийсэн дүн шинжилгээ

- 1.1. Асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон нь
- 1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон нь
- 1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон нь

ХОЁР. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолсон нь

ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсан нь

ДӨРӨВ. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судалсан нь

ТАВ. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж хийсэн дүгнэлт

ЗУРГАА. Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын судалгаа (харьцуулсан судалгаа)

ДОЛОО. Дүгнэлт

НАЙМ. Зөвлөмж

Ашигласан эх сурвалж

Хавсралт

УДИРТГАЛ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлд цахим орчин дахь хүүхэд хамгааллын тухай заалт хэрхэн хэрэгжиж байгаа эсэх, түүнийг боловсронгуй болгох нь энэхүү тандан судалгааны ажлыг хийх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Тухайлбал, цахим дээрэлхэлт, цахим дарамт, хортой агуулга бүхий контент, цахим залилан, танихгүй этгээдийн дарамт, бэлгийн мөлжлөг, цахим донтолт, хүүхдийн хувийн мэдээлэл алдагдах зэрэг эрсдэл нь хүүхдийн аюулгүй байдал, эрүүл хөгжил, сэтгэл зүй, зан төлөвт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх болсон байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлд цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг тодорхой хэмжээнд тусгасан боловч уг зохицуулалтын хэрэгжилт, үр нөлөө, цаашид боловсронгуй болгох шаардлагыг судлах нь энэхүү тандан судалгааны ажлыг хийх үндэслэл болж байна. Ялангуяа нийгмийн сүлжээний хэрэглээ хүүхдийн өдөр тутмын амьдралд гүнзгий нэвтэрсэн өнөөгийн нөхцөлд хүүхдийн цахим орчин дахь оролцоо, аюулгүй байдал, эрхийн хамгаалалтыг тусгайлан авч үзэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Олон улсын хэмжээнд хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарал хандуулж, Европын Холбооны Digital Services Act, Их Британийн Online Safety Act, Австралийн Online Safety Act 2021 зэрэг хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байна. Эдгээр хууль тогтоомжид нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлага, хүүхдийн аюулгүй байдлын анхдагч тохиргоо, нас баталгаажуулалт, хортой контентын хязгаарлалт, алгоритмын эрсдэлийн зохицуулалт зэрэг асуудлыг тусгайлан зохицуулсан байна.

Мөн Монгол Улсад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2025 оны судалгаагаар 13–17 насны хүүхдүүдийн 51.3 хувь нь цахим дарамт, доромжлолд өртсөн болохыг тогтоосон бөгөөд цахим дээрэлхэлт нь хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, түгшүүр, сэтгэл гутрал, амиа хорлох бодол төрүүлэх эрсдэлтэйг онцолсон байна. Энэ нь хүүхдийн эрхийг цахим орчинд хамгаалах асуудлыг тусгайлан зохицуулах эрх зүйн орчин шаардлагатайг харуулж байна.

Энэхүү тандан судалгааны хүрээнд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтан болон хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийг хамруулсан судалгааны үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийв. Судалгаанд нийт **11,234 оролцогч** хамрагдсан бөгөөд судалгааны үр дүнгээс харахад хүүхдийн цахим хэрэглээ улс орон даяар эрчимтэй нэмэгдэж, хүүхдүүд YouTube, Facebook, TikTok, Instagram зэрэг олон төрлийн цахим платформыг тогтмол ашиглаж байгаа нь тогтоогдсон байна.

Үүний зэрэгцээ хүүхдүүд цахим орчинд олон төрлийн эрсдэлд өртөж байгаа бөгөөд эцэг эх, асран хамгаалагч, багш, боловсролын байгууллагын зүгээс тавих хяналт, хамгаалалтын тогтолцоо хангалтгүй байна. Мөн хүүхдүүд цахим орчинд тулгарсан асуудлаа гэр бүл, багш, холбогдох байгууллагад тэр бүр мэдээлдэггүй, эцэг эх, багш нарын цахим аюулгүй байдлын талаарх мэдлэг, арга зүй, хамгаалалтын хэрэгслийн хэрэглээ хангалтгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсон болно.

Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилго нь тодорхой асуудлыг шийдвэрлэх, зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид уламжлах байдаг.

Хууль тогтоомжийн тухай хуульд: хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаатай хандах, тухайн харилцааг заавал хуулиар зохицуулах шаардлагатай эсэх, хэрэгжүүлэх боломж нөхцөл, холбогдон гарах зардал, хууль зүй, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөг сайтар судлах, хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлахаас эхлээд төсөл боловсруулах үе шатыг тодорхойлох талаар заасан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-д тус тус тодорхойлсноор дараах үндсэн 7 үе шатны дагуу тандан судалгааг гүйцэтгэх ёстой. Үүнд:

1. асуудалд дүн шинжилгээ хийх;
2. асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. зөвлөмж боловсруулах.

Дээрх аргачлалын агуулга, дэс дарааллын дагуу Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлыг гүйцэтгэж, тайланг боловсруулсан болно.

НЭГ. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1. Асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон нь:

1.1.1. Цахим орчин ба хүүхдийн эрх

Цахим орчин, нийгмийн сүлжээ, мэдээ, мэдээлэл дамжуулах хэрэгсэл, харилцаа холбооны хурдацтай хөгжил түүнийг даган хувьсаж байгаа нийгмийн өөрчлөлтөд цахимд суурилсан хэрэглээ тэргүүлэх болсон бөгөөд үүнийг нийгмийн харилцааны бүхий л оролцогчид дэмжсээр ирсэн.

Сүүлийн үед цахим орчин дахь хүний эрх, түүний дотор хүүхдийн эрх чөлөөг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээнд эрх зүйн зохицуулалт хийх, тодорхой хязгаарлалт тогтоох үйл явц өрнөх болсон.

Цахим орчин дахь нийгмийн сүлжээг ашиглагч хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага улс орнууд өөрсдийн үйл ажиллагааны зорилго, онцлогт нийцсэн техник хэрэгсэл, программын тусламжтайгаар бүрдүүлж, түүнийг хөгжүүлэх, илүү дэвшилтэт болгосоор байгаа бөгөөд тус орчин нь хил хязгаар, орон зай, цаг хугацаанаас үл хамаардаг. Гар утас, нүдний шил, телевиз, цаг, компьютер, таблет, автомашин, бусад дагалдах хэрэгсэл болон аюулгүй байдлын тоног төхөөрөмж зэрэг өдөр тутмын идэвхитэй хэрэглээний бүхий л зүйлс цахим орчинтой ямар ч саад бэрхшээлгүйгээр холбогдохын зэрэгцээ, интернэтээс шууд хамааралтай болсон нь хүний тэр дундаа хүүхдийн хүмүүжил, ёс суртахуун, эрх, эрх чөлөө, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Интернэт хэрэглээ, тэр дундаа нийгмийн харилцааны зарим платформууд хүүхдэд гүнзгий нөлөөлөх болсны сөрөг тал нь цахим дээрэлхэл, гадуурхал, гүтгэлэг, доромжлол, хууль бус контент, сурталчилгаанд өртөх зэрэг байдлаар илэрч, улмаар энэ нь донтох, ёс суртахуун, хүмүүжлийн доголдолтой болох, сэтгэл гутралд орох, эцэст нь амиа хорлоход хүргэх зэрэг тодорхой үр дагаврыг хүүхдэд бий болгох болсон тул нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах асуудалд онцгойлон анхаарал хандуулах шаардлагыг бий болгосон.

Орчин үеийн цахим хөгжлийн эл сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудлаар олон улсын байгууллагууд ихээхэн анхаарал хандуулж, олон төрлийн арга хэмжээ зохион байгуулах болсон бөгөөд Монгол Улсын Засгийн газар, Боловсрол шинжлэх ухааны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нэгдсэн Үндэсний байгууллага нарын хамтран хэрэгжүүлдэг “Хүүхдэд ээлтэй цахим орчин” төслийн хүрээнд “Цахим орчин дахь хүүхэд хамгааллын зөвлөм” гэсэн нэртэйгээр дахин гаргасан байна.

Тус зөвлөмжийн зорилго нь нэг талаас хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах бол, нөгөө талаас цахим орчноос хүүхдэд өгч болох боломж, ашиг тусыг дэмжих, энэ хоёр харилцан хамаарал бүхий хүчин зүйлийн хоорондын тэнцвэрийг бүрдүүлэхэд оршино. Шинэчлэгдсэн зөвлөмжид цахим орчны нарийн төвөгтэй байдлаас үүдэлтэйгээр хүүхдийн хувийн нууц, хувийн мэдээллийг хамгаалах хэрэгцээ, шаардлага нэн чухлаар тавигдаж байгаа болохыг хүлээн зөвшөөрч, олон талын оролцогчдын хүлээх үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна¹.

¹ Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 2021 оны 5 дугаар 31-ний өдөр гаргасан “Цахим орчин дахь хүүхэд” шинэчилсэн зөвлөмж

Мөн Олон Улсын Цахилгаан холбоо (ITU)-ны байгууллага “Хүүхдийг Нийгмийн сүлжээнд хамгаалах удирдамж”-ийг 2020 онд шинэчлэн гаргасан бөгөөд “Хүүхдэд зориулсан удирдамж”-аараа цахим орчны эрсдэл, боломжуудыг ойлгуулах, өөрсдийгөө хамгаалах арга замуудыг заах, “Эцэг эх, багш нарт зориулсан удирдамж”-аараа Хүүхдүүдийн цахим орчны хэрэглээг хэрхэн дэмжих, удирдан чиглүүлэх талаар практик зөвлөмжүүдийг агуулсан. Гэр бүл, сургуулийн орчинд аюулгүй, эерэг цахим орчныг бүрдүүлэхэд чиглэсэн, “Аж үйлдэрт зориулсан удирдамж”-аараа Мэдээлэл, харилцаа холбооны салбарын компаниудыг хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүнд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх, боловсролын хөтөлбөрүүдийг дэмжих, “Бодлого боловсруулагчдад зориулсан удирдамж”-аараа Улс орнуудын засгийн газруудыг хүүхдийг нийгмийн сүлжээнд хамгаалах үндэсний стратеги, хууль тогтоомжийг боловсруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг өгдөг. Энэ нь олон талт оролцоог хангах, хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын стандартуудыг дагаж мөрдөхийг уриалсан байна.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо нь 2021 онд Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн Ерөнхий Тайлбар №25-ыг баталсан. Энэ тайлбар нь хүүхдийн эрхийг дижитал орчинд хэрхэн хамгаалах талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгсөн. Тухайлбал тус тайлбарт хүүхдүүдийг нийгмийн сүлжээнд аливаа хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хувийн нууцыг хадгалах, насанд тохирсон мэдээлэл, үйлчилгээ авах эрхийг хангах зэрэг асуудлуудыг хөндсөн.

Түүнчлэн Австралийн Засгийн газар 2024 оны 11 дүгээр сард “Нийгмийн сүлжээний хамгийн бага насны хязгаар”-тай холбоотой хуулийг баталж 16-аас доош насны хүүхдийг нийгмийн сүлжээнд нэвтрэхийг хориглосон. Энэхүү хууль нь 2025 оны 12 дугаар сараас хэрэгжиж эхлэх бөгөөд цахим орчин дахь сөрөг нөлөөллөөс хамгаалах юм. Тус хуультай холбоотой судалгааны үндэслэл нь Австрали хүүхдүүдийн 80 хувь нь Youtube, TikTok, Instagram, Snapchat зэрэг платформуудыг ашиглаж байсан бөгөөд ямар нэгэн насны хязгаарлалт, хяналтын нэмэлт механизм хангалтгүй байсан байна. Ингэснээр насанд хүрээгүй хүүхэд ямар нэгэн шүүлтүүргүйгээр мэдээ, мэдээллийг авах, гэмт хэргийн хохирогч болж байгаа тул шаардлагтай арга хэмжээг авч буйгаа зарлажээ.

Америкийн Нэгдсэн Улсын тухайд 1998 онд батлагдсан Хүүхдийн цахим орчин дахь хамгааллын тухай хууль (COPPA) мөрдөгдөж байгаа бөгөөд 13 хүртэл насны хүүхдийн хувийн мэдээллийг эцэг эхийн зөвшөөрөлгүй цуглуулах, хадгалах, ашиглахыг хориглосон бол үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрсдийн хэрэглэгчийн насыг асуухыг даалгасан байна. Ингэснээр Meta /Facebook, instagram/, Google /youtube/, X /twitter/ зэрэг компаниуд хүүхдийг заавал бүртгэж, тодорхой хэмжээний хязгаарлалт тогтоосон байна.

1.1.2 Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах Монгол Улсын эрх зүйн орчин

Монгол Улсад 1990 онд өрнөсөн ардчилсан хөдөлгөөний дүнд хүн төвтэй, эрх зүйт төртэй хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг сонгож авсан нь нийгмийн бүхий л хүрээ, салбарыг хамарсан шинэтгэл хийх эхлэл бөгөөд үүний эх үндэс нь Үндсэн хуулиа батлах явдал байсан.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний талаар тусгайлан зааж уг эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцах талаар үүрэг хүлээсэн нь шаардлагатай бүхий л хууль тогтоомжийг баталж мөрдүүлэх нөр их ажлыг өрнүүлсэн. Энэ хүрээнд бидний тухайлан авч үзэж байгаа Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хууль тогтоомжийн зохицуулалт хамаарах юм.

Эдүгээ хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдон үүсэх харилцааг 1989 оны Хүүхдийн эрхийн конвенци зэрэг Монгол Улсын олон улсын гэрээ, мөн Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль зэрэг дотоодын нэлээдгүй олон хууль тогтоомжоор зохицуулж байна.

Эдгээрээс Хүүхэд хамгааллын тухай хууль /2024/, Хүүхдийн эрхийн тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль зэрэг хуулиуд нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хэм хэмжээг агуулж байна.

Үүнээс үзвэл дээрх хууль тогтоомжийн зохицуулалтыг хүүхдийн эрхийг хамгаалах нийтлэг хэм хэмжээ, нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах тусгай хэм хэмжээ хэмээн ангилан авч үзэж болохоор байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах нийтлэг хэм хэмжээнд задлан шинжилгээ хийвэл Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.-т *"Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно"*, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т *"Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно"*, Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр зүйлийн 1-т *"Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан ..."* зэрэг зохицуулалт нь нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдон үүсэх харилцаанд шууд үйлчлэхээр байна.

Харин нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах тусгай хэм хэмжээг судлан үзвэл Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, хүүхдэд хортой агуулга, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ” мөн зүйлийн 25.3-т “Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхихах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.”, 25.4-т “Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно” гэсэн нь тухайн асуудлыг зохицуулсан ерөнхий харилцаанд үйлчлэхээр байна.

Монгол Улсын хувьд нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалтай холбоотой нарийвчилсан зохицуулалттай бие даасан хууль байхгүй байна. Нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг 2015 онд Эрүүгийн хуульд хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэргийг цахим орчин ашиглаж үйлдэх зохицуулалт хийгдсэнээр эхлэл нь тавигдсан байна. Харин цахим орчны хүүхэд хамгаалалтай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах алхмыг хийсэн байна. Тухайлбал, Эрүүгийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжид хүүхдийг цахим орчны хор хөнөөлөөс хамгаалах, гэм буруутай этгээдэд холбогдох хариуцлагыг хүлээлгэхээр зохицуулсан байдаг.

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсанаар Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилах” зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “цахим сүлжээ” гэснийг “кибер орчин” болгон өөрчилсөн байна.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд “кибер орчин” гэх мэдээлэлд хандах, нэвтрэх, цуглуулах, түүнийг боловсруулах, хадгалах, ашиглах боломж олгож байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний орчин байна гэсэн байна.

Нэгтгэн авч үзэхэд хууль тогтоомжийн зохицуулалт нь нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах, цахим гэмт хэргээс тухайлбал, цахим орчин бэлгийн хүчирхийлэл, зүй бус зар сурталчилгаа, хуурамч, мэдээ, мэдээллээс хэрхэн хамгаалах, сөрөг агуулгатай контентын хандалтыг хязгаарлах, арилгах талаарх эрх зүйн харилцааг цогцоор нь тусгайлан зохицуулаагүй байна.

1.1.3. Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг зохицуулахтай холбогдон үүсэх харилцааг хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлахтай холбогдуулан үүсэн бий болсон асуудал, түүний мөн чанар, цар хүрээний талаарх судалгаа

Өнөөдөр дэлхий нийтээрээ интернэт орчинд ихэнх цагийг өнгөрүүлж, цахим орчин нь нийгмийн амьдралд гүнзгий нөлөөлөх болжээ.

2021 оны байдлаар дэлхийн нийт хүн ам 7.87 тэрбум байгаагаас интернэт хэрэглэдэг 4.66 тэрбум (дэлхийн нийт хүн амын 59.5 хувь), гурван хүүхэд тутмын нэг нь интернэт хэрэглэгч, гурван интернэт хэрэглэгч тутмын нэг нь 18-аас доош насны хүүхэд байна².

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /Ковид-19/ өвчний улмаас дэлхийн нийт оюутан, сурагчдын 99 хувь буюу 1.7 тэрбум хүүхэд танхимын хэлбэрээр сургалт явуулах боломжгүй болоод байна³. Ийнхүү хүүхдэд танхимын хэлбэрээр сургалт явуулах боломжгүй байгаатай холбоотойгоор нийгэм, эдийн засагт олон асуудал, үр дагавар үүсч байгаа бөгөөд цахим хэлбэрээр сургалтыг үргэлжлүүлэх сонголттой тулгараад байна. Үүнээс шалтгаалан хүүхдүүдийн цахим орчны хэрэглээ нэмэгдэж, нийгмийн сүлжээнд өнгөрөөх хугацаа эрс уртассан. Манай улсад ч ийм нөхцөл байдал үүссэн билээ.

ДЭМБ-ын судалгаагаар жил бүр 200 сая хүүхэд бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн золиос болдог байна. Үүний тодорхой хувь нь нийгмийн сүлжээнд үйлдэгдэж, жилээс жилд хувь хэмжээ нь нэмэгдэж байгаа бөгөөд интернэт орчин нь мөлжлөг, хүчирхийллийн талбар болж байна⁴.

Нийгмийн сүлжээнд дараах төрлийн зөрчлүүд гарч, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа ба энэ нь тусгай зохицуулалт бүхий хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах чухал шаардлагатай болохыг илэрхийлж байна. Үүнд:

1. Хууль бус агуулга бүхий мэдээлэл;
2. Нийгмийн сүлжээнд харилцаа тогтоохтой холбоотойгоор үүсэх гэмт хэрэг, зөрчил;
3. Цахим орчин дахь ялгаварлан гадуурхалт;
4. Цахим орчин ашиглан сэтгэл санаа болон бие махбодийн дарамтанд оруулах;
5. Хүүхдийн итгэлийг олж, дасгах;
6. Хүүхдийн хувийн мэдээлэл, нууцад халдах зэрэг болно.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийн зөрчлийн асуудал өдөр ирэх тусам нэмэгдэж, хүүхдүүд сургуулийн орчиндоо цахим халдлагад өртөх нь ихэсч, улмаар үүнийг дагасан олон сөрөг үр дагаварууд бий болж байна.

Эдгээрийг судлан авч үзвэл:

Хүүхэд цахим орчноос хууль бус, хориотой мэдээлэл авснаар хүүхдийн хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлж байна. Цахим орчин дахь ялгаварлан гадуурхалтаас үүдэн хүүхдүүд өөртөө итгэлгүй болох, нийгмийн харилцаанд орохоос айж эмээх, улмаар амиа хорлох шалтгаан нөхцлийг бий болгож байна.

² <https://datareportal.com/reports/digital-2021-global-overview-report>

³ https://gia.gov.mn/12/item/709#_ftn1

⁴ <https://gia.gov.mn/12/item/709>

Түүнчлэн нийгмийн сүлжээнд бусадтай харилцаа тогтоож, улмаар гэмт хэргийн хохирогч болох явдалууд ч нэмэгдсээр байна.

Хэдийгээр ийнхүү нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхтэй хамааралтай олон хууль бус ажиллагаа явагдаж байгаа боловч цахим орчныг төрөөс бүхэлд нь хянан зохицуулах боломжгүй юм.

Тиймээс цахим орчин, интернэт хэрэглээг эрх зүйгээр зохицуулахын зэрэгцээ технологийн шийдлийн хувьд зохицуулах нь илүү оновчтой болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Дийлэнх орнууд интернэт орчинд насанд хүрээгүй хүүхдэд сөргөөр нөлөөлөх мэдээллийг хориглох, хязгаарлах, үүнийг зохицуулах байгууллага, хороог байгуулан ажиллуулах арга замыг сонгон хэрэглэж байна.

Манай улсын хувьд ч хүүхдийн эрхийн зөрчил үүсгэх, насанд хүрээгүй хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэх мэдээллийг хориглох, хязгаарлах харилцааг зохицуулах зайлшгүй хэрэгцээ бий болсон гэж үзэхээр байна.

Ийнхүү нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын асуудлыг манай улсын хувьд хууль тогтоомжоороо бүрэн зохицуулаагүй бөгөөд энэ төрлийн харилцааг зохицуулах хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага үүсэн бий болсон байх тул эл асуудлыг урьдчилан тандан судлах явдал нэн чухлаар тавигдаж байна.

Тиймээс нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах нь зөв зохистой талаар судлан үзэх нь энэхүү тандан судалгааны “үндсэн асуудал”-аар тодорхойлж байна.

Асуудлыг тодруулах үүднээс авсан судалгааны талаар

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулахтай холбогдсон асуудлаар өсвөр насны хүүхдүүдээс болон эцэг, эх, асран хамгаалагч нараас дараах судалгааны анкетаар судалгаа авсан болно.

Хүүхдээс авсан судалгааны анкетын загвар:

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТАЛААРХ САНАЛ АСУУЛГА /ХҮҮХДЭЭС АВАХ АСУУЛГА/

Энэ өдрийн мэндийг хүргэе!

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах талаарх харилцааг зохицуулахад чиглэсэн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны хүрээнд энэхүү санал асуулгыг бэлтгэсэн болно.

Бидний ажилд дэмжлэг үзүүлж энэхүү судалгааг үнэн зөв бөглөж өгөхийг танаас хичээнгүйлэн хүсье.

1. Хэдэн настай вэ?
 - а. 10-12

- б. 12-14
- в. 14-16
- г. 16-18

2. Өдөрт дунджаар хэдэн цагийг нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг вэ?

- а. 1-2 хүртэлх цаг
- б. 2-4 хүртэлх цаг
- в. 4 -8 хүртэлх цаг
- г. 8 болон түүнээс дээш цаг

3. Интернэтийг ихэнх тохиолдолд ямар зорилгоор хэрэглэдэг вэ?

- а. Мэдээ, мэдээлэл цуглуулах, олж авах
- б. Найз нөхдийн харилцаа
- в. Хичээл, сургалттай холбоотойгоор ашиглах
- г. Нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)
- д. Онлайн тоглоом хайх, тоглох (Minecraft, PUBG mobile, Roblox, Mobile Legend зэрэг)
- е. Бусад

4. Нийгмийн сүлжээнд танихгүй хүнээс ирсэн хүсэлт, мессежинд хариу өгдөг үү?

- а. Хариу өгдөг
- б. Хариу өгдөггүй
- в. Сонирхож үздэг /орж хардаг/
- г. Шууд блок хийдэг

5. Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, пост авч байсан уу?

- а. Тийм
- б. Үгүй

6. Хэрэв тийм бол дараах сонголтуудаас алийг нь сонгох вэ?

- а. Хувийн мэдээллийг нийтэд тараах
- б. Дарамталсан үг зурвас
- в. Гутаан доромжилсон үг сэтгэгдэл
- г. Гэмт хэрэгт уруу татсан
- е. Садар самуун сурталчилсан
- ё. Бусад

7. Нийгмийн сүлжээнд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу?

- а. Тийм
- б. Үгүй

8. Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү?

- а. Хэрэглэдэг
- б. Хэрэглэдэггүй
- в. Тохиргооны талаар мэдэхгүй
- г. Зарим мэдээллийг нууцалдаг

9. Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний цагт ямар нэгэн хяналт тавьдаг уу?

- а. Үргэлж
- б. Заримдаа
- в. Огт үгүй

10. Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний агуулгад ямар нэгэн хяналт тавьдаг уу?

- а. Үргэлж
- б. Заримдаа
- в. Огт үгүй

11. Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ?

- а. Эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана
- б. Найз нөхдөөсөө зөвлөгөө авна
- в. Сургуулийн багшид хандана
- г. Хүүхдийн тусламжийн байгууллагаас тусламж хүснэ
- е. Бусад

БАЯРЛАЛАА

Эцэг, эх, асран хамгаалагч нараас авсан судалгааны анкетын загвар:

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ
САНАЛ АСУУЛГА
/ЭЦЭГ ЭХЭЭС АВАХ АСУУЛГА/**

Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны хүрээнд энэхүү санал асуулгыг бэлтгэсэн болно.

Бидний ажилд дэмжлэг үзүүлж энэхүү судалгааг үнэн зөв бөглөж өгөхийг танаас хичээнгүйлэн хүсье.

1. Та хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хяналт тавьдаг уу?
 - а. Хяналт тавьдаг
 - б. Хяналт тавьдаггүй
 - в. Хааяа хяналт тавьдаг
2. Та цахим орчин дахь мэдээллийн шүүлт хийх тохиргооны талаар хэр мэдээлэлтэй вэ?
 - а. Шүүлт хийх тохиргоо ашигладаг
 - б. Сонсож байсан
 - в. Мэдэхгүй
3. Таны хүүхэд нийгмийн сүлжээнд үе тэнгийнхний дарамт, шахалтанд өртөж байсан уу?
 - а. Тийм
 - б. Үгүй
 - в. Мэдэхгүй
4. Таны хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэг үү?
 - а. Тийм
 - б. Үгүй
5. Та нийгмийн сүлжээнд хүүхдийн хамгаалалын талаар хэр мэдээлэлтэй вэ?
 - а. Хангалттай
 - б. Дунд
 - в. Бага зэрэг
 - г. Мэдэхгүй
6. Таньд нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн зохицуулалттай холбоотой санал байвал дор бичнэ үү.

ТАНД БАЯРЛАЛАА

Судалгааны үр дүн:

Судалгааг өсвөр насны хүүхдүүдээс онлайн болон цаасан хэлбэрээр цуглуулсан бөгөөд нийт 1129 хүүхэд хамрагдсан байна. Эцэг, эх, асран хамгаалагч нараас онлайн хэлбэрээр судалгааг авсан бөгөөд нийт 253 иргэд хамрагдсан байна.

а/ Хүүхдээс авсан судалгааны үр дүн:

Нийт 1129 хүүхдээс авсан судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

-Тус судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн насаар ангилан үзвэл нийт судалгаанд оролцогчдын 40 хувь нь 12-14 насны хүүхдүүд хамрагдсан байна;

- 46 хувь нь 2-4 хүртэлх цагийг нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг байна;

-Давхардсан тоогоор нийт 79 хувь нь нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдохоор, 65 хувь нь найз нөхдийн харилцаа холбоо тогтоохоор цахим орчныг хэрэглэдэг байна;

-Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, и-мэйл авч байсан уу гэсэн асуулгад 78 хувь нь авч байгаагүй гэсэн хариулт өгсөн нь сайшаалтай байна;

-Харин авч байсан гэж хариулсан 22 хувийн оролцогчдоос 50 хувь нь хувийн мэдээллийг нь нийтэд тараасан гэсэн хариултыг сонгосон байна;

-Интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу гэдэгт 56 хувь нь тийм гэж хариулснаас үзвэл цахим сүлжээнд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэл нь ямар нэгэн шүүлтүүргүйгээр байршиж байдаг гэсэн дүгнэлтэд хүрэхээр байна;

-Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү гэсэн асуулгад 60 хувь нь хэрэглэдэг гэж хариулсан байна;

-Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний цаг болон агуулгад хяналт тавьдаг уу гэж асуухад заримдаа гэдгийг 55 хувь нь сонгосноос үзвэл цахим сүлжээн дэх эцэг эхийн хяналт сул байна;

-Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ гэдэгт судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана, 41 хувь нь найз нөхдөөсөө зөвлөгөө авна гэсэн хариултыг сонгосон байна.

Үүнээс нэгтгэн дүгнэвэл 10-18 насны нийт 1129 хүүхдээс судалгаа авахад интернэтийг 2-4 цаг хүртэлх хугацаанд хэрэглэдэг, интернэтийг ихэвчлэн нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдох, найз нөхөдийн харилцаа холбоо тогтооход хэрэглэдэг, интернэт хэрэглээний цаг болон агуулгад эцэг, эхийн хяналт сул байдаг, интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралддаг, нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандахаар байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

б/ Эцэг эхээс авсан судалгааны үр дүн:

Нийт 253 эцэг, эхээс 6 төрлийн асуулга бүхий судалгаа авахад эцэг эхийн хяналт сул байдаг, хүүхдүүд нийгмийн сүлжээнд дарамт шахалтанд өртөж байгаагүй, хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэггүй, нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын талаар мэдлэг дунд эсхүл бага

зэрэг гэсэн хариултуудыг дийлэнх нь сонгосон байгаа бөгөөд тусгайлсан хууль гаргах нь зүйтэй гэсэн саналыг дийлэнх нь гаргасан байна.

Эцэг, эхчүүдээс нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн зохицуулалттай холбоотой дараах саналуудыг ирүүлсэн байна. Үүнд:

- хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай гэж боддог;
- эцэг эхчүүдийг цахим орчны мэдээллийг нэмэгдүүлэх;
- тусгайлан хууль гаргаж сайтар хамгаалах нь зүйтэй байна;
- цахим орчны хэрэглээг хянах, аль болох утасны хэрэглээг багасгаж өөр зүйлд анхаарлыг хандуулах спортын ямар нэг төрлөөр хичээллүүлэх;
- Нийгмийн сүлжээнд зарим мэдээллийг хаалттай болгох, хүүхэд нэвтэрдэг учраас хориотой үг хэл ашиглахыг таслан зогсоох болон хүчирхийлэлтэй мэдээлэл түгээхгүй байх;
- Эрхзүйн зохицуулалт байх хэрэгтэй гэж боддог. Ганц хүүхэд ч биш шүү дээ. Хүүхдүүдээ цаг үргэлж хянаж чадахгүй, цаг үргэлж цахим хэрэглээг нь хязгаарлаад байж болохгүй асуудал эцэг эх бүрт бий байх. Эрхзүйн зохицуулалттай болж ухуулга хийж байж хүүхэд ч, томчууд ч өөрийгөө ч өрөөл бусдыг ч хамгаалах сэтгэл зүйтэй болох байх гэж боддог;
- Тодорхой сайт вэбүүдэд нэвтрэх боломжгүй нас заах;
- Насанд хүрээгүй хүүхдүүдийг заавал нийгмийн сүлжээнд холбож байгаа нь таалагддаггүй. Ангийн групп нээчихээд тэндээ энэ тэр зар оруулна. Багш нар бүүр шөнийн 23 24цагт ангийнхаа хүүхдүүдэд зарын чанартай мэдээлэл оруулдаг. Одоо шалгалт энэ тэр мэдээллээ цахим групптэй оруулдаг энэ мэтээр хүүхдийг цахим орчноос хол байлгах нөхцөл бүрдэхгүй байна. Зарим нь бүр цахимаар гэрийн даалгавар өгнө гээд тараадаг;
- Энэ төрлийн зохицуулалт байх нь зөв. Гол нь эрх зүйн орчин болоод технологийн шийдэл нь сайн байх хэрэгтэй;
- FB -г тодорхой насанд хүрсэн хүн хэрэглэгч болдог. Гэтэл хичээл мэдээлэл нь бүгд FB-ээр дамжиж хүрч байна. Тиймээс ямар ч арга байхгүй хэрэглэгч болсон. Тиймээс хамгаална гэдгийг хэрхэн ойлгохоо мэдэхгүй байна;
- Хүүхдийн цахим орчин дахь хэрэглээ нь эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналттай шууд холбоотой учир түүнд чиглэсэн зүйл заалт оруулж хариуцлагыг өндөржүүлэх тал дээр анхаарах;
- эрх зүйн мэдээллийн талаар мэдээлэл өгөх;
- Сургуулийн эцэг эхчүүд нийлээд гар утас, PC-ний хэрэглээ хянах төлбөртэй цогц программ худалдаж авбал зүгээр байх;
- Энэ төрлийн гэмт хэрэг гарч л байгаа байх. Сайн хуульчилж өгөх ёстой;
- Шүүлтүүртэй мэдээллийг хүргэх;
- Нийгмийн сүлжээнд байршуулж байгаа мэдээлэлд тодорхой босго тавьж, мэдээлэл байршуулж байгаа эх сурвалжийг хянадаг байх шаардлагатай байна;
- Эцэг эхчүүд өөрсдөө анхаарах;
- Цахим орчины хэрэглээг багасгах зэрэг болно.

Дээр дурдсан асуултанд хариулт өгсөн агуулгыг ерөнхийд нь дүгнэн үзвэл эцэг, эх, асран хамгаалагч нар нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн орчинг бүрдүүлэх, хүүхдэд хүрч байгаа мэдээлэлд хяналт тавих, шүүлт хийх, тус асуудлыг нийтэд хүрэхүйц түгээх, сурталчилах зэрэг талаар дурдсан байна.

Судалгааны дүнг Хавсралт 2-оос дэлгэрүүлэн үзнэ үү.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон нь

Энэхүү хэсгээр тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон бөгөөд тэдгээрт нөлөөлж буй хэлбэрийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулахсудалгааны дүнд үндэслэн гаргасан болно.

Хүснэгт 1

Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1. Төрийн байгууллага, албан тушаалтан	-Нийгмийн сүлжээнд хүүхдийн хэрэглээг зохицуулсан зохицуулалт, зөв зохистой хэрэглээний талаар зөвлөмж гаргадаг боловч тухайн зөвлөмжийн хэрэгжилтийг буцаан аваагүй байна. -Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүүхдийн интернэт хэрэглээтэй холбоотой Эцэг эх, багш нарт зориулсан зөвлөмж, Үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан зөвлөмж, Бага насны хүүхдүүдэд зориулсан зөвлөмж⁵-ийг гаргаж өөрийн цахим хуудаст байршуулсан байх боловч зөвлөмжийн хэрэгжилт сул, түүнийг таниулан сурталчилах ажил сайтар хийдэггүй байна -Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт цахим орчны зөв зохистой хэрэглээний талаархи мэдээлэл хангалтгүй байгаатай холбоотойгоор цахим орчны зохистой хэрэглээний талаарх сургалтын гарын авлага, материал, модуль хөтөлбөртэй болох хэрэгцээ, шаардлага байна.

⁵ Бага насны хүүхдүүдэд зориулсан зөвлөмж (crc.gov.mn)

		- Цагдаа, прокурор, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлүүд тодорхой төрлийн шторк, гарын авлага, зөвлөмжүүд хийдэг боловч яг тухайн зорилтот бүлэгт хүрээгүй байна.
2.	Аж ахуйн нэгж, байгууллага	-Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь насанд хүрээгүй хэрэглэгчид хүрэх сөрөг мэдээллийг шүүгч програм хангамжийн мэдээллийг хэрэглэгчид хүргэх үүргийг хуульчилах шаардлагатай. -Аж ахуйн, нэгж байгууллага нь нийгмийн сүлжээнд сурталчилгаа, мэдээ, мэдээлэл түгээхдээ насанд хүрээгүй этгээдэд хориглосон агуулга бүхий мэдээлэлд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, хандалтыг хязгаарласан програм ашигладаггүй байна.
3.	Төрийн бус байгууллага	-Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэл бүхий төрийн бус байгууллагууд цөөнгүй байх боловч үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, хүүхдийн цахим орчны хэрэглээний талаарх судалгаа шинжилгээний ажил хийдэггүй, энэ талаарх сургалт, мэдээллийн арга хэмжээ хангалтгүй байна.
4.	Иргэн	- Цахим орчин хөгжих, илүү олон төрлийн платформ, үйлчилгээ нэмэгдэж буйтай холбоотой хүүхдийн интернэт хэрэглээний хугацаа нэмэгдэж, түүнд эцэг, эхийн зүгээс хяналт тавьдаггүй, -Эцэг, эхийн зүгээс нийгмийн сүлжээнд нэвтрэх хэрэгсэлд хяналтын программуудын тохиргоог идэвхижүүлдэггүй, - Интернэтийн хэрэглээтэй холбоотой хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөггүй, зарим тохиолдолд эцэг, эхийн интернэт хэрэглээний мэдлэг дутмаг байна.
5.	Бусад хүн, хуулийн этгээд	-Хүүхдийг зохисгүй контентоос хамгаалах зорилгоор хязгаарлалт хийх арга хэмжээг хэрэгжүүлдэггүй,

		-Цахим хэрэглээтэй холбоотой мэдлэг, мэдээлэл олгох хөтөлбөр, контент, сурталчилгаа дутмаг байна.
--	--	---

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон нь:

Хууль зүйн үндэсний хүрээлэн цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалтын талаарх хууль тогтоомжийг түүвэрлэн судлаад⁶ нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах талаарх эрх зүйн бие даасан, тусгай зохицуулалт Монгол Улсад дутагдалтай байгааг онцолжээ.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх зөрчигдсөөр байгааг статистикийн тоо баримтуудаас харж болно. Тодруулбал, “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал” судалгааны “Цахим орчны хүүхдийн эрхийн зөрчил” бүлэгт:

- *Гурван хүүхэд тутмын нэг нь цахим орчны хувийн нууц мэдээллээ хадгалах тохиргоог огт мэддэггүй бөгөөд эцэг, эхчүүдийн энэ талын мэдлэг нь хүүхдээсээ муу;*
- *Хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, таван хүүхэд тутмын дөрөв нь цахимаар зүй бус утгатай зурвас авдаг ба эцэг эхчүүдийн ийм төрлийн сөрөг мэдээллийг шүүх программ хангамжийг ашиглах чадвар 95 хувьд нь огт байхгүй байна;*
- *Интернэтийн байгууллага хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгаа эсэхийг 84 гаруй хувь нь асуугаагүй байна. Интернэтийн компаниуд бага насны хүүхэдтэй айлд сөрөг мэдээллийг шүүгч программыг заавал суулгуулах шаардлагатайг мэдээлэх үүргээ биелүүлэхгүй, нийгмийн хариуцлагаа ухамсарлахгүй байна;*
- *Гурван хүүхэд тутмын нэгнийх нь гар утасны дугаар өөр хүний нэр дээр бүртгэлтэй байна. Гар утасны дугаарыг хүүхдийн нэр дээр бүрэн бүртгэлжүүлснээр хориглосон буюу сөрөг нөлөө бүхий мэдээлэл хүлээн авахаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна.”⁷ гэсэн дүгнэлтэд хүрч, нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалах хууль шаардлагатай байгааг дурьджээ.*

Коронавирус (Ковид 19)-ын цар тахалын улмаас хүүхдийн интернэтийн хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор одоогийн хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг судалгааны үр дүнгээс харж болохоор байна. Тодруулбал, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар судалгааны тайлангийн Интернэтэд орох нь хэр зэрэг аюултай гэж үзэж байгаа талаарх асуулгын үр дүнд “хүүхдүүдийн 25% буюу 10 хүүхэд тутмын 2-3 нь хувийн мэдээллээ бусдад алдах аюултай гэж үзэж байна. Үүний дараа дөнгөж 9% нь хакердуулах, фейсбүүкийн нууц үг, бусад мэдээллээ алдах болон нүдний хараа

⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалт, 2017 он

⁷ www.fcy.gov.mn, Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан /албан хэрэгцээнд/, 2018 он, х26

муудах аюул бий гэж үнэлж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдүүд цахим орчны эрсдэлийн түвшинг хэт багаар дүгнэж байж болзошгүй зүйл харагдаж байна.”⁸ гэж дүгнэжээ.

Нийгмийн сүлжээнд үүсэх харилцаанаас үүдэлтэй гэмт хэргүүд (садар самуун үйлдэл хийлгэх зорилготой цахим өдөөлт, цахим шоглолт/зовоолт, гүтгэх, сэтгэл санааны хохирол учруулах, сэтгэл санаа болон бие махбодийн дарамтанд оруулах гэх мэт) сүүлийн жилүүдэд ихээр нэмэгдэж байгаатай холбоотой нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах асуудал нэн чухал болоод байна. Хүүхдийн хувийн мэдээлэл нь нийгмийн сүлжээнд нээлттэй, ил тод байх, эцэг, эхийн хараа хяналт сул зэрэг нь хүүхдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох нөхцлийг бүрдүүлж байна.

Түүнчлэн олон нийтийн дунд Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулахуламсар хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, хүүхдэд интернэтийг зүй зохистой ашиглах талаарх мэдлэг олгоход чиглэсэн иргэн, хуулийн этгээд болон төрийн болон бус байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн зохицуулалт дутмаг байна.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой зохицуулалт дутмаг байгаагаас цахим орчин дэх хүүхдийн эрхийн зөрчлийг шийдвэрлэхгүйгээр орхигдуулах нөхцөл байдалд хүрч байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН НЬ

Нийгмийн сүлжээ, цахим платформын хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, хүүхдийн өдөр тутмын амьдрал, боловсрол, харилцаа холбоо, мэдээлэл авах орчинд гүнзгий нэвтэрч байгаатай холбоотойгоор хүүхдийн цахим орчин дахь эрх, оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудал нь төрөөс онцгойлон анхаарах шаардлагатай нийгмийн харилцааны нэг болоод байна.

Цахим орчин нь хүүхдийн суралцах, хөгжих, мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, бусадтай харилцах боломжийг нэмэгдүүлж байгаа боловч нөгөө талаас цахим дарамт, заналхийлэл, хүчирхийлэл, мөлжлөг, хувийн мэдээллийн зөрчил, зохисгүй болон хортой контент, донтох эрсдэл, сэтгэл зүйн сөрөг нөлөөлөл зэрэг шинэ төрлийн эрсдэлийг бий болгож байна.

Иймд нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах асуудлуудыг судлан тодруулж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу дээрх асуудлуудыг шийдвэрлэх зорилгыг томьёолсон болно.

Асуудлыг шийдвэрлэх зорилго нь нийгмийн сүлжээнд хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахим дарамт, заналхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо, эрх зүйн үндсийг тогтооход чиглэгдсэн Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулахад оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

⁸ Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар судалгааны тайлан (crc.gov.mn)

1. **Хүүхдийн нийгмийн сүлжээн дэх эрх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;** Хүүхдийн хувийн мэдээлэл, цахим мөр, харилцаа холбоо, цахим хэрэглээтэй холбоотой мэдээллийг хууль бусаар цуглуулах, ашиглах, түгээх, гуравдагч этгээдэд дамжуулах зэрэг эрсдэлээс хамгаалах, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хамгаалалтын зохицуулалтыг бий болгоно.
2. **Цахим платформ, нийгмийн сүлжээ болон үйлчилгээ эрхлэгчдийн хүүхэд хамгааллын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;** Нийгмийн сүлжээ, цахим платформ, интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хүүхдэд сөрөг нөлөө бүхий контентын хандалтыг хязгаарлах, нас баталгаажуулах, хүүхдийн нууцлал хамгаалах, мэдээлэл устгах, гомдол мэдээлэл шийдвэрлэх зэрэг хүүхэд хамгааллын үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
3. **Эцэг, эх, асран хамгаалагч, боловсролын байгууллага болон бусад этгээдийн оролцоо, үүргийг тодорхойлох;** Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийн цахим хэрэглээнд зохистой хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвартай байх, боловсролын байгууллага хүүхдэд цахим боловсрол олгох, цахим орчны аюулгүй хэрэглээний талаарх мэдлэг, дадлыг төлөвшүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.
4. **Төрийн байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоо, хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох;** Хүүхдийн эрх хамгаалал, цахим хөгжил, боловсрол, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, хяналт, шуурхай арга хэмжээ авах тогтолцоог тодорхой болгож, салбар хоорондын зохицуулалтыг сайжруулна.
5. **Нийгмийн сүлжээн дэх хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх;** Хүүхэд, эцэг эх, хууль ёсны төлөөлөгчөөс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, контентыг хязгаарлах, устгах, холбогдох байгууллагад шилжүүлэх үйл ажиллагааг түргэн шуурхай, чирэгдэлгүй хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгоно.
6. **Хүүхдийн цахим боловсрол, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих;** Хүүхдэд цахим орчны эрсдэл, зохистой хэрэглээ, хувийн мэдээллээ хамгаалах мэдлэг олгох, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
7. **Хүүхдийг сөрөг нөлөө бүхий контент болон цахим эрсдэлээс хамгаалах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;** Хүүхдэд зориулсан default хамгаалалтын тохиргоо, насны ангилал, эцэг эхийн хяналтын хэрэгсэл, контент шүүх технологи, шөнийн хэрэглээний

хязгаарлалт зэрэг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг эрх зүйн хүрээнд тодорхойлно.

8. **Нийгмийн сүлжээн дэх хүүхэд хамгааллын талаар олон улсын чиг хандлага, стандартад нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн хорооны Ерөнхий тайлбар №25 болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн хүүхдийн цахим орчин дахь эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Ийнхүү дээрх зорилго, зорилтыг хэрэгжүүлснээр нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохистой болгох, хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим дарамт, заналхийлэл, хортой контент, хувийн мэдээллийн зөрчил болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн үндэс бүрдэх юм.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЗЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН НЬ

Асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлахдаа Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан **“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”**-ын 5 дугаар зүйлд заасан зохицуулалтын хувилбар тогтоох аргачлалыг баримталсан болно.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалттай холбоотой харилцаа нь өнөөгийн байдлаар Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжид салангид, ерөнхий байдлаар тусгагдсан байна. Гэвч хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалт, платформын үүрэг, хариуцлага, нас баталгаажуулалт, хүүхдэд ээлтэй анхдагч хамгаалалтын тохиргоо, хортой контентын хязгаарлалт, алгоритмын нөлөөлөл, цахим дарамт, заналхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх зэрэг шинэ төрлийн харилцааг бүрэн хамарч чадахгүй байна.

Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгод хүрэхийн тулд Аргачлалын 5.1-д заасан дараах хувилбаруудыг харьцуулан авч үзэв. Үүнд:

- 5.1.1. “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
- 5.1.2. хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
- 5.1.3. зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- 5.1.4. төрөөс санхүүгийн интервенц хийх;
- 5.1.5. төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
- 5.1.6. захиргааны шийдвэр гаргах;
- 5.1.7. хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Энэхүү тайлангийн 1.3 дахь хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг зэрэгцүүлэн авч үзвэл:

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	“Тэг” хувилбар	Өнөөгийн үүсэж байгаа асуудал, бэрхшээл хэвээр үлдэнэ. Зорилгод хүрэх боломжгүй.	Зардал нэмэгдэхгүй боловч үүссэн асуудал шийдвэрлэгдэхгүй.	Үр дүнгүй
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг дан ганц хэвлэл мэдээллийн болон бусад хэрэгслээр олон нийтэд хандсан ухуулга сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил хийх нь хүлээгдэж байгаа үр дүнд хүрэх хангалттай арга хэмжээ болж чадахгүй юм.	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулга хийх нэмэлт зардал гарах боловч энэ талаар хийгдэж буй арга хэмжээ асуудлыг шийдэхгүй. Гэхдээ нэмэлт байдлаар энэ зохицуулалтын хувилбарыг ашиглах боломжтой байна.	Үр дүн хангалттай бус
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх тохиолдолд хүний нөөц, техник, технологийг бэхжүүлэх боломжтой ч зорилгыг бүрэн хамарч чадахгүй.	Ихээхэн зардал шаардлагатай. Үр өгөөж нь хүний нөөц, техник, технологийг бэхжүүлэх хэдий ч зорилгод хүрэхгүй.	Үр дүнгүй
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг	Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй.	Тодорхой зардал гарах хэдий ч үр өгөөж нь бага.	Үр дүнгүй

	үүрэг гүйцэтгүүлэх	Харин эдгээр байгууллагууд зах зээлийн механизмаар нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах хангах үйл ажиллагаанд оролцох боломжтой.		
6.	Захиргааны шийдвэр гаргах	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зохицуулагдаагүй байгаа харилцааг зохицуулах боломжтой болж зорилгыг бүрэн хангах боломжтой.	Зардал гарах боловч үр өгөөж нь зорилгод хүрэхүйц байна.	Үр дүнтэй

Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулж үзэхэд хууль тогтоомж батлан гаргах хувилбар нь хамгийн оновчтой хувилбар гэж үзэж байна. Түүнчлэн энэхүү тайланд дурдсан асуудал нь хүүхдийн эрхтэй шууд хамааралтай тул “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.4.1-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөл хэрэгжүүлэх хувилбарыг шууд сонгохоор байгаа нь эдгээр асуудлуудыг зохицуулах хүрээнд хууль тогтоомж батлан гаргах хувилбар нь хамгийн сайн хувилбар мөн гэдгийг давхар нотолж байна.

Иймд хуулийн төслийн агуулга, зохицуулалтыг өмнө тодорхойлсон зорилгын дагуу дараах ерөнхий байдлаар томъёолж байна. Өөрөөр хэлбэл, энэхүү хуулийн төсөл нь нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой байна.

ДӨРӨВ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН НЬ

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газраас баталсан аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Энэ талаарх тодорхой хариултыг Хавсралт 3-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхийн нэг хэсэг томоохон салаа мөчир бол хүүхдийн эрх мөн. Нэгдсэн Үндэсний Байгууллагын (НҮБ) Хүүхдийн эрхийн тухай Конвенц буюу хүүхдийн эрхийн тухай цогц хэм хэмжээ бүхий баримт бичгийг 1989 оны 11-р сарын 20-ны өдөр баталснаас хойш 193 орон нэгдэн орсон ба уг конвенцод Монгол Улс 1990 онд нэгдэн орсон байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 2-р зүйлд хүүхэд гэдэг 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ гэж заасан. Тухайн конвенцод хүүхдийн суурь дөрвөн

эрхийг заасан нь амьд явах эрх, хөгжих эрх, хамгаалуулах эрх болон оролцох эрх юм.

Гэвч мэдээллийн технологи хурдацтай хөгжихийн хэрээр олон нийтийн сүлжээг түлхүү ашиглаж өөрийн үзэл бодол, байр суурийг цахим хуудас, инстаграм /instagram/ юүтүб /youtube/, фэйсбүүк /facebook/, твиттер-х /x/, тик-ток /Tik-tok/ гэх мэт сүлжээг ашиглаж үзэл бодол, санал сэтгэгдлээ бичиж байгаа нь нэг талаас хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талбар хэдий ч нөгөө талаас хүүхдийн эрх, тэдгээрийн эсэн мэнд амьдрах, хөгжих зэрэг ялгаварлалтаас ангид байх, хүүхдэд ээлтэй орчинг бий болгох гэх мэтчилэн хүүхдийн эрхийг хөндсөөр байна.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөө, түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах эерэг нөлөө үзүүлнэ. Тухайлбал, интернэт дэх хууль бус агуулгыг хориглох, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийг устгах, нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх баталгаажих зэрэг эерэг нөлөө үзүүлнэ.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлд Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг тусгасны дагуу хүүхэд, өсвөр үеийнхнийг дэлгэцийн донтолт, цахим орчны гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн техник, технологийн зохистой хэрэглээг дэмжиж ажиллах чиглэлээр НҮБ-ын Хүүхдийн сан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран ажиллах зэргээр эерэг нөлөө бий болно.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас салбар дундын зохицуулалтыг ханган ажиллах хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 2019 оноос эхлэн олон улсын “Бид хамгаална” загварыг хэрэгжүүлж, цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа ба үүнтэй холбогдуулан цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах төрлийн ажиллагааг хөхиүлэн дэмжих үр нөлөөтэй байна.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүйн зэрэгцээ техникийн тусламжтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд шүүлтийн програм ашиглах (filtering), техникийн тусламжтай агуулгын

рейтинг тогтоох, хор хөнөөлтэй агуулгыг шошголох (labeling), хүүхдийн насыг магадлах систем бий болгох (age verification system) зэрэг нийгмийн техникийн хөгжлийн арга хэлбэр ашиглаж, нийгэмд илүү эерэг орчин үүсгэнэ.

Түүнчлэн хүүхэд ихээр цуглардаг орчин /жишээ нь: боловсролын байгууллагууд/-оор бүсчлэн зохицуулах арга, хүүхдэд зориулсан тусгай сайтуудыг ажиллуулах, олон нийтийн дунд энэ талаарх ухамсар хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах зэргээр нийгмийн хөгжилд эерэг үр нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой бүрнээ нийцэх юм.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлалын 5.1-д зааснаар үүсэн бий болсон асуудлыг зохицуулах хувилбарыг дараах байдлаар тодорхойлсон:

- “Тэг” хувилбар;
- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
- Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- Төрөөс санхүүгийн интервенц хийх;
- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
- Захиргааны шийдвэр гаргах;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлалын 7.1-д зааснаар эдгээр хувилбаруудаас хэд хэдэн хувилбар санал болгосон бол тэдгээрийн эерэг болон сөрөг үр нөлөөг харьцуулж, дүгнэлт хийхээр байна. Бидний санал болгосон хувилбар нь гагцхүү хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар байгаа тул бусад зохицуулалтын хувилбаруудтай

харьцуулан дүгнэлт хийх шаардлага үүсэхгүй юм. Харин ийнхүү хууль тогтоомжийн төслийг боловсруулж, хэрэгжүүлснээр Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн дагуу хүлээсэн үүргүүд болон Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасан хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах зорилго хангагдахын зэрэгцээ Арван зургадугаар зүйлийн 2, 13, 14, 17 хэсгүүдэд тус тус заасан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй, чөлөөтэй байх хүний үндсэн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах зорилго хангагдахын сацуу нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэсэн нэгдсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Тус хуулийг хэрэгжүүлснээр төр болон иргэнд зардлын ачаалал бий болгохгүй юм.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Бид олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийхдээ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 8.3-т заасан “эрх зүйн соёл түүх, газар зүйн байршил, эрх зүйн эх сурвалжийн ангилал”⁹-ыг харгалзан үзсэний зэрэгцээ нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг баталж, жишиг болгон хөгжүүлж чадсан улс орнуудыг сонгосон болно.

НЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

6.1. АВСТРАЛИ УЛСЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Австрали улс 2015 онд Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийг баталсан бөгөөд 2021 онд өргөжүүлж Цахим аюулгүй байдлын тухай хууль¹⁰-ийг баталсан ба тус хууль нь 2022 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэхүү хуулийн онцлог нь насанд хүрээгүй хүүхэд болон насанд хүрсэн Австрали хүн бүрт үйлчилж байгаагаар онцлог юм. Тус хууль нь нийт 16 хэсэг, 240 зүйлээс бүрдэх төрөлжсөн хууль юм. Нийт 209 хуудсаас бүрдэх тус хуулийн хуулийн зорилт нь:

(а) Австраличуудын цахим орчны аюулгүй байдлыг сайжруулах; болон

(б) Австраличуудын цахим орчны аюулгүй байдлыг дэмжих¹¹ болно.

Тус хуулийн 5 дугаар зүйлд нэр томъёоны тодорхойлолтыг оруулж өгсөн бөгөөд “хүүхэд” гэдэг нь 18 насанд хүрээгүй хүнийг хэлнэ гэж заасан. Тус хуулийн 6 дугаар бүлэгт хүүхдийн цахим гадуурхалт, дээрэлхэлтийн талаарх ойлголтыг тодорхойлсон ба дараа дараагийн холбогдох бүлэгт энэ талаарх гомдлыг хэрхэн гаргах, хаана гаргах, хянан шалгах зэрэг ажиллагаануудыг нарийвчлан заасан байсан.

⁹ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлалын 8.3

¹⁰ 2021 оны Австрали улсын Цахим аюулгүй байдлын тухай хууль

¹¹ 2021 оны Австрали улсын Цахим аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйл

Тус хуульд 2024 оны 12 дугаар сард өөрчлөлт оруулсан бөгөөд тус өөрчлөлтөөр 16 хүртэлх насны хүүхдийн цахим хэрэглээг бүрэн хаахаар зохицуулсан.

Тодруулбал, Австралийн хүүхдүүдийн 80 хувь нь Youtube, TikTok, Instagram, Snapchat зэрэг платформыг ашигладаг бөгөөд ямар нэгэн насны хязгаарлалт байхгүй, хяналтын механизм хангалтгүй зэргээс шалтгаалан насанд хүрээгүй хүүхэд ямар нэгэн шүүлтүүргүйгээр мэдээ, мэдээллийг авах, гэмт хэргийн хохирогч болж байгаа тул ийнхүү хуулийн шаардлагатай арга хэмжээг авч буйгаа зарлажээ.

Тус хуулийн дагуу нийгмийн сүлжээний платформ хөгжүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд 16-аас доош насны хүүхдийг нэвтрүүлэхгүй, хаяг үүсгэхгүй байх үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргээ биелүүлээгүй бол торгуулийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Нөгөө талаар энэ нь тухайн хүүхэд болон эцэг, эхэд ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй байх талаар мөн дурджээ.

6.2. АНУ-ЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

АНУ-ын нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжид дараах хуулиуд хамаарна. Үүнд:

1. Нийгмийн сүлжээнд хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (COPPA). Энэхүү актыг 1998 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталсан бөгөөд 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Энэхүү акт нь 13-аас доош насны хүүхдүүдийн хувийн мэдээллийг цуглуулахад үйлчилнэ. Цахим хуудасны оператор нууцлалын бодлогодоо ямар мэдээлэл оруулах болон эцэг, эх, асран хамгаалагчаас баталгаажуулах зөвшөөрлийг хэзээ, хэрхэн авах, мөн 13-аас доош насныхны маркетинг хязгаарлах зэрэг хүүхдийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалахад оператор ямар үүрэг хариуцлага хүлээх зэргийг нарийвчлан тусгасан. Хэдийгээр 13-аас доош насны хүүхдүүд эцэг, эхийнхээ зөвшөөрлөөр хувийн мэдээллээ өгч болох боловч олон цахим сайтууд, ялангуяа олон нийтийн сүлжээний сайтууд зардал, ажлын ачаалал зэргээс шалтгаалан 13-аас доош насны хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэхээс татгалздаг, мөн тэднийг өөрсдийнхөө цахим хуудсыг ашиглахыг хориглодог байна.

Энэхүү хууль нь дараах агуулга бүхий 12 зүйлээс бүрдэнэ: 1. Хүүхэд, 2. Оператор, 3. Комисс, 4. Ил болгох, 5. Холбооны агентлаг, 6. Интернэт, 7.Эцэг, эх, 8.Хувийн мэдээлэл, 9. Эцэг, эхийн баталгаажуулсан зөвшөөрөл, 10. Хүүхдэд чиглэсэн цахим хуудас эсхүл цахим үйлчилгээ, 11. Этгээд, 12. Цахим хаяг тус тус орно.

2. Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль (CIPA)- Энэхүү хуулийг АНУ-ын Конгресс 2000 онд баталсан бөгөөд хүүхдүүд интернэт ашиглан садар самуун эсвэл хор хөнөөлтэй контентод нэвтрэхийг хязгаарлах зорилготой болно. CIPA нь E-rate хөтөлбөрөөр дамжуулан интернэт холболт эсвэл дотоод холболтын хөнгөлөлт авдаг сургууль, номын сангуудад тодорхой шаардлага тавьдаг. Энэхүү хөтөлбөр нь тухайн шаардлага хангасан сургууль, номын сангуудад тодорхой харилцаа холбооны үйлчилгээ, бүтээгдэхүүнийг илүү хямд болгох

хөтөлбөр байдаг. 2001 оны эхээр Холбооны улсын харилцаа холбооны комисс (FCC) нь CIPA-г хэрэгжүүлэх дүрмийг гаргаж, 2011 онд тус дүрмийг шинэчилсэн байна.

Хэрэв CIPA-д хамрагдах сургууль, номын сангууд нь технологийн хамгаалалтын арга хэмжээг багтаасан интернэтийн аюулгүй байдлын бодлоготой гэдгийгээ нотлож баталгаажуулаагүй бол E-rate хөтөлбөрийн хөнгөлөлтийг авахгүй болно. Хамгаалалтын арга хэмжээ нь дараах дүрс зургуудын интернэтийн хандалтыг хаах буюу шүүх ёстой: (а) садар самуун; (б) хүүхдийн порнограф; эсвэл (в) насанд хүрээгүй хүмүүст хор хөнөөлтэй (насанд хүрээгүй хүмүүсийн ханддаг компьютерийн хувьд) дүрс зураг зэрэг болно. Энэхүү интернэтийн аюулгүй байдлын бодлогыг батлахаас өмнө сургууль, номын сангууд нь зохих мэдэгдэл гаргаж, нэгээс доошгүй нийтийн сонсгол, уулзалт зохион байгуулж, санал, хүсэлтийг шийдвэрлэнэ.

CIPA-д хамрагдах сургуулиудыг гэрчилгээ олгохдоо дараах хоёр нэмэлт шаардлагыг тавьдаг: 1) интернэтийн аюулгүй байдлын бодлогод насанд хүрээгүй хүүхдүүдийн цахим үйл ажиллагаанд хяналт тавих; 2) XXI зуунд Хүүхдийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу насанд хүрээгүй хүүхдүүдэд нийгмийн сүлжээний цахим хуудас, чат өрөөнд бусад хүмүүстэй харилцах, цахим дарамтын тухай ойлголт, хариу арга хэмжээ авах зэрэг нийгмийн сүлжээнд зохистой зан үйлийг төлөвшүүлэх талаар сургах ёстой.

CIPA-д хамрагдах сургууль, номын сангууд дараах асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн интернэтийн аюулгүй байдлын бодлогыг баталж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Насанд хүрээгүй хүмүүсийн интернэт дэх зохисгүй зүйлд хандах, аюулгүй байдал;
- Цахим шуудан, чат өрөө болон шууд цахим харилцааны бусад хэлбэрийг ашиглах үед насанд хүрээгүй хүмүүсийн аюулгүй байдал;
- Насанд хүрээгүй хүмүүсийн нийгмийн сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх, үүнд "хакердах" болон бусад хууль бус үйлдлийг хориглох;
- Насанд хүрээгүй хүмүүсийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй задруулах, ашиглах, тараахыг хориглох;
- Хүүхдэд хор хөнөөлтэй материалд нэвтрэх эрхийг хязгаарлах арга хэмжээ.

CIPA нь зөвхөн харилцаа холбооны үйлчилгээнд хөнгөлөлт авдаг сургууль, номын сангуудад үйлчилдэггүй бөгөөд сургууль, номын сангууд E-rate-ийн санхүүжилт авахаасаа өмнө CIPA-ийн шаардлагад нийцэж байгаа эсэхээ баталгаажуулах хэрэгтэй байдаг.

Эрх бүхий этгээд нь шударга ёс болон хууль ёсны бусад зорилгод нийцүүлэн нэвтрэх боломжийг чөлөөтэй олгохын тулд насанд хүрсэн хүн тухайн цахим орчныг ашиглах үед хаалтын эсвэл шүүлтийн программыг идэвхгүй болгож болно.

CIPA нь насанд хүрээгүй эсвэл насанд хүрэгчдийн интернэтийн хэрэглээг хянадаггүй болно.

3.Нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах тухай хууль (СОРА)- Энэхүү хуулийг АНУЛс 1998 онд баталсан бөгөөд Интернэт дэх насанд хүрээгүй хүүхдэд хор хөнөөлтэй гэж тодорхойлсон аливаа материалд насанд хүрээгүй хүмүүсийн хандалтыг хязгаарлах зорилготой байсан боловч 2009 онд болсон гурван ч удаагийн шүүх хурлаар тус хуулийн эсрэг байнгын ажиллагааг идэвхижүүлсэн тул хүчин төгөлдөр болоогүй.

СОРА нь "насанд хүрээгүй хүүхдэд хортой мэдээлэл"-ийг нийтэлдэг бүхий л арилжааны эрхлэгчдийг өөрсдийн сайтад насанд хүрээгүй хүмүүсийн нэвтрэх эрхийг хязгаарлахыг шаардсан байсан.

4. Хориннэгдүгээр зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль- Видео үйлчилгээ үзүүлэгчид хүүхдийн порнограф гаргахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийг цахим орчин дахь түрэмгийлэгч нараас хамгаалах, улс хоорондын худалдаанд хүүхдийн хувийн мэдээллийг худалдах, худалдан авахыг хязгаарлах зорилгоор 1934 оны Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль юм.

6.3 ЯПОН УЛС- ХҮҮХЭД АЮУЛГҮЙ, ТАЙВАН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭХ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ (2008 ОН)

Энэхүү хууль нь нийгмийн сүлжээнд хүүхдэд хор хөнөөлтэй мэдээлэл түгэн тархсантай холбогдуулан интернэтийг зөв зохистой хэрэглэх чадварыг хүүхдэд суулгахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, тус хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн (filtering) програм хангамжийн ажиллагааг дээшлүүлэх, түүний хэрэглээг түгээн дэлгэрүүлэх, тухайн хор хөнөөлтэй мэдээллийг хүүхэд интернэтээс үзэх боломжийг аль болох багасгах арга хэрэгслийг тодорхойлох замаар хүүхдийн эрхийг хамгаалах зорилготой болно.¹²

Тус хуулиар хүүхдийн интернэтийн зөв зохистой хэрэглээтэй холбоотой үндсэн төлөвлөгөө, боловсрол, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжих, хүүхэд интернэтээс хор хөнөөлтэй мэдээлэл олж үзэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эцэг, эх, асран хамгаалагч, төрийн захиргааны байгууллага, гар утас, интернэтийн оператор компани, хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн (filtering) програм хангамж зохион бүтээгч зэрэг тус харилцаанд оролцогч этгээдүүдийн үүрэг, оролцоо, интернэтийн зөв зохистой хэрэглээтэй холбоотой олон нийтийн байгууллын дэмжлэг, хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн (filtering) үйл ажиллагаа хөгжүүлэгчийн бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулна.

6.4 ИТАЛИ УЛС-ХҮҮХДИЙН ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛ, ГАДУУРХАЛТАЙ /CYBER-BULLYING/ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ (2017 ОН)

Тус хуулиар нийгмийн сүлжээнд хүүхдийг доромжилсон эсвэл нэр төрийг гутаасан мэдээлэл нийтлэх, интернэтээр айлган сүрдүүлэх эсвэл хувь хүний мэдээллийг хулгайлахыг хориглосон. Нийгмийн сүлжээнд дээрэлхүүлж, гадуурхагдсан хохирогч нь тус агуулгыг нийтлэлсэн цахим хуудас эрхлэгчээс тухайн

¹² <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=420AC10000000079>

мэдээллийг 48 цагийн дотор устгах шаардлага гаргаж болно. Уг хуулиар Итали Улсад цахим дээрэлхэл, гадуурхал /cyber-bullying/ гэдэг ойлголтыг хууль зүйн талаас анх удаа тодорхойлж, нийт сургуулиудад интернэт орчин дахь хариуцлагын талаар сурагчдад боловсрол олгох, цахим дээрэлхэл, гадуурхал, цахим орчны зөрчлийг илрүүлж, тэмцэх ажлыг хариуцсан ажилтантай байх шаардлагыг тавьж өгсөн.

6.5 БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь цахим аюул заналхийлэл, эрсдэлийн талаар мэдлэгтэй байх, цахим эрин үед интернэт хэрэглэгчдийн хувьд хүүхдүүдийн аюулгүй байдал, хувийн нууцыг хамгаалах мэдлэгтэй байхын зэрэгцээ үйлчлэх боломжтой нэгдсэн хууль тогтоомж, үр дүнтэй техник, захиргааны болон нийгмийн арга хэмжээ авах шаардлагатай гэж үздэг. БНСУ-ын Үндсэн хууль нь иргэний үндсэн эрх чөлөөг баталгаажуулж, хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн эрх чөлөөг зохицуулсан ерөнхий заалтыг агуулдаг бөгөөд тусгай хуулиудад хүүхдийн боловсрол, сайн сайхныг зохицуулсан байдаг.

БНСУ-ын Үндсэн хууль¹³-ийн:

21-р зүйлийн (4): “Үг хэллэг, хэвлэл мэдээллийн аль нь ч бусдын нэр төр, эрхийг зөрчиж, олон нийтийн ёс суртахуун, нийгмийн ёс зүйг гутааж болохгүй.”;

37-р зүйлийн (2): “Үндсэн хуульд нэмэлтээр “үндэсний аюулгүй байдал, хууль, хэв журмыг сахиулах, нийтийн сайн сайхны төлөө” шаардлагатай бол Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хязгаарлаж болно” гэж тус тус заасан байдаг.

Сүлжээний хэрэгжилтийн тухай хууль¹⁴ /Мэдээлэл, харилцааны сүлжээний ашиглалт, мэдээллийн хамгааллыг дэмжих ажиллагаа/ 2016-ийн:

44-р зүйлийн (5): Интернэтэд жинхэнэ нэрээр бүртгүүлэх (ЖНБ) систем нь 2007 онд танилцуулагдсан. Энэ хуулийн нэг хэсэг болсон тус систем нь 2010 онд БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхэд маргаан дагуулж шийдвэрлэгдэж байсан ба шүүхийн 2010 Хёон Ма 47, 252¹⁵ дугаартай хэрэгт энэ хуулийн 44-р зүйлийн 5 дугаарт заасан жинхэнэ нэрээр бүртгүүлэх системийг Үндсэн хуульд харш гэж үзсэн.

Энэ системийг танилцуулах шалтгаан бол үндэслэлгүй цуурхал, цахим дээрэлхэл, гадуурхалыг зогсоох болон хувийн нууцад халдах зэрэг гэмт хэргээс урьдчилан хамгаалах зорилгоор интернэтэд нэвтрэхээс өмнө нь интернэт хэрэглэгчдийн хэн болохыг баталгаажуулахыг шаарддаг байна. ЖНБ системийг үг хэлэх эрх чөлөөг зөрчсөн гэх үндэслэлээр 2012 онд Үндсэн хуулийн шүүхэд хандсан байна. Үндсэн хуулийн шүүх уг системийг үндсэн хуульд харш гэж үзсэн боловч ЖНБ-ийн зорилгыг хууль ёсны хэмээн үзсэн. Мөн хувийн мэдээллийг хулгайлах хэд хэдэн тохиолдлоос болж ЖНБ-ийг цуцалсан боловч интернэтэд нэвтрэх боломжийг олгох Ай-пин системийг нэвтрүүлсэн явдал нь онцлох хэсэг болсон.

¹³ <http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/67127/98324/F2042155478/KOR67127%20English.pdf>

¹⁴ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38422&lang=ENG

¹⁵ <http://opennetkorea.org/en/wp/wp-content/uploads/2014/03/Korean-real-name-law-decision-english.pdf>

Солонгос улс цахим бүртгэлийн тогтолцоондоо хүүхдийн насыг магадлан тогтоох программыг ашигладаг ба энэхүү программ нь нийгмийн сүлжээнд хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалахад зориулагдсан. Түүнчлэн тус улс интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудаас хүүхдэд хор хөнөөлтэй мэдээллийн шүүлтийн программ ашиглаж байхыг үүрэг болгон хуульчилсан байдаг.

Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай хууль¹⁶

Энэхүү хуулиар сурагч хариуцсан албанд өргөдөл гаргаж буй хохирогч сурагчдыг сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлж, таатай нөхцөл байдлыг төлөвшүүлэх зорилгоор хохирогч, түрэмгийлэн халдагч сурагчдыг хооронд нь эвлэрүүлэх замаар суралцагчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Тус хуульд “Цахим дээрэлхэл, гадуурхал” гэдгийг интернэт, гар утас болон бусад мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслээр суралцагчид тодорхой сурагчийн хувийн мэдээллийг задруулах, эсвэл тухайн сурагчийн талаар худал, цуурхал тараах зорилгоор бусад сурагчдын сэтгэл санааг хохироож, зовлон шаналалд унагах, улмаар байнга болон давтан үйлдэх аливаа хэлбэрийг хэлнэ¹⁷ гэж тодорхойлсон бол “сургууль” гэж Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль, тусгай сургууль, төрөлжсөн сургуулийг, мөн дээрх хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу үйл ажиллагаа явуулж буй сургуулийг хэлнэ¹⁸ гэж заасан.

6.6 ШВЕД УЛС

Швед Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид 1990 онд нэгдэн орж, 2020 оны 1-р сарын 1-нд дотоодын хууль тогтоомжуудаа уялдуулсан байна¹⁹. Цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд ерөнхий дэмжлэг болгох зохицуулалтыг Мэдээллийг хамгаалах ерөнхий журам /GDPR/²⁰-д тусгасан.

Швед Улс нь Европын Холбоонд 1995 оны 1 сарын 1-ны өдөр нэгдэн орсон тул Европын Холбооны хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт²¹ тус улсад үйлчилнэ.

Европийн Холбооны Цахим худалдааны заавар (Directive on electronic commerce)-т тусгаснаар аж ахуйн нэгжүүд нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах талаарх ёс зүйн дүрэмтэй байх, үүнийгээ хэрэгжүүлэн ажиллах шаардлагыг

¹⁶ <https://law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=199081&viewCls=engLsInfoR&urlMode=engLsInfoR#0000>

¹⁷ Сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эсрэг арга хэмжээ авах тухай хуулийн 1-3 дах зүйл

¹⁸ Сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эсрэг арга хэмжээ авах тухай хуулийн 2.2 дах зүйл

¹⁹ <https://www.togetherscotland.org.uk/news-and-events/news/2018/06/sweden-to-incorporate-the-uncrc-into-law/>

²⁰ https://gdprhub.eu/Data_Protection_in_Sweden

²¹ [https://downloads.unicef.org.uk/wp-](https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC_united_nations_convention_on_the_rights_of_the_child.pdf?_adal_sd=www.unicef.org.uk.1644975131543&_adal_ca=so%3DGoogle%26me%3Dorganic%26ca%3D(not%2520set)%26co%3D(not%2520set)%26ke%3D(not%2520set).1644975131543&_adal_cw=1644975110033.1644975131543&_adal_id=3f637e28-b702-4661-be5e-dba9ea34294b.1644975110.2.1644975110.1644975110.b9ec6fed-1206-411e-a88c-0c3be100d0de.1644975131543&_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109)

[content/uploads/2010/05/UNCRC_united_nations_convention_on_the_rights_of_the_child.pdf?_adal_sd=www.unicef.org.uk.1644975131543&_adal_ca=so%3DGoogle%26me%3Dorganic%26ca%3D\(not%2520set\)%26co%3D\(not%2520set\)%26ke%3D\(not%2520set\).1644975131543&_adal_cw=1644975110033.1644975131543&_adal_id=3f637e28-b702-4661-be5e-dba9ea34294b.1644975110.2.1644975110.1644975110.b9ec6fed-1206-411e-a88c-0c3be100d0de.1644975131543&_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109](https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC_united_nations_convention_on_the_rights_of_the_child.pdf?_adal_sd=www.unicef.org.uk.1644975131543&_adal_ca=so%3DGoogle%26me%3Dorganic%26ca%3D(not%2520set)%26co%3D(not%2520set)%26ke%3D(not%2520set).1644975131543&_adal_cw=1644975110033.1644975131543&_adal_id=3f637e28-b702-4661-be5e-dba9ea34294b.1644975110.2.1644975110.1644975110.b9ec6fed-1206-411e-a88c-0c3be100d0de.1644975131543&_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109)

тогтоосон²². Үүний зэрэгцээ Европын Холбооны Дуу дүрс бичлэгийн хэвлэл мэдээллийн үйлчилгээний тухай заавар (EC Directive of the Audiovisual Media Services 2010/13/EU)-д хэрэглэгчдийн хүсэлтээр интернэтээр нэвтрүүлэг түгээгч нь хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс, мөн зохисгүй зар сурталчилгаанаас хамгаалах ёстой байх тухай заасан нь хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах маш чухал зохицуулалт болсон²³.

Түүнчлэн 2011 онд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүүхдийн порнографтай тэмцэх тухай заавар батлагдсан ба энэхүү хүрээнд нийгмийн сүлжээнд хүүхдийн порнограф үзүүлэх болон “садар самуунд уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох” гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхаар тусгасан²⁴. Мөн Европын холбоо нь гишүүн орнуудын нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд байнга үнэлэлт, дүгнэлт өгч байх эргэх холбоог хэрэгжүүлдэг.

Швед Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын оролцогч тул нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг тус конвенцын хүрээнд тодруулах нь чухал. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3-р зүйлд Хүүхдийн талаарх бүх арга хэмжээ, шийдвэрийг гаргахдаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг харгалзан үзэх ёстой гэж заасан байх ба конвенцод тусгасан бүх эрхийг хүүхдэд холбоотой асуудалд хамааруулахгүй боловч үндсэн дөрвөн зарчим баримтлах шаардлагатай байдаг.

Швед Улс интернэтийн аюулгүй орчин хөтөлбөрийн хүрээнд салбарын өөрийн зохицуулалт мөн төрийн болон салбарын хамтарсан зохицуулалтын дагуу гурван гол арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд: уг салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг ёс зүйтэй байхыг хөхиүлэн дэмжих замаар ёс зүйн дүрэмтэй болох; контентын шүүлтийн болон чансаа тогтоох технологи хөгжүүлэх; эцэст нь олон нийтийн дунд энэ талаарх ухамсарыг дээшлүүлэх арга хэмжээг авдаг.

Швед Улсын мэдээлэл хамгаалах ерөнхий журам /Хүүхдийн эрх/. Энэ журамд хүүхдийн тухай асуудлыг илүү онцлон тусгасан байх ба бага насны хүүхэд нь өөрийн хувийн мэдээлэл ямар аюулд өртөж болох тухай мэдлэг хомс байдагаас тэдний хувийн мэдээлэлд тусгайлан анхаарал тавьж, хамгаалах шаардлагатай гэж үздэг байна.

НҮБ нь 16 нас хүрсэн хүүхэд өөрийн хувийн мэдээллийг нийгмийн сүлжээнд өгөх эсэх талаар шийдвэр гаргах чадамжтай гэж үздэг бол НҮБ-ын гишүүн улс орнууд энэхүү шийдвэр гаргах насны талаар өөр журам /буруулж/ тогтоож болдог. Швед Улсын хувьд 13 нас хүрсэн хүүхэд²⁵ өөрийн хувийн мэдээллийг нийгмийн сүлжээнд өгөх эсэх талаар шийдвэр гаргах чадамжтай гэж үздэг. Мөн тус журамд хүүхэдтэй холбогдолтой мэдээллийг авах, мөн ашиглахад хэрхэн хариуцлагатай байх талаар чухал зарчмуудыг тусгасан байдаг.

Хэвлэл мэдээллийн хорттой нөлөөллөөс хүүхдийг хэрхэн хамгаалдаг вэ?

²² 16 дугаар зүйлийн 1 <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32000L0031>

²³ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32010L0013>

²⁴ <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32011L0093>

²⁵ Шведэд зөвшөөрлийн нас нь Мэдээлэл хамгаалах тухай хуулийн § 4-ийн дагуу 13 нас байна.

Маркетингийн тухай хуульд²⁶ 16 нас хүрээгүй хүүхдэд зар сурталчилгаа шууд түгээх болон шууд худалдан авалт хийх сэдэл төрүүлэхийг хориглодог. Мөн Радио болон Телевизийн тухай²⁷ хуульд хүчирхийлэл, садар самууныг харуулсан зураглал бүхий контентыг хязгаарлах талаар заасан. Шведийн хэвлэл мэдээллийн зөвлөлөөс олон нийтэд хүргэх мэдээлэлд насны хязгаарыг зааж өгдөг нь хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллийн агуулгаас хамгаалдаг. Мөн телевизээр тодорхой төрлийн контентыг нэвтрүүлж болох өдрийн цагийг тухайн нэвтрүүлэгт тусгай зөвшөөрлөөр олгодог.

Энэ чиглэлээр ажилладаг төрийн байгууллагууд:

1. Шведийн хэвлэл мэдээллийн зөвлөл;
2. Шведийн хэрэглэгчийн агентлаг;
3. Шведийн хэвлэл, өргөн нэвтрүүлгийн байгууллага;
4. Хууль зүйн канцлерын алба;
5. Шведийн цагдаагийн байгууллага.

Хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээнд бэхжүүлэх зорилгоор Хүүхдийн Омбудсмен²⁸ болон Шведийн Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран олон нийтийн сүлжээ, тоглоом болон бусад цахим орчныг хариуцдаг хүмүүст зориулан гарын авлагыг гаргадаг²⁹ байна.

6.7 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Оросын Холбооны Улс (ОХУ) 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд сөргөөр нөлөөлөх мэдээллээс хүүхдийг хамгаалах тухай хуулийг³⁰ баталсан бөгөөд 2012 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байна. Тус хууль нь 7 бүлэг 23 зүйлтэй.

Тус хуулийн зорилго нь хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Хуулийн 2 дугаар зүйлд дараах нэр томъёог хууль тогтоогч тухайлан тайлбарлаж тодорхойлсон байна. Үүнд:

- “хүүхдийн мэдээлэл авах боломж” гэж хүүхдэд зориулсан нээлттэй мэдээллийг хүлээн авах, ашиглах боломж;
- “мэдээллийн бүтээгдэхүүний тэмдэг” гэж мэдээллийн бүтээгдэхүүний ангиллын дагуу мэдээллийн бүтээгдэхүүний график ба текстийн тэмдэглэгээ;

²⁶ <https://www.government.se/4abc0a/contentassets/747603b3d1a04351b1773524c7de3c84/2008486-marketing-act>

²⁷ <https://www.mpr.se/globalassets/dokument/lagar-och-regler/radioandtelevisionact2016.pdf>

²⁸ https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms_accessible.pdf

²⁹ https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms_accessible.pdf

³⁰ <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody&nd=102144583>

- “хүүхдийн мэдээллийн аюулгүй байдал” гэж мэдээллийн улмаас хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, оюун санаа, ёс суртахууны хөгжилд хохирол учруулахаас хүүхдийг хамгаалахыг;
- “мэдээллийн бүтээгдэхүүн” гэж ОХУ-ын нутаг дэвсгэрт эргэлтэд оруулах зориулалттай олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хэвлэмэл материал, аливаа төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээрх дуу дүрсний бүтээгдэхүүн, цахим төхөөрөмж (компьютерийн программ) болон мэдээллийн санд зориулсан программууд, түүнчлэн хөгжөөнт арга хэмжээ, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, интернэт болон хөдөлгөөнт радио телефоны сүлжээгээр дамжуулан түгээх мэдээлэл;
- “хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн” гэж хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл санааны болон ёс суртахууны хөгжилд сэдэв, агуулга, уран сайхны загвар нь тохирсон мэдээллийн бүтээгдэхүүн;
- “мэдээллийн бүтээгдэхүүний ангилал” гэж энэ хуульд заасны дагуу тогтоосон хүүхдийн насны ангиллаар мэдээллийн бүтээгдэхүүнийг түүний сэдэв, төрөл, агуулга, уран сайхны загвараас хамааран ангилсаныг хэлнэ хэмээн тусгажээ.

Түүнчлэн, тус хуулийн 4 дүгээр зүйлд хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах чиглэлээр ОХУ-ын төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг хуульчилсан байна. Үүнд:

- хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах чиглэлээр төрийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэдээллийн бүтээгдэхүүний эргэлтэд чиглэсэн холбооны арга хэмжээний жагсаалтыг боловсруулж хэрэгжүүлэх; (*Холбооны хуулийн 2021 оны 7-р сарын 1-ний өдрийн 264-фз-ийн нэмэлт, өөрчлөлт*)
- хуульд заасан мэдээллийн бүтээгдэхүүний шалгалт хийх журмыг тогтоох;
- хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд хортой мэдээллээс хамгаалах тухай ОХУ-ын хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд холбооны улсын хяналт хэрэгжүүлэх;
- хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах чиглэлээр ОХУ-ын зохих байгууллагуудын төрийн эрх баригчдын бүрэн эрхэд хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүс нутгийн арга хэмжээний жагсаалтыг боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэдээллийн бүтээгдэхүүний эргэлт, түүнчлэн энэхүү холбооны хуулиар тогтоосон бусад бүрэн эрх. (*Холбооны хуулийн 2019 оны 5-р сарын 1-ний өдрийн 93-фз, 2021 оны 7-р сарын 1-ний өдрийн 264-фз-р нэмэлт, өөрчлөлт оруулсан*).

Мөн хуулийн 6 дугаар зүйлд мэдээллийн бүтээгдэхүүнийг хуулийн шаардлагын дагуу дараах насны ангиллаар ангилдаг байна. Үүнд:

- зургаан нас хүрээгүй хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;
- зургаагаас дээш насны хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;
- арван хоёр наснаас дээш насны хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;
- арван зургаан нас хүрсэн хүүхдэд зориулсан мэдээллийн бүтээгдэхүүн;
- хүүхдэд хориглосон мэдээллийн бүтээгдэхүүн гэж тус тус ангиллалыг тогтоож өгсөн байна.

Ийнхүү ангилал тогтоосноороо хүүхэд өөрт нь тохироогүй мэдээ, мэдээллийг олж авахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Үүнээс гадна энэ хуулийн 14 дүгээр зүйлд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан мэдээлэл түгээх онцлогийг тусгасан байна:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр бүртгэгдээгүй "Интернэт" мэдээлэл, харилцаа холбооны сүлжээнд байгаа сайт нь мэдээллийн бүтээгдэхүүний тэмдэг (түүний дотор машинд уншигдах хэлбэрээр) ба хүүхдийн дунд тархалтыг хязгаарлах тухай анхааруулга бүхий бичвэрийг агуулж болно. Энэхүү Холбооны хуулийн шаардлагын дагуу сайтуудыг эзэмшигчид нь бие даан ангилна.
- Аудио-визуал үйлчилгээ нь энэ зүйлийн 3-р хэсэгт заасан мэдээллийн бүтээгдэхүүний ангиллын аль нэгэнд хамаарах мэдээллийн бүтээгдэхүүний тэмдэглэгээ (түүний дотор машинд уншигдахуйц хэлбэрээр) ба хүүхдийн дунд мэдээллийн бүтээгдэхүүний тархалтыг хязгаарлах тухай анхааруулга агуулсан байх ёстой гэж тусгасан байна.

Дээр дурдсанчлан мэдээллийн хязгаарлалт, хяналтыг тогтоосноор хүүхдийг нийгмийн сүлжээнд хамгаалах механизм бүрэлдэн бий болдог.

6.8 ИХ БРИТАНИ УЛСЫН Нийгмийн сүлжээнд ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Их Британи нь техник, технологийн дэвшилттэй холбоотой үүсч буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах арга замыг хэрэгжүүлж байна. Жишээ нь: Эрүүгийн болон олон нийтийн хэв журмыг сахиулах тухай хуульд садар самуун материал “хэвлэн нийтлэх” гэдэг ойлголт нь интернэт дэх агуулгыг адил хамрах болсон. Түүнчлэн технологи ашиглаж, компьютерийн тусламжтай эсхүл өөр ямар нэгэн техник ашиглан бий болгосон хүүхдийн дүрс зураг бүхий садар самуун хэв маягтай “дууриамал зураг” нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог. Цаашлаад, 1978 онд батлагдсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “зураг” гэх ойлголтыг цахим хэлбэрийг оруулан ойлгох тухай, мөн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. 2003 оны Садар самууны тухай хууль нь интернэтийг буруугаар ашиглан хүүхдүүдийг хохироох аюулаас хамгаалах үүднээс хүүхдийг садар самуун үйл хэрэгт ашиглах зорилгоор хүүхдийн итгэлийг олж аван, түүнтэй найз нөхдийн дотно харилцааг бий болгодог “садар самуун уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох” гэмт хэргийг хамааруулах болсон. Садар самуун уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох хэлбэрийг гэмт хэрэгт хамруулах болсоноор хүүхдийг өдөөн хатгах, хууран мэхлэх үйлдлийг таслан зогсоох хэм хэмжээг хуульчилсан.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэдэгт компьютерийн тусламжтай бий болгосон хүүхдийн дүрсийг харуулсан садар самуун зураг нь Садар самуун зүйл хэвлэн нийтлэх тухай хуулийн дагуу хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл хэмээн тооцогдох болсон. Мөн уг хууль нь Английн насанд хүрэгчдэд зориулсан контент түгээдэг цахим хуудасны операторууд насны хязгаар тогтоох тухай журамгүй байдгаас ийм төрлийн контент түгээхийг хууль бус үйлдэл болгон хуульчилсан.

Их Британи нь ЕХ-ны гишүүн орны хувьд Холбооны өмнө хүлээсэн хариуцлагын дагуу ЕХ-ны хөтөлбөр арга хэмжээг авахаас гадна өөрийн орны түүх, соёлын онцлогт тохирсон тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Их Британийн Дотоод хэргийн яам болон тус байгууллагын дэргэдэх Аюулгүй интернэт орчин бүрдүүлэх комисс (The Home Secretary's Internet Task Force) нь хүүхдэд зориулсан аюулгүй орчин бий болгох, хүүхдийг хамгаалах гэсэн хоёр үндсэн зорилго, чиг үүрэгтэй ажилладаг.

Үүний зэрэгцээ төрөөс санхүүждаг салбарын төлөөлөл болон цагдаа, шүүх байгууллагын төлөөлөл нь хамтарсан байдлаар цахим ертөнцөд хүүхдийг хамгаалах, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор бий болсон “Цахим ертөнц дэх хүүхдийн эсрэг хүчирхийллийн төв” /The Child Exploitation and Online Protection Centre/ гэсэн хамтын зохицуулалт хэрэгжүүлдэг байгууллага эрчимтэй үйл ажиллагаа явуулдаг. Уг байгууллага нь хууль сахиулах байгууллагын нэг хэсэг учраас хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

1996 онд Их Британийн засгийн газрын дэмжлэгтэйгээр бий болсон Интернэтийн хяналтын байгууллага нь /The Internet Watch Foundation/ байнгын утас, факс, и-мэйлээр хууль бус агуулга, хүүхдийн порнограф болон хүүхдийг харуулсан садар самуун материал түгээж байгаа талаарх мэдээллийг олон нийтийн зүгээс хүлээн авдаг. Уг байгууллага нь холбогдох төрийн байгууллагууд, салбар байгууллагууд, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажилладаг.

Уг байгууллага нь салбартаа өөрийн бие даасан зохицуулалт бүхий хууль сахиулах бүрэн эрхгүй байгууллага (self-regulatory) боловч хуулийн дагуу бүрэн эрхийн хүрээнд олгогдсон холбогдох хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажилладаг тул хуулийн хэрэгжилт нь өндөр үр дүнтэй хэрэгжих боломжийг нөхцөлдүүлдэг.

Хууль бус агуулгатай, хууль бус агуулга бүхий магадлалтай мэдээлэл нийтэлдэг цахим хуудасны жагсаалтыг гаргаж, цаашид хуулийн дагуу ажиллуулах арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлдэг байгууллага руу шилжүүлдэг. Энэ байгууллагын гол зорилго нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг ба “мэдэгдэх болон таслах” (notice and takedown) тактикийн дагуу эрчимтэй ажилладаг байна.

Өөрөөр хэлбэл, уг байгууллага нь тодорхой зөрчил гаргасан эсхүл гаргах өндөр магадлал бүхий сайт эрхлэгчдэд анхааруулах мэдэгдэл илгээдэг ба тус мэдэгдлийг хүлээн авсан тухайн байгууллага хэрэв үл тоомсорловол харьяалах хууль сахиулах байгууллагад мэдэгдэж, зохих арга хэмжээг авдаг. Энэхүү

“мэдэгдэх болон таслах” арга хэмжээ нь цахим ертөнц дэх оюуны өмчийн зөрчлийн асуудалд маш өргөн хэрэглэгддэг арга юм. Тус байгууллага нь мөн олон улсын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.

Их Британийн томоохон 4 интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь ЕХ болон Английн төрийн уриалга, санаачлагын дагуу хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээнд хамгаалах үйл хэрэгт өөрсдийн хувь нэмрийг оруулах үүднээс өөрсдийн ёс зүйн дүрэмтэй бөгөөд шүүлтийн болон контентыг хаах техникийн тусламжтайгаар амиа хорлолт, хүчирхийлэл, порнограф зэрэг зүй бус контент хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээнд хамгаалах болсон. Интернэт орчныг хянах байгууллагаас гаргасан хаах боломжтой цахим хуудасны жагсаалтын дагуу контентыг хаах, түүнчлэн тусгай техникийн тусламжтайгаар хүүхдийн порнограф, хүчирхийлэл болон терроризмыг агуулсан контентыг хаадаг байна.

Их Британийн Засгийн газар утасгүй интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагатай шүүлтийн программ байршуулах тухай гэрээ байгуулан ажилладаг. Энэхүү хүрээнд нэлээдгүй утасгүй интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд шүүлтийн техникийн тусламжтайгаар хор хөнөөлтэй контентыг хязгаарласан байна. Гэсэн хэдий ч маш чухал гэгдэх бэлгийн боловсролын талаарх цахим сайт гэх мэт хор хөнөөлгүй, харин ч үр ашигтай сайтуудыг хаасан хэмээн олон нийтийн зүгээс ихээхэн гомдол гаргах болсон. Иймд хаах/хязгаарлах үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийх шаардлага гарсан ба шүүлтийн программ болон хаах үйл ажиллагаа нь хэр зохистой хийгдэж байгаа талаар судалгаа хийгдэж байгаа аж.

Харилцаа холбооны тухай хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах газар нь олон нийтийн ашиг сонирхлыг харилцаа холбооны салбарт хамгаалахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ газар нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс интернэт дэх мэдээллийн агуулга ялангуяа садар самуун зүйлийг зохицуулах талаар холбогдох эрх бүхий байгууллагуудад зөвлөмж боловсруулж, тус хүрээнд маш идэвхтэй ажилладаг. Мөн Харилцаа холбооны зохицуулах газар нь интернэт дэх “телевизийн нэвтрүүлэг адил” (television-like content) агуулгыг зохицуулах болсон.

Их Британийн хүүхдэд зориулсан боловсролын, үйлчилгээний байгууллагуудын стандартад хяналт тавьдаг Офстед байгууллага (Office for Standards in Education, Children's Services and Skills /Ofsted/-ын гаргасан Нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах талаарх заавар (the Ofsted eSafety guidance)-ын дагуу цахим аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг гүйцэтгэсэн эсэхийг сургууль, дээд боловсролын байгууллагуудыг аттестатчилахдаа дүгнэдэг байна.

Боловсролын байгууллагууд шүүлтийн программтай байдаг ба сургуулийн хүүхдүүд болон оюутнуудын мэдээллийн технологийн хичээлд интернэтийн зохистой хэрэглээ, “садар самуун уруу татах зорилгоор интернэт ашиглан харилцаа тогтоох”, “цахим дарамт буюу дээрэлхэл, гадуурхал” зэрэг ойлголтын талаар заадаг. Үүний зэрэгцээ нийгмийн ухамсар хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүүхдүүд, эцэг эхчүүд, сурган хүмүүжүүлэгчид, харилцаа холбооны хувийн хэвшлийн байгууллагуудад зориулсан www.thinkuknow.co.uk гэх тусгай цахим сайтыг төрийн зүгээс ажиллуулдаг байна.

6.9 БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

2019 оны 8-р сарын 22-ны өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Кибер орон зайн удирдах газар Хүүхдийн хувийн мэдээллийг нийгмийн сүлжээнд хамгаалах тухай журмыг гаргасан байна. Мэдээллийн нууцлалын шинэ журамд БНХАУ-ын нутаг дэвсгэрт байгаа хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулахад тавигдах өндөр түвшний шаардлагуудыг тусгасан. Энэ нь интернэт дэх хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах тухай тусгайлан зохицуулсан Хятадын анхны эрх зүйн хэм хэмжээ болсон бөгөөд 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Тус журмын зорилго нь хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, хүүхдийн эрүүл хэвийн өсөлтийг дэмжих зорилгоор БНХАУ-ын Кибер аюулгүй байдлын тухай хууль, БНХАУ-ын Насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу боловсруулагдсан болно.

Хүүхдийн хувийн мэдээллийг цахимаар хамгаалах тухай журмын дагуу 14 нас хүрээгүй хүүхдийг насанд хүрээгүй гэж тодорхойлсон. БНХАУ-ын нутаг дэвсгэр дэх интернэт болон бусад холбогдох үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулахад энэхүү журам хамаарна. Ямар ч байгууллага, хувь хүн хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдалд халдсан мэдээллийг үйлдвэрлэх, гаргах эсхүл тарааж болохгүй. Хүүхдийн асран хамгаалагч нь асран хамгаалах чиг үүргээ зөв гүйцэтгэж, боловсрол, удирдамжаар дамжуулан хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах ухамсар, чадварыг дээшлүүлж, хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалж байх ёстой.

Журам нь сүлжээний операторуудаас³¹ хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулахдаа зөв шударга, зайлшгүй шаардлагатай, бүрэн мэдээлэл авсны үндсэн дээр зөвшөөрөх, тодорхой зорилготой, баталгаатай аюулгүй байдал болон хууль ёсны дагуу ашиглах зарчмуудыг баримтлахыг шаарддаг. Мөн энэхүү журмын дагуу сүлжээний операторууд хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах тусгай бодлого, хэрэглэгчийн гэрээ байгуулж, хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах үүрэг бүхий тусгай ажилтнуудыг томилсон байдаг.

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, шилжүүлэх, задруулахаас өмнө эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авах ёстой. Зөвшөөрөл авсан

³¹ Сүлжээний операторууд гэдэг нь БНХАУ-ын Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3-д заасны дагуу "Хятадын аливаа сүлжээ, сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн "эзэмшигч, менежер" гэсэн утгатай бөгөөд "сүлжээ" гэдэг нь компьютер болон холбогдох тоног төхөөрөмжийн систем, мэдээллийг цуглуулах, хадгалах, мэдээлэл дамжуулах, солилцох, боловсруулахыг хэлнэ" гэж томъёолсон байна. <https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/translation-cybersecurity-law-peoples-republic-china/>

сүлжээний операторууд зөвшөөрөл өгөхөөс татгалзаж, дараах мэдээллийг хүүхдийн асран хамгаалагчид өгөх ёстой. Үүнд:

1. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, шилжүүлэх, задруулах зорилго, арга, хамрах хүрээ;
2. Хадгалах байршил, хадгалах хугацаа, харилцан тохиролцсон хадгалах хугацаа дууссаны дараа мэдээллийг боловсруулах;
3. Хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээ;
4. Хүүхдийн хувийн мэдээллийг ашиглах, шилжүүлэх, задруулах, хадгалахыг зөвшөөрөхөөс татгалзсаны үр дагавар;
5. Зөрчлийн талаар мэдээлэх эсхүл сүлжээний операторт гомдол гаргах арга хэрэглүүр;
6. Хүүхдийн хувийн мэдээллийг засах, устгах арга хэрэглүүр;
7. Сүлжээний операторууд мэдээлэл өгөх ёстой бусад асуудал.

Энэхүү журам нь сүлжээний операторуудад хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах зорилгодоо хүрэхэд шаардагдах хугацаанаас хэтрүүлэн хадгалахыг хориглож, мэдээллийн аюулгүй байдлыг шифрлэх болон бусад аргыг хэрэглэхийг операторуудаас шаарддаг. Үүнээс гадна сүлжээний операторууд хүүхдийн хувийн мэдээллийг ашиглахдаа захиргааны хууль тогтоомж, эсхүл хоёр талын тохиролцсон ашиглалтын зорилго, хүрээг зөрчихгүй байх ёстой. Сүлжээний операторууд гуравдагч этгээдийн үйлдвэрлэгчдийг татах, хүүхдийн хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэхээс өмнө аюулгүй байдлын үнэлгээ хийсэн байх ёстой байдаг байна.

Аливаа байгууллага, хувь хүн энэхүү журмыг зөрчсөн үйлдлийг илрүүлсэн тохиолдолд интернэтийн мэдээллийн хэлтэс эсхүл бусад холбогдох хэлтэст мэдээлж болно. Сүлжээний операторууд хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг хангалтгүй хэрэгжүүлж, аюулгүй байдлын томоохон эрсдэлт оруулсан, аюулгүй байдлын зөрчил гарсан тохиолдолд интернэтийн мэдээллийн алба нь үүргийнхээ дагуу хариуцлага гаргасан ажилтантай ярилцах бөгөөд сүлжээний операторууд залруулга хийх, аюулыг арилгах арга хэмжээг шуурхай авч ажиллана³². Харин тухайн үүргээ биелүүлээгүй интернэтийн мэдээллийн алба болон бусад холбогдох хэлтэст Кибер аюулгүй байдлын тухай хууль, Интернэт мэдээллийн үйлчилгээний удирдлагын арга хэмжээ зэрэг холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг байна³³.

Хоёр. Хүүхдийн цахим орчин дахь хамгаалалтын зохицуулалтын олон улсын чиг хандлага

АНУ-ын Үндэсний сэтгэцийн эрүүл мэндийн хүрээлэн (National Institute of Mental Health)-ийн судалгаагаар 13 насанд хүрээгүй хүүхдийн тархины хөгжил, танин мэдэхүй, өөрийгөө хянах болон эрсдэлийг үнэлэх чадвар бүрэн төлөвшөөгүй байдал нь хүүхдийн шийдвэр гаргалт, импульс хянах, урт хугацааны үр дагаврыг

³² <https://www.chinalawtranslate.com/en/childrenspersonalinforonline/>

³³ <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2019-10-28/china-regulation-on-online-protection-of-childrens-personal-information-issued/>

тооцоолох үүрэгтэй тархины урд хэсэг (prefrontal cortex)-ийн хөгжил өсвөр насны сүүл үе хүртэл үргэлжилдэг бол шагнал, сэтгэл хөдлөлийн хариу урвалтай холбоотой лимбик систем илүү эрт идэвхждэг байна.³⁴ Үүний улмаас бага насны хүүхэд допамины өдөөлтөд суурилсан урамшууллын механизм (dopamine-based reward system)-аар ажилладаг лайк дарах (like), хуваалцах (share), хязгааргүй үзэх (endless scroll), алгоритмын санал болголтын арга (algorithmic recommendation) зэрэг донтуулах шинжтэй платформын нөлөөнд өртөмтгий, цахим дарамт, итгэл олж авах замаар бэлгийн хүчирхийлэлд татан оруулах үйлдэл(grooming), хортой агуулга, хувийн мэдээлэл алдах эрсдэлийг бодитоор үнэлэх чадвар сул байдаг³⁵. АНУ-ын COPPA зохицуулалт нь 13 наснаас доош хүүхдийн хувийн мэдээллийг эцэг эхийн зөвшөөрөлгүй цуглуулахад тусгай шаардлага тавьдаг бөгөөд өнөөдрийн олон платформын 13 насны босго үүнтэй холбоотойгоор тогтсон байдаг.³⁶

Харин 13–16 насны хүүхдийн хувьд нийгмийн сүлжээг бүрэн хориглох нь хүүхдийн мэдээлэл авах, боловсрол эзэмших, үзэл бодлоо илэрхийлэх, нийгмийн оролцоонд оролцох болон харилцах эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж олон улсын байгууллага, судлаачид үздэг.³⁷

Австрали улс 16-аас доош насны хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээг бүрэн хаах зохицуулалт хэрэгжүүлсэн боловч практик хэрэгжилтийн явцад хүүхдүүд VPN, эцэг эхийн бүртгэл, нас баталгаажуулалтыг тойрох бусад арга ашиглан хаалтыг төвөггүй давж байгаа талаар судалгаа, тайлан гарсаар байна. Тухайлбал 2026 онд хийгдсэн судалгаагаар 12–15 насны хүүхдийн 60 гаруй хувь нь хориг хэрэгжсэний дараа ч нийгмийн сүлжээг VPN болон бусад аргаар үргэлжлүүлэн ашиглаж, хязгаарлалтыг тойрон гарч байгааг тэмдэглэсэн байна.³⁸ Мөн Австралийн болон олон улсын судлаачид насны хатуу хориг нь дангаараа үр дүнтэй хамгаалалт болж чадахгүй, харин хүүхдүүдийг илүү зохицуулалтгүй, эрсдэлтэй орчин руу шилжүүлэх, эсхүл онлайн орчинд учирсан эрсдэлийн талаар мэдээлэхээс айх нөхцөл үүсгэж болзошгүйг анхааруулжээ.³⁹

Түүнчлэн хүүхэд, өсвөр насныхны хувьд нийгмийн сүлжээ нь зөвхөн эрсдэл бүхий орчин бус, харилцаа, дэмжлэг, сэтгэл зүйн тусламж авах хэрэгсэл болдог талаар судалгаанд дурдсан. Австралийн Хүүхдийн тусламжийн үйлчилгээний төв (Kids Helpline) болон сэтгэл зүйн байгууллагуудын мэдээлснээр зарим өсвөр насныхан нийгмийн сүлжээний хоригийн дараа дэмжлэг авдаг орчноосоо тусгаарлагдаж, сэтгэл гутрал, амиа хорлох бодолтой холбоотой хямралын шинжтэйгээр тусламж хүссэн тохиолдлууд бүртгэгдсэн байна.⁴⁰ Иймд олон улсын чиг хандлага нь нийгмийн сүлжээг бүрэн хориглох арга хэмжээнээс илүүтэйгээр платформын аюулгүй загварчлалын шаардлага, алгоритмын зохицуулалт, насанд тохирсон хамгаалалтын тохиргоо, эцэг эхийн оролцоо, сэтгэл зүйн дэмжлэг болон

³⁴ National Institute of Mental Health, *The Teen Brain: 7 Things to Know*, 2024.

³⁵ UNICEF, *Policy Brief on Online Platform Regulation and Child Safety*, 2025.

³⁶ Federal Trade Commission, *Children's Online Privacy Protection Rule (COPPA)*, 1998.

³⁷ UNICEF, *Policy Guidance on AI for Children and Child Rights in the Digital Environment*, 2021–2024., United Nations Committee on the Rights of the Child, *General Comment No.25 (2021) on children's rights in relation to the digital environment*, 2021.

³⁸ Molly Rose Foundation, *Survey on Australia's Under-16 Social Media Restrictions*, 2026; Fortune, *Australian teens say social media ban is futile and look to VPNs*, 2026.

³⁹ Scott J. Fatt & Jasmine Fardouly, *Debate: Social media in children and young people – time for a ban?*, Child and Adolescent Mental Health, 2025.

⁴⁰ Molly Rose Foundation, *Written Evidence Submitted to UK Parliament on Social Media Ban Risks*, 2026.

цахим боловсролыг хамтад нь хэрэгжүүлэх “эрсдэлд суурилсан, тэнцвэртэй зохицуулалт”-д чиглэж байна.⁴¹

Харвардын их сургуулийн Хүүхдийн хөгжлийн төв (Harvard Center on the Developing Child)-ийн судалгаагаар 13–16 насанд хүүхдийн нийгмийн оролцоо, харилцаа, мэдээлэл авах, суралцах, өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ эрчимтэй нэмэгддэг боловч тархины өөрийгөө хянах, сэтгэл хөдлөлөө зохицуулах, нийгмийн дарамтыг даван туулах чадвар бүрэн төлөвшөөгүй хэвээр байдаг байна.⁴² Судалгаагаар өсвөр насныхан “peer validation” буюу бусдын үнэлэмжид илүү мэдрэмтгий байдаг тул алгоритмаар эрчимтэй түгээх (algorithmic amplification), бусадтай өөрийгөө харьцуулах (social comparison), донтуулах шинжтэй хэрэглээний загварчлал (addictive engagement design)-ын нөлөөнд илүү өртөмтгий байдаг гэж үздэг.⁴³ Иймээс Европын холбооны Цахим үйлчилгээний тухай хууль (Digital Services Act, 2022) нь насанд хүрээгүй хэрэглэгчид ашиглах боломжтой платформд “өндөр түвшний нууцлал, аюулгүй байдал, хамгаалалт” хангах үүргийг хуульчилж, хүүхдэд чиглэсэн хэрэглэгчийн зан төлөвт суурилсан сурталчилгаа, алгоритмыг хориглосон байна.

Иймд 13–16 насанд нийгмийн сүлжээг ашиглуулах, аюулгүй байдлын анхны тохиргоо, танихгүй хүнтэй холбогдох боломжийг хязгаарлах болон байршил хуваалцах тохиргоог идэвхгүй болгох, хортой агуулгыг харуулахгүй байх, эцэг эхийн хяналт, алгоритмын эрсдэлийг бууруулах гэх зэрэг хамгаалалтын арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээрх технологийн хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийг хангахын тулд нас баталгаажуулалтын системийг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Их Британи, Европын Холбоо, АНУ, Сингапур зэрэг улс орнуудын цахим орчин дахь хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад платформын үйл ажиллагааны хүрээ, үйлчилгээний төрөл, хүүхдэд учруулж болзошгүй эрсдэлийн түвшинд үндэслэн ялгамжтай зохицуулалт хийх хандлага түгээмэл байна. Тухайлбал, Их Британийн Цахим аюулгүй байдлын хууль (Online Safety Act, 2023), Европын холбооны Цахим үйлчилгээний тухай хууль (Digital Services Act, 2022) болон Австралийн Цахим аюулгүй байдлын хууль (Online Safety Act, 2021)-д платформд эрсдэлийн үнэлгээ хийх, насны баталгаажуулалт хэрэглэх, хортой агуулга болон алгоритмын нөлөөллийг бууруулах, хүүхдэд ээлтэй аюулгүй тохиргоог анхнаас нь бий болгох үүрэг хүлээлгэж байна. Иймд хуулийн төсөлд нийгмийн сүлжээний платформыг эрсдэлийн түвшнээр ангилах, эрсдэлийн үнэлгээнд суурилсан зохицуулалт хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Харин Сингапур улсын хувьд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (Broadcasting Act, 1994)-иар олгогдсон эрхийн дагуу Мэдээлэл, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн хөгжлийн газар (IMDA)-аас Цахим аюулгүй байдлын үйл ажиллагааны журам (Code of Practice for Online Safety, 2023) баталж, тус журмаар технологийн урьдчилсан сэргийлэх хамгаалалтыг нарийвчлан зохицуулсан нь нийгмийн сүлжээг

⁴¹ UNICEF, *Child Rights in the Digital Environment*; United Nations Committee on the Rights of the Child, General Comment No.25, 2021.

⁴² Harvard Center on the Developing Child, *Brain Development During Adolescence*, 2024.

⁴³ National Library of Medicine, *Social Media and Adolescent Mental Health*, 2025.

бүрэн хориглох бус, платформын хариуцлага, эрсдэлд суурилсан зохицуулалт, хэрэглэгчийн хамгаалалтын хэрэгсэл болон цахим боловсролыг хослуулсан практик хэрэгжилтэд чиглэж байна.

Энэ мэтчилэн АНУ, Австрали, Япон, Итали, БНСУ, ОХУ, ИБУИНВУ, БНХАУ, Сингапур, Казакстан, Малайз, Норвеги, Испани, Герман, Эстони зэрэг улс орнууд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх бодлого тодорхойлж, нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудыг баталжээ.

Эдгээрээс үзвэл улс орнуудын цахим хамгааллын зохицуулалт нь бүрэн хориглох арга хэмжээнд бус, хүүхдийн насны онцлогт тохирсон, зохистой хэрэглээний орчин бүрдүүлэх, хувийн мэдээлэл хамгаалах, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны ил тод байдал, эцэг эхийн оролцоо болон платформын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Европын Холбоо, НҮБ-ын Хүүхдийн сангийн баримт бичгүүдэд, хүүхэд хамгаалал, мэдээлэл авах эрх, хувийн нууц болон цахим оролцооны эрхийн тэнцвэрийг хадгалах зарчмыг чухалчилж байгаа нь насны баталгаажуулалтыг дангаараа хангалтгүй гэж үзэж байна. Иймд хуулийн үзэл баримтлалд хүүхдийн эрхийг хангасан, эрсдэлд суурилсан, технологийн хөгжлийг дэмжсэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангах тэнцвэртэй зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Судлаачдын баг нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу **Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах** тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү тандан судалгааны хүрээнд хүүхэд, эцэг эх, багш, нийгмийн ажилтан болон хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдээс нийт 11,234 оролцогчийг хамруулсан судалгааны үр дүн, Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, олон улсын эрх зүйн баримт бичиг, гадаад улсын туршлагад үндэслэн хүүхдийн цахим орчин дахь эрх, хамгаалалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын асуудал нэн чухалд тооцогдож, дэлхийн улс орнууд анхаарлаа хандуулж хууль тогтоомжоо шинэтгэх болсон. Улс орнууд эл шинэтгэлийг хийхдээ *нэгдүгээрт*, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах; *хоёрдугаарт*, нарийвчилсан зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулж батлах гэсэн хоёр чиглэлийг баримталж байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээ, цахим платформын хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, хүүхдийн өдөр тутмын амьдрал, боловсрол, мэдээлэл авах, харилцаа холбоо тогтоох, чөлөөт цагаа өнгөрүүлэх үндсэн орчны нэг болж байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхдүүд YouTube, Facebook, TikTok, Instagram зэрэг алгоритмд суурилсан платформыг өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд интернэт, нийгмийн сүлжээний хэрэглээ хүүхдийн амьдралын салшгүй хэсэг болсон байна.

Гэвч үүний зэрэгцээ хүүхдүүд цахим дээрэлхэлт, цахим дарамт, танихгүй хүнээс ирсэн чат, цахим залилан, бэлгийн шинжтэй дарамт, хортой болон насанд

тохироогүй контент, донтуулах богино видео, алгоритмын сөрөг нөлөөлөл зэрэг олон төрлийн эрсдэлд өртөж байгаа нь тогтоогдлоо. Эдгээр эрсдэл нь хүүхдийн зан төлөвийн өөрчлөлт, сэтгэл зүйн тогтворгүй байдал, цахим хэрэглээний хамаарал, сурлага, нийгмийн харилцаанд үзүүлэх сөрөг нөлөөллөөр илэрч байгаа бөгөөд хүүхдийн эрүүл хөгжил, төлөвшил, аюулгүй байдалд бодит эрсдэл учруулж байна.

Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд хүүхдүүд интернэтийг өдөрт дунджаар 2–5 цаг ашиглаж, ихэвчлэн нийгмийн сүлжээнд холбогдох, найз нөхөдтэйгөө харилцах, видео контент үзэх зорилгоор хэрэглэж байна. Харин хүүхдийн цахим хэрэглээний хугацаа, агуулгад тавих эцэг эхийн хяналт хангалтгүй, хүүхдүүд цахим орчинд тулгарсан асуудлаа гэр бүлдээ тэр бүр мэдээлдэггүй, эцэг эх, багш, асран хамгаалагчдын цахим орчны аюулгүй байдлын талаарх мэдлэг, хамгаалалтын арга хэрэгслийн хэрэглээ хангалтгүй байгаа нь тогтоогдов.

Олон улсын хэмжээнд хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарч, хууль тогтоомжоо шинэчлэх хандлага эрчимтэй хөгжиж байна. Улс орнууд уг асуудлыг шийдвэрлэхдээ нэг талаас холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, нөгөө талаас хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг тусгайлан зохицуулсан бие даасан хууль батлах гэсэн үндсэн хоёр чиглэлийг баримталж байна. Тухайлбал, Европын Холбооны Digital Services Act, Их Британийн Online Safety Act, Австралийн Online Safety Act зэрэг хууль тогтоомжид платформын үүрэг, хариуцлага, хүүхдийн default хамгаалалт, нас баталгаажуулалт, хортой контентын хязгаарлалт, алгоритмын эрсдэлийн зохицуулалтыг тусгайлан тусгасан байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооны 2021 оны “Цахим орчин дахь хүүхдийн эрхийн талаарх Ерөнхий тайлбар №25”-д хүүхдийн эрх цахим орчинд бүрэн хэрэгжих ёстой бөгөөд улс орнууд хүүхдийн эрхэд суурилсан, эрсдэлд суурилсан, нас, хөгжлийн онцлогт нийцсэн эрх зүйн зохицуулалт бий болгох үүрэгтэйг тодорхойлсон байдаг.

Монгол Улсын хувьд хүүхдийн эрх, хамгаалал, хувийн мэдээлэл, цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой асуудлыг Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг хууль тогтоомжоор тодорхой хэмжээнд зохицуулж байна. Гэвч эдгээр зохицуулалт нь хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээ, цахим орчин дахь оролцоо, аюулгүй байдал, технологийн хамгаалалтын арга хэмжээ, платформын үүрэг, хариуцлагыг цогцоор нь зохицуулахад хангалтгүй байна.

Тухайлбал, одоогийн эрх зүйн зохицуулалтад дараах асуудлууд тодорхой, нарийвчилсан байдлаар тусгагдаагүй байна. Үүнд:

1. нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлага;
2. нас баталгаажуулалтын тогтолцоо;
3. хүүхдийн хувийн мэдээлэл, байршил, бүртгэлийн нууцлалыг хамгаалах анхдагч тохиргоо;
4. эцэг эх, асран хамгаалагчийн хяналтын механизм;
5. хортой болон хориотой агуулгын харагдац, түгээлт, санал болгох алгоритмыг хязгаарлах зохицуулалт;
6. танихгүй хэрэглэгчээс ирэх шууд зурвас, харилцааг хязгаарлах хамгаалалт;
7. цахим дарамт, заналхийлэл, дээрэлхэлт, бэлгийн шинжтэй дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдээлэх, хамгаалах тогтолцоо;

8. хүүхдийн гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авах, шийдвэрлэх механизм;
9. нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээ, зохицуулалттай нийгмийн сүлжээний шалгуур, хяналтын тогтолцоо.

Иймд хүүхдийн цахим орчин дахь эрх, оролцоо, аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн соён гэгээрүүлэх арга хэмжээ, зөвлөмж, байгууллага хоорондын салангид зохицуулалтаар шийдвэрлэх боломжгүй байна. Харин хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд суурилсан, олон улсын чиг хандлагад нийцсэн, эрсдэлээс урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг тусгасан, нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч, төрийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч болон бусад оролцогч талын эрх, үүргийг тодорхойлсон тусгайлсан хуулийн зохицуулалт шаардлагатай гэж дүгнэв.

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг нэгэн голомтод төвлөрүүлж бие даасан хууль батлан гаргах хэрэгцээ шаардлага нэгэнт үүссэн байна.

Нийгмийн сүлжээнд үүсэх харилцаа нь шинжлэх ухаан, техник, технологийн ололтоос шууд хамааралтай байдаг онцлогийг харгалзахын зэрэгцээ хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаа нь гэр бүл, төрийн бодлогын төвд байх онцлогийг мөн харгалзаж зохистой тусгасан бие даасан хууль гаргах нь цахим орчны зүй бус, хор хөнөөлтэй нөлөөлөл болох цахим дарамт, заналхийлэл, цахим сүлжээ ашиглан хүүхдийг садар самуунд уруу татах, гэмт хэрэг, зөрчилд уруу татах, улмаар амиа хорлохоос ирээдүй хойч үеэ хамгаалах, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах гол арга зам хэмээн үзэж байна.

Иймд дараах бодлогын болон эрх зүйн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. “Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай” бие даасан хуулийн төслийг боловсруулж, хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангаж, хүүхдийн эрх, хамгаалалтыг цогцоор нь зохицуулах;
2. Нийгмийн сүлжээний платформуудад хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүрэг, хариуцлага, тайлагналын тогтолцоог хуульчлах;
3. Нас баталгаажуулалтын хүний эрхэд суурилсан, хувийн мэдээлэл хамгаалсан техникийн тогтолцоог үе шаттай нэвтрүүлэх;
4. “Safety by default”, “Privacy by default” зарчмыг хуульд тусгаж, хүүхдийн аккаунтыг анхдагчаар хамгаалалттай тохиргоотой үүсгэх зохицуулалт бий болгох;
5. Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохироогүй хүчирхийлэл, бэлгийн агуулга, өөртөө гэмтэл учруулах, амиа хорлолтыг өдөөх, донтуулах контентод хязгаарлалт тогтоох;

6. Хортой контентыг мэдээлснээс хойш тодорхой хугацаанд устгах платформын үүрэг, хариуцлагын зохицуулалтыг хуульчлах;
7. Хүүхдэд чиглэсэн донтуулах алгоритм, autoplay, endless scroll зэрэг механизмд эрсдэлийн үнэлгээ хийх, хязгаарлах зохицуулалт бий болгох;
8. Эцэг эх, асран хамгаалагчид зориулсан дижитал боловсрол, цахим аюулгүй байдлын сургалт, зөвлөмжийг тогтмол хэрэгжүүлэх;
9. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт цахим боловсрол, мэдээллийн аюулгүй байдал, цахим орчны эрсдэлийн талаарх агуулгыг үе шаттай тусгах;
10. Хүүхдийн цахим орчин дахь эрхийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг шуурхай шийдвэрлэх нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх;
11. Төрийн байгууллага, боловсролын байгууллага, платформ, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох;
12. Хүүхдийн цахим орчны асуудлаар тогтмол үндэсний хэмжээний судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийж, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах;
13. Хүүхдийн цахим орчны асуудлыг шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн онцлогтой уялдуулан тогтмол шинэчилж байх эрх зүйн уян хатан тогтолцоо бүрдүүлэх;
14. Хүүхдийг цахим дарамт, заналхийлэл, цахим мөлжлөг, гэмт хэрэг, зөрчил, амиа хорлолтыг өдөөсөн контентын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах нэгдсэн тогтолцоог төрийн бодлогын түвшинд хэрэгжүүлэх.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр хүүхдийн цахим орчин дахь эрх, оролцоо, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагчийн хяналтыг сайжруулах, нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдал болон хүүхдийн эрхийг хамгаалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.

....oOo....

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.
3. Иргэний хууль, 2002.
4. Эрүүгийн хууль, 2015
5. Зөрчлийн тухай хууль, 2017
6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019
7. Зар сурталчилгааны тухай хууль, 2002.
8. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998.
9. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016.
10. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016.
11. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012
12. Оюуны өмчийн тухай хууль, 2020
13. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021
14. Кибер аюулгүй байдлын тухай хууль, 2021
15. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998
16. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2002
17. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019.
18. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”. Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоол, 2021.
19. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал, Засгийн газрын 59 дүгээр тогтоол. 2016.
20. Хүүхдийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, 1989

Хоёр. Монгол болон гадаад улсын эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаа

1. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 2021 оны 5 дугаар 31-ний өдөр гаргасан “Цахим орчин дахь хүүхэд” шинэчлэн найруулсан зөвлөмж.
2. Европын зөвлөлөөс 2018 оны 9 дүгээр сард “Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах болон хэрэгжүүлэх талаархи удирдамж”.
3. Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан /албан хэрэгцээнд/, 2018 он.
4. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цахим орчин дахь хүүхдийн эрхийн хамгаалалт, 2017 он.
5. Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар судалгааны тайлан, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, 2021 он.
6. Нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах талаарх заавар (the Ofsted eSafety guidance-UK), 2019

7. Хүүхдийн Омбудсмен болон Шведийн Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран олон нийтийн сүлжээ, тоглоом болон бусад цахим орчныг хариуцдаг хүмүүст зориулсан гарын авлага
8. Европын Холбооны хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүүхдийн порнографтай тэмцэх тухай заавар, 2011
9. Европын Холбооны Дуу дүрс бичлэгийн хэвлэл мэдээллийн үйлчилгээний тухай заавар, 2010
10. Бага насны хүүхдүүдэд зориулсан зөвлөмж (crc.gov.mn)

Гурав. Гадаад эх сурвалж

1. www.saferinternetday.org
2. <https://www.unicef.org/mongolia/mn>
3. http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/67127/98324/F2042155478/KO_R67127%20English.pdf
4. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38422&lang=ENG
5. <http://opennetkorea.org/en/wp/wp-content/uploads/2014/03/Korean-real-name-law-decision-english.pdf>
6. <https://www.chinalawtranslate.com/en/childrenspersonalinfoonline/>
7. <http://duma.gov.ru/news/50878/>
8. <https://rkn.gov.ru/>
9. <https://datareportal.com/reports/digital-2021-global-overview-report>
10. <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2019-10-28/china-regulation-on-online-protection-of-childrens-personal-information-issued/>
11. <https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/translation-cybersecurity-law-peoples-republic-china/>
12. <https://www.government.se/4abc0a/contentassets/747603b3d1a04351b1773524c7de3c84/2008486-marketing-act>
13. <https://www.mprt.se/globalassets/dokument/lagar-och-regler/radioandtelevisionact2016.pdf>
14. https://www.imy.se/globalassets/dokument/rapporter/the-rights-of-children-and-young-people-on-digital-platforms_accessible.pdf
15. <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody&nd=102144583>
16. www.thinkuknow.co.uk
17. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=celex%3A32010L0013>
18. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A32011L0093>
19. <https://www.togetherscotland.org.uk/news-and-events/news/2018/06/sweden-to-incorporate-the-uncrc-into-law/>
20. [https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC_united_nations_convention_on_the_rights_of_the_child.pdf?_adal_sd=www.unicef.org.uk.1644975131543&_adal_ca=so%3DGoogle%26me%3Dorganic%26ca%3D\(not%2520set\)%26co%3D\(not%2520set\)%26ke%3D\(not%2520set\).1644975131543&_adal_cw=1644975110033.1644975131543&_adal_id=3f637e28-b702-4661-be5e-](https://downloads.unicef.org.uk/wp-content/uploads/2010/05/UNCRC_united_nations_convention_on_the_rights_of_the_child.pdf?_adal_sd=www.unicef.org.uk.1644975131543&_adal_ca=so%3DGoogle%26me%3Dorganic%26ca%3D(not%2520set)%26co%3D(not%2520set)%26ke%3D(not%2520set).1644975131543&_adal_cw=1644975110033.1644975131543&_adal_id=3f637e28-b702-4661-be5e-)

dba9ea34294b.1644975110.2.1644975110.1644975110.b9ec6fed-1206-411e-a88c-

0c3be100d0de.1644975131543&_ga=2.159751674.65386346.1644975109-551663205.1644975109

<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32000L0031>

<https://law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=199081&viewCls=engLsInfoR&urlMode=engLsInfoR#0000>

21. [https://gdprhub.eu/Data Protection in Sweden](https://gdprhub.eu/Data%20Protection%20in%20Sweden)

Дөрөв. Цахим эх сурвалж

1. www.legalinfo.mn
2. www.ekids.mn
3. www.crc.gov.mn
4. www.fcy.gov.mn
5. www.mddc.gov.mn
6. www.gia.gov.mn

Хавсралт 1: Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн түүвэр

№	Хуулийн нэр	Зүйл, заалт
1.	Хүүхэд хамгааллын тухай хууль	8 дугаар зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал 8.1.Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална. 8.2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана. 8.3.Хүүхдэд зориулсан мэдээ, мэдээлэл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн ажилтан энэ тухай гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ. 8.4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

		8.5.Арван зургаан насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 8.4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна. 8.6.Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.
2.	Хүний мэдээллийг тухай хууль хувийн хамгаалах	29 дүгээр зүйл.Хориглох зүйл 29.1.Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно. 29.2.Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно. 29.3.Мэдээллийг энэ хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.
3.	Кибер аюулгүй байдлын тухай хууль	15 дугаар зүйл.Цагдаагийн байгууллага 15.1.Цагдаагийн байгууллага кибер аюулгүй байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.1.1.кибер халдлага, зөрчилтэй холбоотой гэмт хэргийн мэдээллийг хүлээн авч, хуульд заасан ажиллагааг явуулах; 15.1.2.энэ хуулийн 15.1.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс гаргуулан авах;

		15.1.3.кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөмж, шаардлага, сэрэмжлүүлэг хүргүүлэх; 15.1.4.кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, тоног төхөөрөмж, программ хангамжийг шалгах, судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах зорилгоор тоон шинжилгээний лаборатори ажиллуулах.
4.	Хэвлэл мэдээний эрх чөлөөний тухай хууль	3 дугаар зүйл.Мэдээлэлд хяналт тавихыг хориглох 3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй. 3.2.Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.
5.	Зар сурталчилгааны тухай хууль	6 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд тавих ерөнхий шаардлага 6.5.Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд дараах зүйлийг хориглоно: 6.5.5.Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.8.хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчилах. 7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа 7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.

	7.2.Дараахь зар сурталчилгааг зүй бус зар сурталчилгаанд тооцно: 7.2.2.бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа; 7.3.Дараахь зүйлийн талаар хэрэглэгчийг төөрөгдүүлсэн зар сурталчилгааг бодит байдалд үл нийцсэнд тооцно: 7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно: 7.4.1.бусдын бүтээгдэхүүнийг гутаан доромжилсон; 7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан; 7.4.6.хүнлэг ёс, ёс суртахуун, Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг зан заншлын ёс горимыг зөрчсөн. 7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно. 7.6.Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно. 7.7.Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно. 12 дугаар зүйл.Интернэтээр түгээх зар сурталчилгаа 12.1.Зар сурталчилгаа түгээгч нь бусдын эзэмшилд байгаа интернэтийн хуудсанд өөрийн зар сурталчилгаагаа зөвшөөрөлгүй байрлуулахыг хориглоно.
--	--

	16 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд хүүхдийн эрхийг хамгаалах 16.1.Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд дараахь зүйлийг хориглоно: 16.1.1.эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн нэр хүндийг бууруулах; 16.1.2.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахыг эцэг, эх болон бусад этгээдээс шаардахыг хүүхдэд шууд зөвлөх, ухуулах, бусад хэлбэрээр нөлөөлөх; 16.1.3.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авсан, эсхүл аваагүйгээс бусад хүүхдээс давуутай буюу дор байдалд орно гэсэн ойлголтыг хүүхдэд бий болгох; 16.1.4.хүүхдийг аюултай орон зай, нөхцөл байдалд дүрсэлсэн дүрс, дуу авиа, эсхүл үг хэллэгийг зар сурталчилгаанд ашиглах; 16.1.5.тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэхэд шаардагдах мэдлэг, дадлага, туршлагын төвшинг бууруулж буюу өсгөж сурталчлах; 16.1.6 бүтээгдэхүүний үнийн талаар буруу ойлголт хүүхдэд бий болгох. 16.1.7.Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 3.1.8-д зааснаас бусад нялх, балчир хүүхдэд зориулж үйлдвэрлэсэн хүнс болон хооллох хэрэгслийг сурталчлах; 16.1.8.чихэр, давс, транс болон ханасан тос ихээр агуулсан хоол, хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаанд хүүхэд оролцуулах.
6.	5 дугаар зүйл.Садар самууныг сурталчлахыг хориглох 5.1.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно. 5.2.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.

	7 дугаар зүйл.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам 7.2.3. 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдах. 8 дугаар зүйл.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйл 8.1.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих урлаг, үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн, бусад үзвэрийг үзүүлэхэд дараахь зүйлийг хориглоно: 8.1.3. 18 насанд хүрээгүй хүнд үзүүлэх.
7.	Эрүүгийн хууль 16.8 дугаар зүйл.Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 1.Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 16.9 дүгээр зүйл.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах 1.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.кибер орчныг ашиглаж;

	2.2.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 26.1 дүгээр зүйл.Цахим мэдээлэлд хууль бусаар халдах 1.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж компьютерийн өгөгдөл, системд нэвтэрсэн, танилцсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж, сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан; компьютерийн өгөгдлийг нуусан, хандалтад хязгаарлалт тогтоосон, компьютерийн системд санаатайгаар хууль бусаар мэдээлэл дамжуулсан, үйл ажиллагааг хязгаарласан; мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсний улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
8.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 32 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг 32.4.Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ.

9.	Мансууруулах эм, сэтгэцэд бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль	13 дугаар зүйл. Хориглох зүйл 13.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь үйл ажиллагааг хориглоно: 13.1.2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дуу, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерийн сүлжээг ашиглан сурталчлах;
10.	Хүүхдийн эрхийн тухай хууль	6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх 6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ: 6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах; 10 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг 10.1.Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ: 10.1.1.хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх; 10.1.2.хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх; 10.1.3.хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

		10.1.4.хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах; 10.1.5.хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах; 10.1.6.хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах; 10.1.7.хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах; 10.1.8.хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах; 10.1.9.хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх; 10.1.10.хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах; 10.1.11.хууль тогтоомжид заасан бусад.
Бусад		
16.	Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	https://legalinfo.mn/mn/detail/7045
17.	“Цахим монгол” үндэсний хөтөлбөр	https://legalinfo.mn/mn/detail/9465
18.	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	https://legalinfo.mn/mn/detail/4698

19.	Үндэсний хөтөлбөр батлах тухай /Мэдээллийн аюулгүй байдал/	https://legalinfo.mn/mn/detail/4716
20.	Гэмт хэргийн тухай хуулийн төсөл	https://mojha.gov.mn/newmojha/?p=557
21.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	https://legalinfo.mn/mn/detail/6163


Хавсралт 2: Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулахсанал асуулгын дүн

Судалгааны талаарх тойм танилцуулга:


Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон асуудлаар өсвөр насны хүүхдүүдээс болон эцэг, эх, асран хамгаалагч нараас дараах судалгааны анкетаар судалгаа авсан болно. Судалгааг өсвөр насны хүүхдүүдээс онлайн болон цаасан хэлбэрээр цуглуулсан бөгөөд нийт 1129 хүүхэд хамрагдсан байна. Эцэг, эх, асран хамгаалагч нараас онлайн хэлбэрээр судалгааг авсан бөгөөд нийт 253 иргэд хамрагдсан.

НЭГ. Хүүхдээс авсан судалгааны үр дүн:


1.Хэдэн настай вэ?




2. Өдөрт дунджаар хэдэн цагийг нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг вэ?




3. Интернетийг ихэнх тохиолдолд ямар зорилгоор хэрэглэдэг вэ?




4. Нийгмийн сүлжээнд танихгүй хүнээс ирсэн хүсэлт, мессежинд хариу өгдөг үү?




5. Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, и-мэйл авч байсан уу?




6. Хэрэв тийм бол дараах сонголтуудаас алийг нь сонгох вэ?




7.Интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу?




8. Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү?



9. Эцэг, эхийн зүгээс интернет хэрэглээний цагт ямар нэгэн хяналт тавьдаг уу?



10. Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний агуулгад ямар нэгэн хяналт тавьдаг уу?



11. Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ?



Хүүхдээс авсан судалгааны үр дүн:

Нийт 1129 хүүхдээс авсан судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

-Тус судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн насаар ангилан үзвэл нийт судалгаанд оролцогчдын 40 хувь нь 12-14 насны хүүхдүүд хамрагдсан байна;

- 46 хувь нь 2-4 хүртэлх цагийг нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг байна;

-Давхардсан тоогоор нийт 79 хувь нь нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдохоор, 65 хувь нь найз нөхдийн харилцаа холбоо тогтоохоор цахим орчныг хэрэглэдэг байна;

-Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, и-мэйл авч байсан уу гэсэн асуулгад 78 хувь нь авч байгаагүй гэсэн хариулт өгсөн нь сайшаалтай байна;

-Харин авч байсан гэж хариулсан 22 хувийн оролцогчдоос 50 хувь нь хувийн мэдээллийг нь нийтэд тараасан гэсэн хариултыг сонгосон байна;

-Интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу гэдэгт 56 хувь нь тийм гэж хариулснаас үзвэл цахим сүлжээнд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэл нь ямар нэгэн шүүлтүүргүйгээр байршиж байдаг гэсэн дүгнэлтэд хүрэхээр байна;

-Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү гэсэн асуулгад 60 хувь нь хэрэглэдэг гэж хариулсан байна;


-Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний цаг болон агуулгад хяналт тавьдаг уу гэж асуухад заримдаа гэдгийг 55 хувь нь сонгосноос үзвэл цахим сүлжээн дэх эцэг эхийн хяналт сул байна;

-Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ гэдэгт судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана, 41 хувь нь найз нөхдөөсөө зөвлөгөө авна гэсэн хариултыг сонгосон байна.


Үүнээс нэгтгэн дүгнэвэл 10-18 насны нийт 1129 хүүхдээс судалгаа авахад интернэтийг 2-4 цаг хүртэлх хугацаанд хэрэглэдэг, интернэтийг ихэвчлэн нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдох, найз нөхөдийн харилцаа холбоо тогтооход хэрэглэдэг, интернэт хэрэглээний цаг болон агуулгад эцэг, эхийн хяналт сул байдаг, интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралддаг, нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандахаар байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

ХОЁР. Эцэг, эх, асран хамгаалагчаас авсан судалгааны үр дүн:


1.Та хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хяналт тавьдаг уу?




2. Та цахим орчин дахь мэдээллийн шүүлт хийх тохиргооны талаар хэр мэдээлэлтэй вэ?




3. Таны хүүхэд нийгмийн сүлжээнд үе тэнгийнхний дарамт, шахалтанд өртөж байсан уу?



4. Таны хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэг үү?



5. Та нийгмийн сүлжээнд хүүхдийн хамгаалалын талаар хэр мэдээлэлтэй вэ?



6. Таньд нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн зохицуулалттай холбоотой санал байвал дор бичнэ үү. Гэсэн асуултанд судалгаанд оролцогчид бичгээр санал гаргасан байна. Үүнийг ямарваа засваргүйгээр, эрэмбэлэхгүйгээр дор дурдвал:

- хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай гэж боддог;
- эцэг эхчүүдийг цахим орчны мэдлэгийг нэмэгдүүлэх;
- тусгайлан хууль гаргаж сайтар хамгаалах нь зүйтэй байна;
- цахим орчны хэрэглээг хянах, аль болох утасны хэрэглээг багасгаж өөр зүйлд анхаарлыг хандуулах спортын ямар нэг төрлөөр хичээллүүлэх;
- Нийгмийн сүлжээнд зарим мэдээллийг хаалттай болгох, хүүхэд нэвтэрдэг учраас хориотой үг хэл ашиглахыг таслан зогсоох болон хүчирхийлэлтэй мэдээлэл түгээхгүй байх;
- Эрхзүйн зохицуулалт байх хэрэгтэй гэж боддог. Ганц хүүхэд ч биш шүү дээ. Хүүхдүүдээ цаг үргэлж хянаж чадахгүй, цаг үргэлж цахим хэрэглээг нь хязгаарлаад байж болохгүй асуудал эцэг эх бүрт бий байх. Эрхзүйн зохицуулалттай болж ухуулга хийж байж хүүхэд ч, томчууд ч өөрийгөө ч өрөөл бусдыг ч хамгаалах сэтгэл зүйтэй болох байх гэж боддог;
- Тодорхой сайт вэбүүдэд нэвтрэх боломжгүй нас заах;
- Насанд хүрээгүй хүүхдүүдийг заавал нийгмийн сүлжээнд холбож байгаа нь таалагддаггүй. Ангийн групп нээчихээд тэндээ энэ тэр зар оруулна. Багш нар бүүр шөнийн 23 24цагт ангийнхаа хүүхдүүдэд зарын чанартай мэдээлэл оруулдаг. Одоо шалгалт энэ тэр мэдээллээ цахим групптэй оруулдаг энэ мэтээр хүүхдийг цахим орчноос хол байлгах нөхцөл бүрдэхгүй байна. Зарим нь бүр цахимаар гэрийн даалгавар өгнө гээд тараадаг;

- Энэ төрлийн зохицуулалт байх нь зөв. Гол нь эрх зүйн орчин болоод технологийн шийдэл нь сайн байх хэрэгтэй;
- FB -г тодорхой насанд хүрсэн хүн хэрэглэгч болдог. Гэтэл хичээл мэдээлэл нь бүгд FB-ээр дамжиж хүрч байна. Тиймээс ямар ч арга байхгүй хэрэглэгч болсон. Тиймээс хамгаална гэдгийг хэрхэн ойлгохоо мэдэхгүй байна;
- Хүүхдийн цахим орчин дахь хэрэглээ нь эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналттай шууд холбоотой учир түүнд чиглэсэн зүйл заалт оруулж хариуцлагыг өндөржүүлэх тал дээр анхаарах;
- эрх зүйн мэдээллийн талаар мэдээлэл өгөх;
- Сургуулийн эцэг эхчүүд нийлээд гар утас, PC-ний хэрэглээ хянах төлбөртэй цогц программ худалдаж авбал зүгээр байх;
- Энэ төрлийн гэмт хэрэг гарч л байгаа байх. Сайн хуульчилж өгөх ёстой;
- Шүүлтүүртэй мэдээллийг хүргэх;
- Нийгмийн сүлжээнд байршуулж байгаа мэдээлэлд тодорхой босго тавьж, мэдээлэл байршуулж байгаа эх сурвалжийг хянадаг байх шаардлагатай байна;
- Эцэг эхчүүд өөрсдөө анхаарах;
- Цахим орчины хэрэглээг багасгах зэрэг болно.

Дээр дурдсан асуултанд хариулт өгсөн агуулгыг ерөнхийд нь дүгнэн үзвэл эцэг, эх, асран хамгаалагч нар нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн орчинг бүрдүүлэх, хүүхдэд хүрч байгаа мэдээллэлд хяналт тавих, шүүлт хийх, тус асуудлыг нийтэд хүрэхүйц түгээх, сурталчилах зэрэг талаар дурдсан байна.

Эцэг эхээс авсан судалгааны нэгдсэн үр дүн:

Нийт 253 эцэг, эхээс 6 төрлийн асуулга бүхий судалгаа авахад эцэг эхийн хяналт сул байдаг, хүүхдүүд нийгмийн сүлжээнд дарамт шахалтанд өртөж байгаагүй, хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэггүй, нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын талаар мэдлэг дунд эсхүл бага зэрэг гэсэн хариултуудыг дийлэнх нь сонгосон байгаа бөгөөд тусгайлсан хууль гаргах нь зүйтэй гэсэн саналыг дийлэнх нь гаргасан байна.

Хавсралт 3. Хуулийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судалсан суурь асуултуудын хариулт

а/ Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Нийцэж байгаа
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох	Тийм		Нийгмийн 1-р хэсгийн эмзэг бүлэг болох хүүхдүүдийн эрхийн оролцоог бүрдүүлнэ.

	Боломжийг бүрдүүлсэн эсэх			
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Асуудал тус бүрээр бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх нөлөөг тооцсон.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Хүүхдийн эрх ашгийг хамгаална.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		НҮБ-ийн Хүүхдийн эрхийн тухай Конвенц буюу хүүхдийн эрхийн тухай цогц хууль бүхий баримт бичгийн зөвлөмжтэй нийцэж байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		

2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх			Хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх			
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Үгүй		Эрх агуулагчдыг ангилан, тодорхойлох зохицуулалт агуулаагүй. Тэдгээрийн эмзэг байдал, эрх ашиг ямар нэгэн байдлаар хөндөгдөхгүй.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй		
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх	Үгүй		

	(хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)			
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

б/ Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үрнөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	байршил өөрчлөгдөхийг оролцуулан)				
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм			Цахим сүлжээн дахь гэмт хэргийн шинжтэй үйлдэлээс хүүхдийг хамгаалах
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

болон захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
эрх	5.Өмчлөх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Иновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Хүүхдийн эрхийг нийгмийн сүлжээнд хамгаалах, энэ чиглэлээр санал гомдол хүлээн авах, хяналт тавих эрх бүхий албан тушаал гарах боломжтой.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажлын эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	11.Олон улсын харилцаа	Тийм		

в/ Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.

	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

г/ Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	түлшний		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	хэрэглээг		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	нөлөө		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	агаарын		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц		3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол		4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
		5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 ОН**

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл нь 6 бүлэг, 20 зүйлтэй анхдагч хууль байх бөгөөд 13 насанд хүрээгүй хүүхдэд нийгмийн сүлжээг ашиглуулахыг хориглох, 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, насны баталгаажуулалт хийх, зохицуулалттай нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээ хийх, оролцогч талуудын эрх, үүрэг, төрийн байгууллагын чиг үүрэг, гомдол мэдээлэл хүлээн авах, хариуцлагын зохицуулалтыг тусгасан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу дараах үе шаттайгаар хийж, дүгнэв.

1. Хуулийн төслийн үр нөлөөх үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль болон "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын (цаашид "Аргачлал" гэх) 2 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон ба шалгуур үзүүлэлт сонгохдоо тус хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцааны онцлог, хамрах хүрээтэй уялдуулав.

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлыг харгалзан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Харилцан уялдаа.

2.1. Зорилгод хүрэх байдал:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17.2.1-д "хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх" гэж заасны дагуу болон аргачлалын 2.3 дахь хэсэгт "Зорилгод хүрэх байдал нь тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт" гэж тодорхойлсны дагуу энэ шалгуур үзүүлэлтийг сонгов.

2.2. Ойлгомжтой байдал:

Аргачлалын 2.5 дахь хэсэгт "Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгах үүднээс сонгов.

2.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал:

Аргачлалын 2.6 дахь хэсэгт "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгахгаар сонгов.

2.4. Харилцан уялдаа:

Аргачлалын 2.8 дахь хэсэгт "Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулиудтай нийцсэн эсэхийг шалгадаг гэж зааснаар энэ шалгуурыг сонгосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. Зорилгод хүрэх байдлын хүрээнд хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэгт заасан насны зохицуулалт урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээ, насны баталгаажуулалт, 7 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээ, 10 дугаар зүйлд заасан нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үүрэг, 11 дүгээр зүйлд заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн үүрэг, 18 дугаар зүйлд заасан гомдол мэдээллийн зохицуулалт нь хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах зорилгыг хангаж чадах эсэхийг үнэлнэ.

3.2. Ойлгомжтой байдлын хүрээнд хуулийн төслийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёоны тодорхойлолт болон 6, 7 дугаар зүйлд заасан технологийн хамгаалалт ба эрсдэлийн үнэлгээ, 8-12 дугаар зүйлд заасан оролцогчдын эрх, үүрэг, 13-17 дугаар зүйлд заасан төрийн байгууллагын чиг үүрэг, 18, 19 дүгээр зүйлд заасан гомдол мэдээлэл, хариуцлагын зохицуулалт нь хэрэгжүүлэгч этгээдэд ойлгомжтой, тодорхой бөгөөд хэрэглэхэд эргэлзээ үүсгэхгүйгээр томъёологдсон эсэхийг үнэлнэ.

3.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын хүрээнд хуулийн төслийн 6.2, 6.3, 6.4, 8.2, 9.1, 9.2, 10.1, 10.2, 11.1, 12.1, 12.2, 13-17, 18 дугаар зүйлд тусгасан зохицуулалтууд нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, боловсролын сургалтын байгууллага, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгч болон төрийн байгууллагын зүгээс хэрэгжих боломжтой, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг үнэлнэ.

3.4. Харилцан уялдааны хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Ийнхүү дээрх зохицуулалтууд нь хуулийн төслийн үндсэн агуулгыг бүрдүүлж, хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой тул үр нөлөөний үнэлгээг эдгээр зохицуулалтын хүрээнд хийж гүйцэтгэхээр тогтоов.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Хүснэгт 1.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Тандан судалгааны үеэр тодорхойлсон асуудлыг хуулиар зохицуулсан харилцааг тусгасан байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах, ойлгомжтой байдлыг судлах
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, төрийн байгууллагад үзүүлэх нөлөө	Оролцогч талуудын эрх ашиг, хэрэгцээ шаардлага, нийгмийн хүлээлтэд нийцэж байгаа эсэхийг шалгах
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгуурын хүрээнд хуулийн төслийн зорилго нь тандан судалгаагаар тодорхойлсон асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн эсэх, хэрэгжсэнээр хүлээгдэж буй үр дүнд хүрэх боломжтой эсэхийг үнэлэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон оролцогч талуудын харилцааг зохицуулах зорилгыг тодорхойлсон байна.

№	Тандан судалгаагаар тодорхойлсон асуудал	Хуулийн төсөлд тусгагдсан байдал
1	Хүүхдийн нийгмийн сүлжээ ашиглах насны зохицуулалт, хамгаалалтын эрх зүйн орчин хангалтгүй байна.	Хуулийн төслийн 6.2-т нийгмийн сүлжээг 13 насанд хүрээгүй хүүхдэд ашиглуулахыг хориглож, 6.3-т 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээр, 6.4-т насны баталгаажуулалт хийхээр тусгасан. Мөн 10.1.2-т 13 насанд хүрээгүй хүүхдийг бүртгэхгүй байх, 10.1.3-т 13-16 насны хүүхдийг баталгаажуулан бүртгэх үүргийг нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид ногдуулсан байна.
2	Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хүүхэд хамгаалах үүрэг тодорхойгүй байна.	10 дугаар зүйлд нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үүргийг тодорхойлж, хэрэглэгчийн насны бүлгийг баталгаажуулах, 13 насанд хүрээгүй хүүхдийг бүртгэхгүй байх, хориотой агуулгыг устгах, хүүхдэд хортой агуулгад хандалтыг хязгаарлах, технологийн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, төлөөлөгч/албан ёсны харилцах нэгж томилох, жил бүр тайлан хүргүүлэх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.
3	Хүүхдийн хувийн мэдээлэл цахим орчинд хамгаалагдах эрх зүйн баталгаа хангалтгүй байна.	5.1.4-т хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах зарчмыг тусгаж, 6.3.2-т хүүхдийн хувийн мэдээлэл, байршил болон бүртгэлийн нууцлалыг хамгаалах анхдагч тохиргоо хэрэгжүүлэхээр, 10.1.1, 10.2, 11.1.2-11.1.4-т насны баталгаажуулалтын мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй байдлаар солилцох, нууцлалыг хангах зохицуулалтыг тусгасан байна. Хадгалах, устгах хугацаа, мэдээллийн хамгийн бага хэмжээний зарчмыг журмаар нарийвчлах шаардлагатай.
4	Хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагын чиг үүрэг тодорхой бус байна.	13-17 дугаар зүйлд Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийг тус тус тодорхойлсон байна.

5	Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд гомдол, мэдээлэл шийдвэрлэх тогтолцоо сул байна.	18 дугаар зүйлд гомдол, мэдээлэл хүлээн авах, шилжүүлэх, бүртгэл хөтлөх, эрх бүхий этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шалгах зохицуулалтыг тусгасан. Мөн 8.2.8, 9.2.5, 10.1.9, 12.1.5-д холбогдох этгээд мэдээлэх, шууд харилцах суваг нээх үүргийг тусгасан байна.
6	Цахим орчинд хүүхдэд чиглэсэн дарамт, заналхийлэл, зохисгүй агуулгаас хамгаалах механизм дутмаг байна.	6.3.3-6.3.5-д хориотой, хүүхдэд хортой агуулгын харагдац, түгээлт, санал болгох алгоритмыг хязгаарлах, мэдээлэх, гомдол гаргах, хаах технологийн боломж бүрдүүлэхээр, 10.1.4-т хориотой агуулгыг ажлын 8 цагт багтаан устгах, 10.1.5-т хүүхдэд хортой агуулгад 72 цагийн дотор хандалтыг хязгаарлах арга хэмжээ авах үүргийг тусгасан байна.

4.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгав.

Хуулийн төсөл нь бүтэц, эх бичвэрийн агуулгад тавигдах шаардлагыг хангасан байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлага	Нийцтэй байдал
1	29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Харилцаа холбооны тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай зэрэг хуультай уялдуулан боловсруулагдсан тул шаардлагыг хангасан байна.
2	29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан байна.
3	29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Судалгаагаар зохицуулах харилцааны хүрээнээс хэтэрсэн зохицуулалт тогтоогдоогүй.
4	29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Энэ төрлийн зөрчил илрээгүй бөгөөд шаардлагыг хангасан байна.
5	29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтууд агуулгын хувьд харилцан уялдаатай байна.
6	29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
7	29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлагыг хангасан байна.
8	29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим,	Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томьёо, үйлчилгээ эрхлэгч болон төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхой тусгасан байна.

	харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	
--	--	--

Хүснэгт 4.

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	Нийцтэй байдал
1	30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан байна.
2	30.1.2. нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Нэр томъёоны хэрэглээнд энэ төрлийн зөрчил ажиглагдаагүй.
3	30.1.3. үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан байна.
4	30.1.4. хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
5	30.1.5. жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Энэ шаардлагад нийцсэн байна.

3.1. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, төрийн байгууллагын эрх ашиг, хэрэгцээ шаардлага болон нийгмийн хүлээлтэд нийцэж байгаа эсэхийн хүрээнд үнэлэв.

Хуулийн төслийн зохицуулалт нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, цахим орчны аюулгүй байдлыг хангах, хүүхдийг насанд тохироогүй агуулга болон цахим эрсдэлээс урьдчилан сэргийлэх нийгмийн хэрэгцээнд нийцэж байна.

Хуулийн төсөл хэрэгжсэнээр хүүхдийн цахим орчны аюулгүй байдал сайжирч, эцэг эх, асран хамгаалагч хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээнд илүү үр нөлөөтэй хяналт тавих эрх зүйн үндэс бүрдэхээр байна. Мөн нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хүүхдийн мэдээллийг хамгаалах, хэрэглэгчийн насыг баталгаажуулах, хуульд заасан үүргийг хэрэгжүүлэх хариуцлага тодорхой болж, төрийн байгууллагуудын эрх хэмжээ, хамтын ажиллагаа илүү оновчтой зохицуулагдана.

Хэдийгээр хуулийн төсөл хэрэгжих явцад нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид нас баталгаажуулах технологи нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой тодорхой техникийн болон санхүүгийн зардал үүсэх боломжтой боловч энэхүү зохицуулалт нь хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах нийтийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн тул үндэслэлтэй гэж үзэв.

Түүнчлэн хуулийн төсөлд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой тусгасан бөгөөд хүүхэд хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, цахим орчны эрсдэлийг бууруулах төрийн бодлоготой нийцэж байгаа нь нийгмийн хүлээлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн зохицуулалт болохыг харуулж байна.

Иймд энэхүү хуулийн төсөл нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч болон төрийн байгууллагын эрх ашиг, хэрэгцээ шаардлагыг харгалзан боловсруулагдсан бөгөөд нийгмийн хүлээлтэд нийцсэн, хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж үнэлэв.

3.2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалын 4.10-т заасан дараах 16 асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь дагалдах хуулийн төслүүдийн хамт шалгахыг зорилоо.

Хүснэгт 5.

№	Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн зохицуулалт нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахим орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилттой нийцэж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд дурдсан Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох салбарын хууль тогтоомж нь зохицуулах харилцаанд шууд хамаарах хууль байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	4 дүгээр зүйлд тодорхойлсон нэр томьёо нь тус хуулийн төсөл болон бусад хуульд хэрэглэж буй нэр томьёотой нийцэж байна.

4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч болон бусад оролцогчийн чиг үүргийг тодорхой тусгасан байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй. Хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, үйлчилгээ эрхлэгчийн үүрэг, төрийн байгууллагын чиг үүрэг, гомдол шийдвэрлэх ажиллагаа, хариуцлагын зохицуулалтыг тусгасан байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй. Хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслөөр шинэ төрлийн албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй. Харин Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулж, хуулийн шаардлагыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх торгуулийн хариуцлагыг тусгасан байна.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй. Хуулийн төслөөр шинээр тусгай зөвшөөрөл бий болгох зохицуулалт тусгагдаагүй.

12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм. Хуулийн төслийн 10 дугаар зүйлд энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгасан. Түүнчлэн дагалдах Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр 16 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэсэн насны хязгаартай нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид хүлээлгэх торгуулийн хариуцлагыг тодорхой зохицуулсан байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэллээ.

Тус хуулийн төсөл нь нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, төрийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, хэрэглэгч болон бусад оролцогч этгээдийн эрх, үүргийг тодорхой болгож, хүүхдийг цахим орчны дарамт, заналхийлэл, зохисгүй агуулгаас хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

5.1. Баримтжуулалт

“Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай” хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу дараах баримт, мэдээллийг ашиглав. Үүнд:

- Хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд;
- Хуулийн төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга;
- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан тайлан;
- Хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос ирүүлсэн санал.

5.2. Үнэлэлт, дүгнэлт

5.2.1. Зорилгод хүрэх байдлын үнэлгээний үр дүн

Хуулийн төслийн үндсэн зорилго нь нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Үнэлгээний хүрээнд хуулийн төслийн 6 дугаар зүйлд тусгасан тусгасан 13 насанд хүрээгүй хүүхдэд нийгмийн сүлжээ ашиглуулахыг хориглох, 13-16 насны хүүхдийн хэрэглээнд технологийн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, насны баталгаажуулалт хийх зохицуулалт, 7 дугаар зүйлд заасан эрсдэлийн үнэлгээ, 10, 11 дүгээр зүйлд заасан үйлчилгээ эрхлэгчдийн үүрэг, 18 дугаар зүйлд заасан гомдол мэдээллийн зохицуулалт нь тандан судалгаагаар тогтоогдсон хүүхдийн цахим хэрэглээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байна.

Иймд “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь тавьсан зорилгодоо хүрэх боломжтой гэж үнэлэв. Гэхдээ насны баталгаажуулалтын аргачлал, хувийн мэдээлэл боловсруулах баталгаа, хандалт хаах арга хэмжээний үе шат, гомдол шийдвэрлэх хугацааг нарийвчлан зохицуулах нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.

5.2.2. Ойлгомжтой байдлын үнэлгээний үр дүн

Хуулийн төслийн бүтэц, зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоо, нэр томьёоны

тодорхой байдал, зохицуулалтын логик дарааллыг үнэлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцсэн байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд хэрэглэгдэх нэр томьёог тодорхойлсон нь хуулийг хэрэгжүүлэх субъектүүдэд зохицуулалтын хүрээг ойлгоход дөхөм болгожээ.

Түүнчлэн үйлчилгээ эрхлэгчийн үүрэг, иргэн болон бусад этгээдийн хүлээх хариуцлага, төрийн байгууллагын чиг үүргийг тусад нь зохицуулсан нь хуулийг хэрэглэх явцад эрх, үүргийн давхардал, ойлголтын зөрүү үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой байна.

Хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь тодорхой, нэг мөр ойлгогдох байдлаар боловсруулагдсан бөгөөд хэрэгжүүлэгч байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд хэрэглэхэд хүндрэл үүсгэхээргүй байна.

Иймд “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл шаардлага хангасан гэж дүгнэв.

5.2.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээний үр дүн

Хуулийн төслийн зохицуулалт нь хүүхдийн эрхийг хамгаалах, цахим орчин дахь эрсдэлийг бууруулах нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн бөгөөд холбогдох оролцогч талуудын эрх ашигтай нийцэж байна.

Нийгмийн сүлжээний хэрэглээ нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд хүүхдийг насанд тохироогүй мэдээлэл, цахим дарамт, сөрөг нөлөө бүхий агуулгаас хамгаалах шаардлага бий болсон бөгөөд уг хуулийн төсөл нь энэхүү хэрэгцээг эрх зүйн зохицуулалтаар хангах зорилготой байна.

Хэдийгээр нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид болон зарим оролцогчдод хэрэглэгчийн нас баталгаажуулах тогтолцоо бий болгох, мэдээллийн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх зэрэг тодорхой үүрэг, зохион байгуулалтын шаардлага үүсэх боловч урт хугацаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, цахим орчны эрсдэлийг бууруулах ач холбогдолтой байна.

Мөн нас баталгаажуулах үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн хамгаалалтыг тусгайлан зохицуулсан нь хүний хувийн мэдээллийг хамгаалах зарчимтай нийцэж байна.

Иймд “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэгжих боломжтой зохицуулалт гэж үнэлэв.

5.2.4. Харилцан уялдааны үнэлгээний үр дүн

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан хуулийн төслийн уялдаа холбоог шалгах хэрэгслийн хүрээнд тодорхой асуултуудад хариулах замаар үнэлэхэд хуулийн уялдаа холбоо хангагдаж байна.

Мөн төрийн байгууллагуудын чиг үүргийг давхардуулахгүйгээр тодорхойлж, хэрэгжилтийн хяналт, гомдол мэдээлэл шийдвэрлэх тогтолцоог тусгасан нь эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог хангаж байна.

Иймд “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь холбогдох хууль тогтоомжтой нийцсэн гэж үзэв.

5.3. Зөвлөмж

Хуулийн төслийн чанар, хэрэгжих боломжийг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг гаргав.

1. Нас баталгаажуулах нэгдсэн аргачлал, стандартыг боловсруулах

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэрэглэгчийн насыг баталгаажуулах арга, технологийн шийдэл, мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг тусгасан нэгдсэн аргачлал, стандартыг боловсруулж, холбогдох журмаар нарийвчлан зохицуулах нь зүйтэй.

2. Насны хязгаартай нийгмийн сүлжээний жагсаалтыг урьдчилан батлах

Хуулийн хэрэгжилтийн бэлтгэлийг хангах үүднээс насны хязгаартай ашиглах нийгмийн сүлжээний жагсаалтыг урьдчилан тогтоож, үйлчилгээ эрхлэгчдэд шаардлагатай мэдээллийг хүргэх арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3. Гадаадын нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах зохицуулалтыг тодорхой болгох

Хуулийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор гадаадын нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчтэй хамтран ажиллах, шаардлага хүргүүлэх, мэдээлэл солилцох болон хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг нарийвчлан боловсруулах нь зүйтэй.

4. Хувийн мэдээлэл боловсруулах зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох

Нас баталгаажуулах ажиллагааны хүрээнд цуглуулсан хувийн мэдээллийг боловсруулах, хадгалах, устгах, хамгаалах ажиллагаатай холбоотой шаардлагыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан нарийвчлан тодорхойлсноор хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой.

5. Хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг шилжилтийн хугацаанд бүрэн хангах

Хуулийг дагаж мөрдөхөөс өмнө эрх бүхий байгууллага, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагааг хангаж, хэрэгжилтэд шаардлагатай зохион байгуулалт, мэдээлэл, техникийн бэлтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

---oOo---

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

/Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл/

Улаанбаатар хот

2026 он

Агуулга

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хоёр. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:

2.1.Зардал үүсэх эсхийг нягтлах

Гурав. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:

- 3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 3.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 3.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 3.6.Нэмэлт зардлыг тооцох.

Дөрөв. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

- 4.1.Төрийн байгууллагад үүсэх зардал байгаа эсэхийг нягтлах, зардлыг тооцоолох.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4- т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно. Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн зохицуулалтыг хууль санаачлагчаас хүлээн авч судлан үзэхэд хуулийн төсөл батлагдсанаар зардал тээгч гурван бүлэг этгээдээс зөвхөн хуулийн этгээдэд тодорхой төрлийн зардал үүсгэхээр байна. Энэ талаар цаашид дэлгэрүүлэн тооцох болно.

ХОЁР. НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцоо хийх аргачлал”-д дараах үе шатын дагуу хийхээр зохицуулсан болно. Үүнд:

- Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нэмэлт зардлыг тооцож гаргах;
- Хялбарчлах боломжийг шалгах

Дээрх бүх үе шат нь иргэнд дээрх хуулийн зохицуулалтаар шинээр бий болгож байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон тухайн нэг иргэнээс зарцуулах хугацааг тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгддэг болно.

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөлд иргэнд үүрэг оногдуулсан, хамааралтай зохицуулалт тусгагдаагүй бөгөөд аргачлалд заасан дараагийн үе шатыг шалгах шаардлагагүй буюу иргэнд зардал үүсгээгүй байна.

ГУРАВ. НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн үйлчлэлд хамаарахаар заасан хуулийн этгээдүүдийн хувь уг хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тэдэнд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;

- нэмэлт зардлыг тооцох.

3.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн зохицуулалтыг судалж үзэхэд мөн хуулийн төслийн 10 дугаар зүйлд дараах зохицуулалт туссан байна. Үүнд:

10.1.1.мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологи ашиглан хэрэглэгчийн насны бүлгийг баталгаажуулан бүртгэх;

10.1.2.нийгмийн сүлжээнд 13 насанд хүрээгүй хүүхдийг бүртгэхгүй байх;

10.1.3.нийгмийн сүлжээнд 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийг баталгаажуулан бүртгэх;

10.1.4.нийгмийн сүлжээнд нийтэлсэн, түгээсэн, сурталчилсан хориотой агуулгыг ажлын 8 цагт багтаан устгах;

10.1.5.эрх бүхий байгууллагын мэдэгдэлд үндэслэн хүүхдэд хортой агуулгад 72 цагийн дотор хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авах;

10.1.6.хиймэл оюун ашиглан бүтээсэн контентод "хиймэл оюун ашиглан бүтээсэн" гэх агуулгатай таних тэмдгийг харагдахуйц байдлаар байрлуулах;

10.1.7.энэ хуулийн 6.3-т заасан технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

10.1.8.нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үүргийн хэрэгжилтийг хангахад шуурхай дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах суурин төлөөлөгч, төлөөлөх байгууллага эсхүл албан ёсны харилцах нэгж томилж, Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;


10.1.9.хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой гомдол, мэдээлэл, эрсдэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор эрх бүхий байгууллагатай шууд харилцах суваг нээх;

10.1.10.Монгол Улсын хэрэглэгчийн тоон мэдээлэл, гомдол шийдвэрлэлт, хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд ашиглаж буй технологийн шинэчлэлийн талаарх тайланг жил бүр Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэх.

Энэ нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий тодорхой хуулийн этгээдийг зааж өгсөн байна. Иймд энэхүү үүргийг биелүүлэхтэй холбоотой үүсэх зардлыг аргачлалд заасан алхамын дагуу гүйцэтгэн тооцоолох болно.

3.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хүн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг болон програм хангамж хөгжүүлэгч байгууллагын ажилтантай ярилцлага хийх замаар гарах үр дүнг харгалзан үзсэн болно.

Иймд энэ үүргийн тухайд үүргийг нэг удаа хэрэгжүүлэх тул тухайн зардал нь хууль хэрэгжиж эхэлснээр нэг удаа гарах юм.

Тухай үүргийн агуулгыг тогтоохдоо хүн, хуулийн этгээдийн хийгдэх ажиллагааг дор задлан тусгав.

Хүснэгт №1

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	Насны хязгаартай хэрэглэгчийн бүртгэл үүсгэхээс сэргийлэх	Технологийн шийдэл олох	Холбогдох албан тушаалтнуудтай хамтран ажиллах	1-2 сар
		Код бичих		1 сар хүртэл
		Турших	Туршилтын үйл ажиллагааг тодорхой хүрээнд явуулах	1 сар хүртэл
		Шүүлтүүр нэмэх	Хүүхэдтэй холбоотой мэдээ, мэдээлэл цуглуулахгүй байх шүүлтүүр нэмэх	1 өдөр
		Флатформд мэдээлэл/цэс нэмэх	Үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	1 өдөр
2	Нийт хугацаа			4 сар 2 өдөр

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцооны тайлан

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргав.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар “2024 оны байдлаар 4 дүгээр улирлын байдлаар дундаж цалин 2.229.400 төгрөг болж өссөн байна.” гэж уг судалгаанд дурдсан байна. Ажиллах хугацааг Хөдөлмөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан ажлын цагийг баримтлав.

Хүснэгт №2

Ажлын хөлс = Үндсэн цалинг : Ажиллах хугацаа
2,229,400 : 22 өдөр = 101,336.3 төгрөг /нэг өдрийн ажлын дундаж хөлс/

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс	Нэг бүрийн зардал
1	Насны хязгаартай хэрэглэгчийн бүртгэл үүсгэхээс сэргийлэх	Техналогийн шийдэл олох	Холбогдох албан тушаалтнуудтай хамтран ажиллах	1-2 сар	2,229,400	2,229,400 - 4,458,800
		Код бичих		1 сар хүртэл	2,229,400	2,229,400
		Турших	Туршилтын үйл ажиллагааг тодорхой хүрээнд явуулах	1 сар хүртэл	2,229,400	2,229,400
		Шүүлтүүр нэмэх	Хүүхэдтэй холбоотой мэдээ, мэдээлэл цуглуулахгүй байх шүүлтүүр нэмэх	1 өдөр	101,336.3	101,336
		Флатформд мэдээлэл/цэс нэмэх	Үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	1 өдөр	101,336.3	101,336
2	Нийт зардал					9,120,272

3.3.ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Одоогоор нэг платформд тодорхой тооны хэдэн хэрэглэгч байгаа талаар тоон мэдээлэл байхгүй байх тул тоон үзүүлэлт тогтоох боломжгүй байна.

Мөн энэ үүргийг хуулийн этгээд нэг л удаа гүйцэтгэснээр дуусгавар болох юм. Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

$$\text{ТОХИОЛДЛЫН ТОО} \times \text{ДАВТАМЖ} = \text{ТООН ҮЗҮҮЛЭЛТ}$$

Нэг этгээд Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн дагуу хориглосон этгээдийг нэвтрүүлэхийг хориглосон үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах үйл ажиллагааны зардал 9,120,272 төгрөг байхаар тооцоолсон болно.

3.4. НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүргийн нийт зардлыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлснээр гаргах юм.

$$\text{НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ} \times \text{ТООН ҮЗҮҮЛЭЛТ} = \text{НИЙТ ЗАРДАЛ}$$

3.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР:

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн дагуу нэг этгээд өөрийн эрхэлж буй нийгмийн сүлжээнд тодорхой шүүлтүүр бүхий хуульд заасан хориглосон этгээдийг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авахаар заасан болно

Энэ үүргийг тухайн этгээд нэг удаа өөрийн платформд нэвтрүүлснээр дуусгавар болох тул зохицуулалтын хувилбарыг өөрчлөх болон хялбаршуулах шаардлагагүй буюу хуулийн төслөөр хэтрүүлсэн их үүрэг оногдуулаагүй байна. Иймд зардлыг бууруулах тодорхой саналгүй болно.

3.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөлд холбогдох этгээдээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтод хамруулж ойлгох бөгөөд нэмэлт зардал гархааргүй байна.

**ДӨРӨВ. НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БУЮУ УЛСЫН
ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн 4 дүгээр бүлэг буюу “Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоо, аюулгүй байдлыг хангах талаар төрийн байгууллагын чиг үүрэг” бүлэгт төрийн зүгээс уг салбарт үзүүлэх баталгааг зааж өгсөн байна. Энэ хэсэгт болон хуулийн төслийн бусад хэсгүүдэд төр тодорхой чиг үүрэг хүлээсэн зохицуулалт байхгүй буюу хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад дурдснаар төрийн оролцоог хамгийн бага түвшинд буюу холбогдох сайд өөрийн эрх үүргийн хэмжээнд захирамж гаргахаар төсөл нь боловсруулагдсан байна. Иймд хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор төрийн аль ч байгууллага, төсөвт зардал үүсгэхээргүй байна.

---oOo---

Түүнчлэн нийгмийн сүлжээнд бусадтай харилцаа тогтоож, улмаар гэмт хэргийн хохирогч болох явдалууд ч нэмэгдсээр байна.

Хэдийгээр ийнхүү нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхтэй хамааралтай олон хууль бус ажиллагаа явагдаж байгаа боловч цахим орчныг төрөөс бүхэлд нь хянан зохицуулах боломжгүй юм.

Тиймээс цахим орчин, интернэт хэрэглээг эрх зүйгээр зохицуулахын зэрэгцээ технологийн шийдлийн хувьд зохицуулах нь илүү оновчтой болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Дийлэнх орнууд интернэт орчинд насанд хүрээгүй хүүхдэд сөргөөр нөлөөлөх мэдээллийг хориглох, хязгаарлах, үүнийг зохицуулах байгууллага, хороог байгуулан ажиллуулах арга замыг сонгон хэрэглэж байна.

Манай улсын хувьд ч хүүхдийн эрхийн зөрчил үүсгэх, насанд хүрээгүй хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэх мэдээллийг хориглох, хязгаарлах харилцааг зохицуулах зайлшгүй хэрэгцээ бий болсон гэж үзэхээр байна.

Ийнхүү нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын асуудлыг манай улсын хувьд хууль тогтоомжоороо бүрэн зохицуулаагүй бөгөөд энэ төрлийн харилцааг зохицуулах хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага үүсэн бий болсон байх тул эл асуудлыг урьдчилан тандан судлах явдал нэн чухлаар тавигдаж байна.

Тиймээс нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах нь зөв зохистой талаар судлан үзэх нь энэхүү тандан судалгааны “*үндсэн асуудал*”-аар тодорхойлж байна.

Асуудлыг тодруулах үүднээс авсан судалгааны талаар

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулахтай холбогдсон асуудлаар өсвөр насны хүүхдүүдээс болон эцэг, эх, асран хамгаалагч нараас дараах судалгааны анкетаар судалгаа авсан болно.

Хүүхдээс авсан судалгааны анкетын загвар:

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ ТАЛААРХ САНАЛ АСУУЛГА /ХҮҮХДЭЭС АВАХ АСУУЛГА/

Энэ өдрийн мэндийг хүргэе!

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах талаарх харилцааг зохицуулахад чиглэсэн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны хүрээнд энэхүү санал асуулгыг бэлтгэсэн болно.

Бидний ажилд дэмжлэг үзүүлж энэхүү судалгааг үнэн зөв бөглөж өгөхийг танаас хичээнгүйлэн хүсье.

1. Хэдэн настай вэ?

а. 10-12

- б. 12-14
- в. 14-16
- г. 16-18

2. Өдөрт дунджаар хэдэн цагийг нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг вэ?

- а. 1-2 хүртэлх цаг
- б. 2-4 хүртэлх цаг
- в. 4 -8 хүртэлх цаг
- г. 8 болон түүнээс дээш цаг

3. Интернэтийг ихэнх тохиолдолд ямар зорилгоор хэрэглэдэг вэ?

- а. Мэдээ, мэдээлэл цуглуулах, олж авах
- б. Найз нөхдийн харилцаа
- в. Хичээл, сургалттай холбоотойгоор ашиглах
- г. Нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)
- д. Онлайн тоглоом хайх, тоглох (Minecraft, PUBG mobile, Roblox, Mobile Legend зэрэг)
- е. Бусад

4. Нийгмийн сүлжээнд танихгүй хүнээс ирсэн хүсэлт, мессежинд хариу өгдөг үү?

- а. Хариу өгдөг
- б. Хариу өгдөггүй
- в. Сонирхож үздэг /орж хардаг/
- г. Шууд блок хийдэг

5. Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, пост авч байсан уу?

- а. Тийм
- б. Үгүй

6. Хэрэв тийм бол дараах сонголтуудаас алийг нь сонгох вэ?

- а. Хувийн мэдээллийг нийтэд тараах
- б. Дарамталсан үг зурвас
- в. Гутаан доромжилсон үг сэтгэгдэл
- г. Гэмт хэрэгт уруу татсан
- е. Садар самуун сурталчилсан
- ё. Бусад

7. Нийгмийн сүлжээнд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу?

- а. Тийм
- б. Үгүй

8. Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү?

- а. Хэрэглэдэг
- б. Хэрэглэдэггүй
- в. Тохиргооны талаар мэдэхгүй
- г. Зарим мэдээллийг нууцалдаг

9. Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний цагт ямар нэгэн хяналт тавьдаг уу?

- а. Үргэлж
- б. Заримдаа
- в. Огт үгүй

10. Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний агуулгад ямар нэгэн хяналт тавьдаг уу?

- а. Үргэлж
- б. Заримдаа
- в. Огт үгүй

11. Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ?

- а. Эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана
- б. Найз нөхдөөсөө зөвлөгөө авна
- в. Сургуулийн багшид хандана
- г. Хүүхдийн тусламжийн байгууллагаас тусламж хүснэ
- е. Бусад

БАЯРЛАЛАА

Эцэг, эх, асран хамгаалагч нараас авсан судалгааны анкетын загвар:

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ЗОХИЦУУЛАХ
САНАЛ АСУУЛГА
/ЭЦЭГ ЭХЭЭС АВАХ АСУУЛГА/**

Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны хүрээнд энэхүү санал асуулгыг бэлтгэсэн болно.

Бидний ажилд дэмжлэг үзүүлж энэхүү судалгааг үнэн зөв бөглөж өгөхийг танаас хичээнгүйлэн хүсье.

1. Та хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хяналт тавьдаг уу?
 - а. Хяналт тавьдаг
 - б. Хяналт тавьдаггүй
 - в. Хааяа хяналт тавьдаг
2. Та цахим орчин дахь мэдээллийн шүүлт хийх тохиргооны талаар хэр мэдээлэлтэй вэ?
 - а. Шүүл хийх тохиргоо ашигладаг
 - б. Сонсож байсан
 - в. Мэдэхгүй
3. Таны хүүхэд нийгмийн сүлжээнд үе тэнгийнхний дарамт, шахалтанд өртөж байсан уу?
 - а. Тийм
 - б. Үгүй
 - в. Мэдэхгүй
4. Таны хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэг үү?
 - а. Тийм
 - б. Үгүй
5. Та нийгмийн сүлжээнд хүүхдийн хамгаалалын талаар хэр мэдээлэлтэй вэ?
 - а. Хангалттай
 - б. Дунд
 - в. Бага зэрэг
 - г. Мэдэхгүй
6. Таньд нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн зохицуулалттай холбоотой санал байвал дор бичнэ үү.

ТАНД БАЯРЛАЛАА

Судалгааны үр дүн:

Судалгааг өсвөр насны хүүхдүүдээс онлайн болон цаасан хэлбэрээр цуглуулсан бөгөөд нийт 1129 хүүхэд хамрагдсан байна. Эцэг, эх, асран хамгаалагч нараас онлайн хэлбэрээр судалгааг авсан бөгөөд нийт 253 иргэд хамрагдсан байна.

а/ Хүүхдээс авсан судалгааны үр дүн:

Нийт 1129 хүүхдээс авсан судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

-Тус судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн насаар ангилан үзвэл нийт судалгаанд оролцогчдын 40 хувь нь 12-14 насны хүүхдүүд хамрагдсан байна;

- 46 хувь нь 2-4 хүртэлх цагийг нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг байна;

-Давхардсан тоогоор нийт 79 хувь нь нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдохоор, 65 хувь нь найз нөхдийн харилцаа холбоо тогтоохоор цахим орчныг хэрэглэдэг байна;

-Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, и-мэйл авч байсан уу гэсэн асуулгад 78 хувь нь авч байгаагүй гэсэн хариулт өгсөн нь сайшаалтай байна;

-Харин авч байсан гэж хариулсан 22 хувийн оролцогчдоос 50 хувь нь хувийн мэдээллийг нь нийтэд тараасан гэсэн хариултыг сонгосон байна;

-Интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу гэдэгт 56 хувь нь тийм гэж хариулснаас үзвэл цахим сүлжээнд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэл нь ямар нэгэн шүүлтүүргүйгээр байршиж байдаг гэсэн дүгнэлтэд хүрэхээр байна;

-Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү гэсэн асуулгад 60 хувь нь хэрэглэдэг гэж хариулсан байна;

-Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний цаг болон агуулгад хяналт тавьдаг уу гэж асуухад заримдаа гэдгийг 55 хувь нь сонгосноос үзвэл цахим сүлжээн дэх эцэг эхийн хяналт сул байна;

-Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ гэдэгт судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана, 41 хувь нь найз нөхдөөсөө зөвлөгөө авна гэсэн хариултыг сонгосон байна.

Үүнээс нэгтгэн дүгнэвэл 10-18 насны нийт 1129 хүүхдээс судалгаа авахад интернэтийг 2-4 цаг хүртэлх хугацаанд хэрэглэдэг, интернэтийг ихэвчлэн нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдох, найз нөхөдийн харилцаа холбоо тогтооход хэрэглэдэг, интернэт хэрэглээний цаг болон агуулгад эцэг, эхийн хяналт сул байдаг, интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралддаг, нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандахаар байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

б/ Эцэг эхээс авсан судалгааны үр дүн:

Нийт 253 эцэг, эхээс 6 төрлийн асуулга бүхий судалгаа авахад эцэг эхийн хяналт сул байдаг, хүүхдүүд нийгмийн сүлжээнд дарамт шахалтанд өртөж байгаагүй, хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэггүй, нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын талаар мэдлэг дунд эсхүл бага

зэрэг гэсэн хариултуудыг дийлэнх нь сонгосон байгаа бөгөөд тусгайлсан хууль гаргах нь зүйтэй гэсэн саналыг дийлэнх нь гаргасан байна.

Эцэг, эхчүүдээс нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн зохицуулалттай холбоотой дараах саналуудыг ирүүлсэн байна. Үүнд:

- хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай гэж боддог;
- эцэг эхчүүдийг цахим орчны мэдлэгийг нэмэгдүүлэх;
- тусгайлан хууль гаргаж сайтар хамгаалах нь зүйтэй байна;
- цахим орчны хэрэглээг хянах, аль болох утасны хэрэглээг багасгаж өөр зүйлд анхаарлыг хандуулах спортын ямар нэг төрлөөр хичээллүүлэх;
- Нийгмийн сүлжээнд зарим мэдээллийг хаалттай болгох, хүүхэд нэвтэрдэг учраас хориотой үг хэл ашиглахыг таслан зогсоох болон хүчирхийлэлтэй мэдээлэл түгээхгүй байх;
- Эрхзүйн зохицуулалт байх хэрэгтэй гэж боддог. Ганц хүүхэд ч биш шүү дээ. Хүүхдүүдээ цаг үргэлж хянаж чадахгүй, цаг үргэлж цахим хэрэглээг нь хязгаарлаад байж болохгүй асуудал эцэг эх бүрт бий байх. Эрхзүйн зохицуулалттай болж ухуулга хийж байж хүүхэд ч, томчууд ч өөрийгөө ч өрөөл бусдыг ч хамгаалах сэтгэл зүйтэй болох байх гэж боддог;
- Тодорхой сайт вэбүүдэд нэвтрэх боломжгүй нас заах;
- Насанд хүрээгүй хүүхдүүдийг заавал нийгмийн сүлжээнд холбож байгаа нь таалагддаггүй. Ангийн групп нээчихээд тэндээ энэ тэр зар оруулна. Багш нар бүүр шөнийн 23 24цагт ангийнхаа хүүхдүүдэд зарын чанартай мэдээлэл оруулдаг. Одоо шалгалт энэ тэр мэдээллээ цахим групптэй оруулдаг энэ мэтээр хүүхдийг цахим орчноос хол байлгах нөхцөл бүрдэхгүй байна. Зарим нь бүр цахимаар гэрийн даалгавар өгнө гээд тараадаг;
- Энэ төрлийн зохицуулалт байх нь зөв. Гол нь эрх зүйн орчин болоод технологийн шийдэл нь сайн байх хэрэгтэй;
- FB -г тодорхой насанд хүрсэн хүн хэрэглэгч болдог. Гэтэл хичээл мэдээлэл нь бүгд FB-ээр дамжиж хүрч байна. Тиймээс ямар ч арга байхгүй хэрэглэгч болсон. Тиймээс хамгаална гэдгийг хэрхэн ойлгохоо мэдэхгүй байна;
- Хүүхдийн цахим орчин дахь хэрэглээ нь эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналттай шууд холбоотой учир түүнд чиглэсэн зүйл заалт оруулж хариуцлагыг өндөржүүлэх тал дээр анхаарах;
- эрх зүйн мэдээллийн талаар мэдээлэл өгөх;
- Сургуулийн эцэг эхчүүд нийлээд гар утас, PC-ний хэрэглээ хянах төлбөртэй цогц программ худалдаж авбал зүгээр байх;
- Энэ төрлийн гэмт хэрэг гарч л байгаа байх. Сайн хуульчилж өгөх ёстой;
- Шүүлтүүртэй мэдээллийг хүргэх;
- Нийгмийн сүлжээнд байршуулж байгаа мэдээлэлд тодорхой босго тавьж, мэдээлэл байршуулж байгаа эх сурвалжийг хянадаг байх шаардлагатай байна;
- Эцэг эхчүүд өөрсдөө анхаарах;
- Цахим орчины хэрэглээг багасгах зэрэг болно.

Дээр дурдсан асуултанд хариулт өгсөн агуулгыг ерөнхийд нь дүгнэн үзвэл эцэг, эх, асран хамгаалагч нар нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн орчинг бүрдүүлэх, хүүхдэд хүрч байгаа мэдээллэлд хяналт тавих, шүүлт хийх, тус асуудлыг нийтэд хүрэхүйц түгээх, сурталчилах зэрэг талаар дурдсан байна.

Судалгааны дүнг Хавсралт 2-оос дэлгэрүүлэн үзнэ үү.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон нь

Энэхүү хэсгээр тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон бөгөөд тэдгээрт нөлөөлж буй хэлбэрийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулахсудалгааны дүнд үндэслэн гаргасан болно.

Хүснэгт 1


Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1. Төрийн байгууллага, албан тушаалтан	-Нийгмийн сүлжээнд хүүхдийн хэрэглээг зохицуулсан зохицуулалт, зөв зохистой хэрэглээний талаар зөвлөмж гаргадаг боловч тухайн зөвлөмжийн хэрэгжилтийг буцаан аваагүй байна. -Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүүхдийн интернэт хэрэглээтэй холбоотой Эцэг эх, багш нарт зориулсан зөвлөмж, Үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан зөвлөмж, Бага насны хүүхдүүдэд зориулсан зөвлөмж⁵-ийг гаргаж өөрийн цахим хуудаст байршуулсан байх боловч зөвлөмжийн хэрэгжилт сул, түүнийг таниулан сурталчилах ажил сайтар хийдэггүй байна -Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт цахим орчны зөв зохистой хэрэглээний талаархи мэдээлэл хангалтгүй байгаатай холбоотойгоор цахим орчны зохистой хэрэглээний талаарх сургалтын гарын авлага, материал, модуль хөтөлбөртэй болох хэрэгцээ, шаардлага байна.


⁵ Бага насны хүүхдүүдэд зориулсан зөвлөмж (crc.gov.mn)

		- Цагдаа, прокурор, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлүүд тодорхой төрлийн шторк, гарын авлага, зөвлөмжүүд хийдэг боловч яг тухайн зорилтот бүлэгт хүрээгүй байна.
2.	Аж ахуйн нэгж, байгууллага	-Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь насанд хүрээгүй хэрэглэгчид хүрэх сөрөг мэдээллийг шүүгч програм хангамжийн мэдээллийг хэрэглэгчид хүргэх үүргийг хуульчилах шаардлагатай. -Аж ахуйн, нэгж байгууллага нь нийгмийн сүлжээнд сурталчилгаа, мэдээ, мэдээлэл түгээхдээ насанд хүрээгүй этгээдэд хориглосон агуулга бүхий мэдээлэлд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, хандалтыг хязгаарласан програм ашигладаггүй байна.
3.	Төрийн бус байгууллага	-Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэл бүхий төрийн бус байгууллагууд цөөнгүй байх боловч үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, хүүхдийн цахим орчны хэрэглээний талаарх судалгаа шинжилгээний ажил хийдэггүй, энэ талаарх сургалт, мэдээллийн арга хэмжээ хангалтгүй байна.
4.	Иргэн	- Цахим орчин хөгжих, илүү олон төрлийн платформ, үйлчилгээ нэмэгдэж буйтай холбоотой хүүхдийн интернэт хэрэглээний хугацаа нэмэгдэж, түүнд эцэг, эхийн зүгээс хяналт тавьдаггүй, -Эцэг, эхийн зүгээс нийгмийн сүлжээнд нэвтрэх хэрэгсэлд хяналтын программуудын тохиргоог идэвхижүүлдэггүй, - Интернэтийн хэрэглээтэй холбоотой хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөггүй, зарим тохиолдолд эцэг, эхийн интернэт хэрэглээний мэдлэг дутмаг байна.
5.	Бусад хүн, хуулийн этгээд	-Хүүхдийг зохисгүй контентоос хамгаалах зорилгоор хязгаарлалт хийх арга хэмжээг хэрэгжүүлдэггүй,

4. Нийгмийн сүлжээнд танихгүй хүнээс ирсэн хүсэлт, мессежинд хариу өгдөг үү?




5. Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, и-мэйл авч байсан уу?




6. Хэрэв тийм бол дараах сонголтуудаас алийг нь сонгох вэ?




7.Интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу?




8. Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү?




9. Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний цагт ямар нэгэн хяналт тавьдаг уу?



10. Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний агуулгад ямар нэгэн хяналт тавьдаг уу?



11. Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ?



Хүүхдээс авсан судалгааны үр дүн:

Нийт 1129 хүүхдээс авсан судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

-Тус судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн насаар ангилан үзвэл нийт судалгаанд оролцогчдын 40 хувь нь 12-14 насны хүүхдүүд хамрагдсан байна;

- 46 хувь нь 2-4 хүртэлх цагийг нийгмийн сүлжээнд өнгөрүүлдэг байна;

-Давхардсан тоогоор нийт 79 хувь нь нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдохоор, 65 хувь нь найз нөхдийн харилцаа холбоо тогтоохоор цахим орчныг хэрэглэдэг байна;

-Нийгмийн сүлжээнд интернэт сүлжээний хэрэглэгчдээс заналхийсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон агуулгатай зурвас, и-мэйл авч байсан уу гэсэн асуулгад 78 хувь нь авч байгаагүй гэсэн хариулт өгсөн нь сайшаалтай байна;

-Харин авч байсан гэж хариулсан 22 хувийн оролцогчдоос 50 хувь нь хувийн мэдээллийг нь нийтэд тараасан гэсэн хариултыг сонгосон байна;

-Интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралдаж байсан уу гэдэгт 56 хувь нь тийм гэж хариулснаас үзвэл цахим сүлжээнд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэл нь ямар нэгэн шүүлтүүргүйгээр байршиж байдаг гэсэн дүгнэлтэд хүрэхээр байна;

-Нийгмийн сүлжээнд хувийн мэдээллээ хамгаалах тохиргоог хэрэглэдэг үү гэсэн асуулгад 60 хувь нь хэрэглэдэг гэж хариулсан байна;


-Эцэг, эхийн зүгээс интернэт хэрэглээний цаг болон агуулгад хяналт тавьдаг уу гэж асуухад заримдаа гэдгийг 55 хувь нь сонгосноос үзвэл цахим сүлжээн дэх эцэг эхийн хяналт сул байна;

-Хэн нэгэн нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ гэдэгт судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана, 41 хувь нь найз нөхдөөсөө зөвлөгөө авна гэсэн хариултыг сонгосон байна.


Үүнээс нэгтгэн дүгнэвэл 10-18 насны нийт 1129 хүүхдээс судалгаа авахад интернэтийг 2-4 цаг хүртэлх хугацаанд хэрэглэдэг, интернэтийг ихэвчлэн нийтийн сүлжээ (Фэйсбүүк, инстаграмм, твиттер, youtube, Tik tok зэрэг)-нд холбогдох, найз нөхөдийн харилцаа холбоо тогтооход хэрэглэдэг, интернэт хэрэглээний цаг болон агуулгад эцэг, эхийн хяналт сул байдаг, интернэтэд буруу зүйлд уруу татсан агуулга бүхий мэдээ, мэдээлэлтэй тааралддаг, нийгмийн сүлжээнд гутаан доромжилж ялгаварлан гадуурхвал нийт хүүхдүүдийн 59 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандахаар байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

ХОЁР. Эцэг, эх, асран хамгаалагчаас авсан судалгааны үр дүн:


1. Та хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хяналт тавьдаг уу?




2. Та цахим орчин дахь мэдээллийн шүүлт хийх тохиргооны талаар хэр мэдээлэлтэй вэ?




3. Таны хүүхэд нийгмийн сүлжээнд үе тэнгийнхний дарамт, шахалтанд өртөж байсан уу?



4. Таны хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэг үү?



5. Та нийгмийн сүлжээнд хүүхдийн хамгаалалын талаар хэр мэдээлэлтэй вэ?



6. Таньд нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн зохицуулалттай холбоотой санал байвал дор бичнэ үү. Гэсэн асуултанд судалгаанд оролцогчид бичгээр санал гаргасан байна. Үүнийг ямарваа засваргүйгээр, эрэмбэлэхгүйгээр дор дурдвал:

- хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай гэж боддог;
- эцэг эхчүүдийг цахим орчны мэдлэгийг нэмэгдүүлэх;
- тусгайлан хууль гаргаж сайтар хамгаалах нь зүйтэй байна;
- цахим орчны хэрэглээг хянах, аль болох утасны хэрэглээг багасгаж өөр зүйлд анхаарлыг хандуулах спортын ямар нэг төрлөөр хичээллүүлэх;
- Нийгмийн сүлжээнд зарим мэдээллийг хаалттай болгох, хүүхэд нэвтэрдэг учраас хориотой үг хэл ашиглахыг таслан зогсоох болон хүчирхийлэлтэй мэдээлэл түгээхгүй байх;
- Эрхзүйн зохицуулалт байх хэрэгтэй гэж боддог. Ганц хүүхэд ч биш шүү дээ. Хүүхдүүдээ цаг үргэлж хянаж чадахгүй, цаг үргэлж цахим хэрэглээг нь хязгаарлаад байж болохгүй асуудал эцэг эх бүрт бий байх. Эрхзүйн зохицуулалттай болж ухуулга хийж байж хүүхэд ч, томчууд ч өөрийгөө ч өрөөл бусдыг ч хамгаалах сэтгэл зүйтэй болох байх гэж боддог;
- Тодорхой сайт вэбүүдэд нэвтрэх боломжгүй нас заах;
- Насанд хүрээгүй хүүхдүүдийг заавал нийгмийн сүлжээнд холбож байгаа нь таалагддаггүй. Ангийн групп нээчихээд тэндээ энэ тэр зар оруулна. Багш нар бүүр шөнийн 23 24цагт ангийнхаа хүүхдүүдэд зарын чанартай мэдээлэл оруулдаг. Одоо шалгалт энэ тэр мэдээллээ цахим групптэй оруулдаг энэ мэтээр хүүхдийг цахим орчноос хол байлгах нөхцөл бүрдэхгүй байна. Зарим нь бүр цахимаар гэрийн даалгавар өгнө гээд тараадаг;

- Энэ төрлийн зохицуулалт байх нь зөв. Гол нь эрх зүйн орчин болоод технологийн шийдэл нь сайн байх хэрэгтэй;
- FB -г тодорхой насанд хүрсэн хүн хэрэглэгч болдог. Гэтэл хичээл мэдээлэл нь бүгд FB-ээр дамжиж хүрч байна. Тиймээс ямар ч арга байхгүй хэрэглэгч болсон. Тиймээс хамгаална гэдгийг хэрхэн ойлгохоо мэдэхгүй байна;
- Хүүхдийн цахим орчин дахь хэрэглээ нь эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналттай шууд холбоотой учир түүнд чиглэсэн зүйл заалт оруулж хариуцлагыг өндөржүүлэх тал дээр анхаарах;
- эрх зүйн мэдээллийн талаар мэдээлэл өгөх;
- Сургуулийн эцэг эхчүүд нийлээд гар утас, PC-ний хэрэглээ хянах төлбөртэй цогц программ худалдаж авбал зүгээр байх;
- Энэ төрлийн гэмт хэрэг гарч л байгаа байх. Сайн хуульчилж өгөх ёстой;
- Шүүлтүүртэй мэдээллийг хүргэх;
- Нийгмийн сүлжээнд байршуулж байгаа мэдээлэлд тодорхой босго тавьж, мэдээлэл байршуулж байгаа эх сурвалжийг хянадаг байх шаардлагатай байна;
- Эцэг эхчүүд өөрсдөө анхаарах;
- Цахим орчины хэрэглээг багасгах зэрэг болно.


Дээр дурдсан асуултанд хариулт өгсөн агуулгыг ерөнхийд нь дүгнэн үзвэл эцэг, эх, асран хамгаалагч нар нийгмийн сүлжээнд хүүхэд хамгаалалын эрх зүйн орчинг бүрдүүлэх, хүүхдэд хүрч байгаа мэдээлэлд хяналт тавих, шүүлт хийх, тус асуудлыг нийтэд хүрэхүйц түгээх, сурталчилах зэрэг талаар дурдсан байна.

Эцэг эхээс авсан судалгааны нэгдсэн үр дүн:

Нийт 253 эцэг, эхээс 6 төрлийн асуулга бүхий судалгаа авахад эцэг эхийн хяналт сул байдаг, хүүхдүүд нийгмийн сүлжээнд дарамт шахалтанд өртөж байгаагүй, хүүхэд цахим дарамтанд өртөж байсан тухай гэр бүлийнхэндээ хэлдэггүй, нийгмийн сүлжээнд хүүхэд хамгааллын талаар мэдлэг дунд эсхүл бага зэрэг гэсэн хариултуудыг дийлэнх нь сонгосон байгаа бөгөөд тусгайлсан хууль гаргах нь зүйтэй гэсэн саналыг дийлэнх нь гаргасан байна.

Хуулийн төслийг “D.PARLIAMENT.MN” цахим хуудсанд байршуулсан байдал:

Зураг 1: Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл



Зураг 2: Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийн хандалт



ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн сүлжээнд хүүхдийн
оролцоог зохицуулах тухай
хуулийн төслийн талаар*

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийн хамт боловсруулж, хуулийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.4-т заасны дагуу цахим хэлбэрээр явуулахаар 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “D.PARLIAMENT.MN” цахим хуудсанд байршуулж, санал авах ажлыг зохион байгууллаа.

Цахим хуудсанд хуулийн төслийг байршуулснаас хойш 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хуулийн төсөлтэй нийт 660 иргэн танилцаж, дэмжлэг ирүүлсэн байна. Тус цахим хуудсаар дамжуулан хуулийн төсөлд иргэд, олон нийтийн зүгээс тухайлан санал ирүүлээгүй боловч Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын албан ёсны цахим хуудасд дэмжиж байгааг илэрхийлсэн мэдэгдэл, сэтгэгдэлүүд ирсэн болно.

Түүнчлэн хуулийн төсөлд санал авахаар Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамтай хамтран дараах хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа. Үүнд:

1. Хүүхэд, эцэг эх асран хамгаалагч, мөн багш, нийгмийн ажилтан, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдээс нийт 11,234 оролцогчийг хамруулсан 4 бүлгийн судалгаа;
2. Олон улсын туршлага, хэм хэмжээ, нийтлэг стандарт болон гадаад орны хууль, эрх зүйн харьцуулсан судалгаа;
3. Улаанбаатар хотын 9 дүүргийн сургуулийн 13-16 насны 1100 гаруй сурагчдын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг;
4. Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 175 сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нарын төлөөлөл болох 3,000 гаруй оролцогчийг хамруулсан хэлэлцүүлэг;
5. Орон нутгийн төрийн өмчийн 542 ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нарын төлөөлөл аймаг, сумдын төв цэгүүдээс нэгдэн оролцсон хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжүүдийг тухай бүр хуулийн төсөлд тусгасан болно.

Мөн хуулийн төсөлд Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Монголын Хуульчдын Холбооноос санал авахаар тус тус хүргүүлж, ирсэн саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх саналын товъёог бэлтгэн дор оруулав.

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус хуулийн төсөлд зарчмын 20 санал, иргэд, олон нийтийн тодорхой хэмжээний дэмжлэг ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 1: Хуулийн төсөлд ирүүлсэн саналын товъёог.

Д/д	Нэр	Ирүүлсэн санал	Хуулийн төсөлд тусгасан эсэх
1	Монголын Хуульчдын холбоо 2026.06.16-ны өдрийн 1/463 тоот албан бичгээр	Төслийн 1.1 дэх хэсгийн найруулгыг засах, тухайлбал “зохицуулах” үгийг давтаж хэрэглэсэн байна.	Хуулийн төслийн үндсэн агуулга нийгмийн сүлжээн дэх хүүхдийн оролцоог зохицуулах гэж байгаа тул саналыг хүлээж авах шаардлагагүй гэж үзэв.
2		Төслийн 5.1.4-т “хуульд заасан бусад нөхцөлүүд” гэсэн нь ямар хуулийн ямар нөхцөл болох нь тодорхойгүй бөгөөд “нөхцөлүүд” гэж олон тооны дагавар хэрэглэсэн нь хууль тогтоомжийн эх бичвэрт тавигдах шаардлагад нийцээгүй байна.	Саналыг хүлээн авч, холбогдох засварыг доорх байдлаар оруулав. 11.1.1.харилцаа холбооны сүлжээний дугаарыг 16-аас доош насны хүүхдэд түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт баталгаажуулан олгох;
3		Төслийн 5.3.2-т “хэрэглэгчийн нас баталгаажуулахад иргэний үнэмлэх эсхүл бусад баримт ашиглах сонголттой байх,” гэсэн нь “бусад баримт” гэдэг нь хэт ерөнхий, ямар баримт бичгийг зөвшөөрөх нь тодорхойгүй тул субъектив тайлбар хийх боломж олгож байна.	Саналыг хүлээн авч, холбогдох засварыг доорх байдлаар оруулав. 11.1.1.харилцаа холбооны сүлжээний дугаарыг 16-аас доош насны хүүхдэд түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт баталгаажуулан олгох;
4		Төслийн 5.4-т “Насны хязгаартай нийгмийн сүлжээ эрхлэгч нь хэрэглэгчийг танин мэдэх зорилгоор	Саналыг хүлээн авч, хуулийн төслийн холбогдох заалтад

		холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллаж болно.” гэж заасан нь “холбогдох байгууллага, албан тушаалтан” гэж хэнийг ойлгох нь тодорхойгүй, мөн “хамтран ажиллаж болно” гэсэн нь заавал биелүүлэх шинжгүй, үзэмжээр шийдэх боломж олгосон.	хамтран ажиллана гэж тусгав.
5		Төслийн 8.2-т “Энэ хуулийг зөрчсөн Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулахаас өмнө мэдэгдэл хүргүүлнэ.” гэж заасан нь мэдэгдлийг хэдий хугацааны өмнө хүргүүлэх, үйлчилгээ эрхлэгч хариу тайлбар, арга хэмжээ авах хугацаа тодорхой заагаагүй нь үйлчилгээ эрхлэгчийн болон хэрэглэгчийн эрхийн зөрчил үүсгэхээр байна.	Саналыг хүлээн авч, мэдэгдэл хүргүүлэх хугацааг нэн даруй байхаар тодорхойлон, уг хэсэгт тусгав.
6		Төслийн 9.1-т “Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг зөрчиж байгаа талаарх ирүүлсэн гомдол, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна.” гэж заасан нь төрийн албан тушаалтан /нийгмийн ажилтан, хууль сахиулагч/ болон хувийн хэвшлийн этгээдийг /нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч/ нэг заалтад хамтатган, гомдол шалгах чиг үүргийг тодорхойгүй хуваарилсан, хэн нь ямар арга хэмжээ авах нь мөн адил тодорхойгүй байна. Иймээс төрийн байгууллага болон хувийн хэвшлийн хүлээх үүрэг, гомдол хүлээн авч шийдвэрлэх харьяаллыг зааглан тусдаа заалт болгон оруулах.	Саналын дагуу гомдол, мэдээлэл хүлээн авах этгээдийг төрийн төлөөлөл болон энэ хуулинд заасан бусад этгээд байхаар тус хэсгийг найруулан, оруулав.
7		Төслийн 9.2-т “Энэ зүйлд заасан гомдол, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай	Хуулийн төслийг хэрэгжүүлэхээр тусгайлан аливаа нэгж,

	тусламжийн утас, цахим шуудан ажиллуулж болно.” гэж заасан ба “ажиллуулж болно” гэсэн үзэмжээр шийдвэрлэх хэллэг хэрэглэсэн нь яаралтай тусламжийн сувгийг ажиллуулахгүй байх боломж олгож хуулийн хийдэл үүсгэсэн байна. Тухайлбал, санхүүжилт байхгүй гэх шалтгаанаар яаралтай тусламжийн утсыг ажиллуулахгүй байснаас хуулийн үндсэн зорилго биелэхгүй буюу хүүхэд цахим дарамтад өртсөн тухайгаа цаг алдалгүй мэдээлж чадахгүй хохирох эрсдэлтэй.	байгууллага, зохион байгуулалтын бүтэц, систем зэргийг заавал шинээр үүсгэхийг шаардахгүй, төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг баримтлан тус саналыг хүлээж авах шаардлагагүй гэж үзэв.
8	Төслийн 5.3.3-т нас баталгаажуулах зорилгоор ашигласан мэдээллийг “нэн даруй устгах” хуулийн үүрэг хүлээлгэсэн байна. Гэвч хэрэв тухайн сошиал платформ нь Зөрчлийн тухай хуулийн нэмэлтээр хүүхдэд бүртгэл үүсгэсэн гэж буруутгагдан шалгагдвал өөрийгөө буруугүй гэдгийг нотлох /тухайн хэрэглэгч хуурамч иргэний үнэмлэх ашигласан эсэх, эсвэл систем хэрхэн шалгасныг баримтжуулах/ нотлох баримтгүй болох эрсдэлтэй. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад хуулиар мэдээлэл цуглуулах, хадгалах доод болон дээд хугацааг нарийвчлан зохицуулдаг бөгөөд “нэн даруй устгах” нь эргээд хуулийн хэрэгжилтийг хянахад саад учруулж болзошгүй. Түүнчлэн мэдээллийг устгасан эсэхэд тавих хяналт тодорхойгүй байгаа нь хувь хүний мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл учруулахаар байна.	Саналыг хүлээн авч, тус заалтад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулахаар тусгав.
9	Төслийн 6.1-д аливаа этгээд “Насны хязгаартай нийгмийн сүлжээнд 16 нас хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэх боломж олгохгүй байх, эсхүл өөрийн бүртгэлтэй хаягийг ашиглуулахгүй байх үүрэгтэй.” гэж	Уг асуудал нь хуулийн төслийн 17 дугаар зүйлд зааснаар Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэгт багтсан байна.

	заасан боловч энэхүү үүргийн биелэлтэд тогтмол хяналт тавих эрх бүхий этгээд тодорхойгүй, зөвхөн гомдол, мэдээллийн мөрөөр арга хэмжээ авахаар тусгасан нь хууль хүн бүрт тэгш үйлчлэх зарчимтай нийцэхгүй байна.	
10	Төслийн 8.1.5-д “Энэ хуулийг зөрчсөн тухай ирүүлсэн гомдол, мэдээллийг үндэслэн энэ хуульд заасан арга хэмжээ аваагүй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж заасан нь зөвхөн дотоодын энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгчид хамаарах боломжтой ба гомдол, мэдээллийн мөрөөр тэдэнд авах нийгмийн сүлжээний хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ нь учруулсан хор хохиролтой хэрхэн уялдах нь тодорхойгүй байна. Мөн хуулийн төсөлд гадаад улсад үйл ажиллагаа явуулдаг, үндэстэн дамнасан /Facebook, YouTube, TikTok гэх мэт/ нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн асуудал тусгагдаагүй нь хууль тэгш үйлчлэхгүй байх эрсдэл үүсгэж байна. Учир нь Монгол Улсын хууль тогтоомжоор гадаадад байршилтай, Монголд албан ёсны төлөөлөгчийн газаргүй хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулиар шууд торгууль ногдуулах, түүнийгээ биелүүлж хураан авах эрх зүйн болон практик боломж бага. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн “шийтгэл гарцаагүй байх”, “хэрэгжихүйц байх” зарчимтай зөрчилдөхөөс гадна үндэсний үйлчилгээ үзүүлэгчдээ ялгаварлан гадуурхах, хясан боох хэрэгсэл болох эрсдэлтэй юм.	Саналыг хүлээн авч, хуулийн төсөлд 10.1.8.нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үүргийн хэрэгжилтийг хангахад шуурхай дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах суурин төлөөлөгч, төлөөлөх байгууллага эсхүл албан ёсны харилцах нэгж томилж, Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх; 10.1.9.хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой гомдол, мэдээлэл, эрсдэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор эрх бүхий байгууллагатай шууд харилцах суваг нээх; гэсэн заалтуудыг нэмж оруулав.

11		Энэ хуулийг зөрчсөн нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээ авах эрхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд шууд олгосон байна. Энэ нь бусад суурь хуулиудаар хүний эрх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарлах, хаах зэрэг эцсийн шийдвэрийг хараат бус шүүхийн байгууллага, эсхүл прокурорын хяналт дор хэрэгжүүлдэг бол энэ төслөөр зохицуулах хороонд хэт өргөн хэмжээний, шүүхийн бус журмаар хандалт хаах эрх мэдэл олгосон нь захиргааны байгууллагын эрх мэдлийн зааг ялгаа, бусад салбарын хуулийн процесстой зөрчилдөх эрсдэлтэй байна.	Саналыг хүлээн авч, хуулийн төсөлд тусгав.
12	Монгол Улсын Дээд шүүх 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 05/2457 тоот албан бичгээр	Хуулийн төслийг Улсын Дээд Шүүхийн Нийт Шүүгчийн 2026 оны 06 сарын 22-ны өдөр хэлэлцүүлсэн тухай.	Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй гэж үзэв.
13	Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 2/2535 тоот албан бичгээр	Тусгайлан өгөх саналгүй.	Тусгайлан өгөх саналгүй. Дэмжсэн санал.
14	Монгол Улсын Засгийн газар	Санал ирүүлээгүй.	

	Улсын Их Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн УИХ-03/4691 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
15	Монголын Өмгөөлөгчдийн нхолбоо 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 04/34 тоот албан бичгээр	Хуулийн төслийн 4.1.1 болон 5.2-т “16 нас хүрээгүй хүүхдэд нийгмийн сүлжээнд бүртгэл үүсгэхийг хориглоно” гэж тусгасан нь хүүхдийн мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, цахим орчинд оролцох эрхийг бүхэлд нь хязгаарласан шинжтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйл, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 13 дугаар зүйлд хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэйг баталгаажуулсан байдаг. Иймд бүх төрлийн нийгмийн сүлжээнд насны хатуу хориг тогтоохоос илүү эцэг эхийн хяналт, хүүхэд хамгааллын тохиргоо, насанд тохирсон хэрэглээний зохицуулалт бүхий ялгамжтай механизм тусгах шаардлагатай байна.	Тус санал хуулийн төсөлд туссан болно.
16		Хуулийн төслийн 5.3.1, 5.3.2-т хэрэглэгчийн насыг иргэний үнэмлэх болон бусад баримтаар баталгаажуулах талаар тусгасан бөгөөд энэ нь хүүхэд болон иргэдийн хувийн мэдээлэл алдагдах, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналтгүй боловсруулалт хийх эрсдэл үүсгэж болзошгүй байна. Түүнчлэн олон улсын нийгмийн сүлжээний платформууд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу техникийн интеграц хийх бодит боломж хязгаарлагдмал байх эрсдэлтэй байна. Нас баталгаажуулах	Саналыг хүлээн авч дараах байдлаар тусгав. 11.1.1.харилцаа холбооны сүлжээний дугаарыг 16-аас доош насны хүүхдэд түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт баталгаажуулан олгох;

		ажиллагааны технологийн стандарт, мэдээлэл хамгаалах баталгаа, хяналтын механизмыг илүү тодорхой зохицуулах шаардлагатай байна.	
17		Хуулийн төслийн 5.1-д “насны хязгаартай нийгмийн сүлжээ”-ний ойлголтыг тодорхойлсон боловч “хуульд заасан бусад нөхцөлүүд” гэж нээлттэй байдлаар тусгасан нь хуулийн тодорхой байх зарчимд нийцэхгүй байна. Ямар платформ уг хуульд хамаарахыг захиргааны байгууллагын өргөн хүрээний тайлбараар шийдэх боломж үүсэж болзошгүй тул шалгуур, нөхцөлийг хуульд илүү тодорхой тусгах шаардлагатай байна.	Саналыг хүлээн авч, холбогдох хэсэгт засвар оруулав.
18		Хуулийн төслийн 7.1.3, 8.1.5-д төрийн байгууллага нийгмийн сүлжээний жагсаалт батлах, хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах арга хэмжээ авах талаар тусгасан боловч ямар үндэслэл, хугацаа, журмаар хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Энэ нь мэдээллийн эрх чөлөө, интернэтийн чөлөөт орчинд хэт өргөн хүрээний хязгаарлалт тогтоох эрсдэлтэй бөгөөд шүүхийн хяналтгүйгээр хэрэгжвэл Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрхэд халдах нөхцөл үүсэж болзошгүй байна.	Саналыг хүлээн авав. Уг асуудлаар хуулийн төслийн 7 дугаар зүйлд тусгав.
19		Хуулийн төслийн 6.1-д “өөрийн бүртгэлтэй хаягийг ашиглуулахыг хориглоно” гэж тусгасан боловч уг үйлдлийг хэрхэн тогтоох, ямар этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Практикт хүүхэд эцэг эхийн гар утас, бүртгэл ашиглах тохиолдол түгээмэл байдаг тул хэрэгжилтийн бодит боломж, хяналтын механизмыг нарийвчлан боловсруулах шаардлагатай байна.	Уг асуудал нь хуулийн төслийн 17 дугаар зүйлд зааснаар Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүрэгт багтсан байна.

20	Хуулийн төслийн 8.1.5-д “хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээ” гэх ойлголтыг хэрэглэсэн боловч энэ нь техник, эрх зүйн хувьд тодорхойгүй байна. Интернет платформын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох асуудал нь Харилцаа холбооны тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон олон улсын интернэтийн зохицуулалттай уялдах шаардлагатай тул ямар арга хэмжээг ямар байгууллага, ямар үндэслэлээр хэрэгжүүлэхийг тодорхой болгох шаардлагатай байна.	Хуулийн үйлчлэх хүрээнд Кибер аюулгүй байдлын тухай хууль багтаж байгаа тул уг санал туссан гэж үзэв.
----	---	--

---oOo---

НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН САНАЛЫН
ТОВЬЁОГ

1. Нэгтгэсэн дүн /Засгийн газрын гишүүд болон бусад байгууллагаас ирсэн саналыг хуулийн төсөлд тусгасан байдал/

Төлөв	Тоо	Тайлбар
ТУСГАСАН	45	Саналыг хуулийн төсөлд бүрэн тусгасан.
АГУУЛГААР ТУСГАСАН	1	Үгчлэн тусгаагүй боловч өөр хэлбэрээр тусгасан.
ХЭСЭГЧЛЭН ТУСГАСАН	4	Саналын зарим хэсэг орсон, үлдсэн нь журам/дагалдах хууль/дараагийн редакц шаардсан.
ТУСГААГУЙ	16	Тодорхой үндэслэлээр хуулийн төсөлд тусгагдаагүй.
ДЭМЖСЭН	6	Хуулийн төслийг дэмжсэн

2. Санал тусгасан байдал

№	Албан бичгийн огноо, дугаар	Саналын утга	Төлөв	Хуулийн тусгасан байдал	Үндэслэл	Шийдвэрлэх
1.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 2026.06.23 01/2046	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "нийгмийн сүлжээ" гэж хэрэглэгч бүртгэл үүсгэн оролцох, өөрийн болон бусдын үүсгэсэн зураг, дүрс бичлэг, дуу, бичвэр зэрэг агуулгыг нийтлэх, түгээх, сэтгэгдэл бичих, хуваалцах, бүлэг үүсгэх, харилцах боломж олгодог цахим хэрэглүүр /аппликэйшн/, цахим хуудас болон түүнтэй адилтгах үйлчилгээг;" ойлгохоор, 4.1.4-т "нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч" гэж энэ хуулийн 4.1.3-т заасан үйлчилгээг нийтэд санал болгож буй этгээдийг;" ойлгохоор тус тус заажээ.Эдгээр тодорхойлолтоос харахад нийгмийн сүлжээ гэдэг нь Facebook, Instagram, Tiktok гэх зэрэг платформуудыг ойлгохоор харагдаж байгаа бөгөөд нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч гэдэг нь тухайн үйлчилгээг нийтэд санал болгож буй этгээдийг ойлгохоор байна. Хэдийгээр хуулийн төслийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон боловч нийгмийн сүлжээг хүрээгээр хязгаарлах боломжгүй, үйлчилгээ үзүүлэгч нар нь үйлчилгээг санал болгохдоо зөвхөн Монгол Улс биш дэлхий даяар тухайн үйлчилгээг авах боломжтой байдлаар санал болгодог гэдгийг анхаарах нь зүйтэй. Хуулийн төслийн 10 дугаар зүйлд нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийн талаарх зохицуулалт нь хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй, бодитой хэрэгжих боломжгүй, хэлбэрийн шинжтэй зохицуулалт байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т "тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх", 29.1.3-т "тухайн хуулиар	АГУУЛГААР ТУСГАСАН	Хуулийн төсөлд тусгасан байдал 4.1.3."нийгмийн сүлжээ" гэж хэрэглэгч бүртгэл үүсгэн оролцох, өөрийн болон бусдын үүсгэсэн зураг, дүрс бичлэг, дуу, бичвэр зэрэг агуулгыг нийтлэх, түгээх, сэтгэгдэл бичих, хуваалцах, бүлэг үүсгэх, харилцах боломж олгодог цахим хэрэглүүр /аппликэйшн/, цахим хуудас болон түүнтэй адилтгах үйлчилгээг; 4.1.4."нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч" гэж энэ хуулийн 4.1.3-т заасан үйлчилгээг нийтэд санал болгож буй этгээдийг	Саналын дагуу өөрчлөн найруулсан.	
2.		Хуулийн төслийн 10 дугаар зүйлд нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийн талаарх зохицуулалт нь хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй, бодитой хэрэгжих боломжгүй, хэлбэрийн шинжтэй зохицуулалт байна.	ТУСГААГУЙ		Өнөөгийн байдлаар нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хэрэгжүүлэх боломжтой зохицуулалт тул хуулийн төслийн 10 дугаар зүйлийн зохицуулалт хэрэгжих боломжтой.	
3.		Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т "тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх", 29.1.3-т "тухайн хуулиар	ТУСГАСАН			

		зохицуулах нийгмийн харилцааны хүрээнд халсан асуудлыг тусгахгүй байх" гэж тус тус заасны дагуу хуулийн төслийн агуулгад анхаарах нь зүйтэй байна.					
4.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 2026.06.19 01/2215	Тусгайлан өгөх саналгүй.	ДЭМЖСЭН				
5.	Боловсролын сайд 2026.06.23 01/3858	Тусгайлан өгөх саналгүй.	ДЭМЖСЭН				
6.	Монгол Улсын Ерөнхий прокурорын газар 2026.06.22 Ц-2/1164	Тусгайлан өгөх саналгүй.	ДЭМЖСЭН				
7.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 2026.06.19 01/2161	Хуулийн төслийн "4.1.9. 'насны баталгаажуулалтын токен' гэж хэрэглэгчийн иргэний бүртгэлийн болон хувийн мэдээллийг нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид илчлэхгүйгээр, зөвхөн насны босго хангаж буйг батлах цахим код, технологийн шийдлийг." гэсэн шинэ заалт нэмэх	ТУСГААГУЙ		Хүний хувийн мэдээллийг хамгаалах үүднээс хуулийн төсөлд насны баталгаажуулалт хийхэд токен ашиглахгүй байхаар тусгасан.		
8.		Хуулийн төслийн "6.2. Нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч нь 13 насанд хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэх, үйлчилгээ авах боломж олгохыг хориглоно. Эцэг эх, асран хамгаалагч нь 13 насанд хүрээгүй хүүхдийг нийгмийн сүлжээнд бүртгүүлэхээс урьдчилан сэргийлнэ." гэж өөрчлөн найруулах.	ТУСГАСАН	8.2.3.эцэг эх, асран хамгаалагч нь 13 насанд хүрээгүй хүүхдийг нийгмийн сүлжээнд бүртгүүлэхээс урьдчилан сэргийлнэ.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж хуулийн төсөлд тусгасан		
9.		Хуулийн төслийн 10.1.4. Эрх бүхий байгууллагын мэдэгдэлд үндэслэн хүүхдийн амь нас, эрүүл мэнд, бэлгийн халдлагатай холбоотой хоригтой агуулгыг нэн даруй (6 цагийн дотор), бусад хүүхдэд хортой агуулгыг 24 цагийн дотор хаах, устгах технологийн арга хэмжээ авах гэж өөрчлөн найруулах	ТУСГАСАН	10.1.4.нийгмийн сүлжээнд нийтэлсэн, түгээсэн, сурталчилсан хоригтой агуулгыг ажлын 6 цагт багтаан устгах; 10.1.5.эрх бүхий байгууллагын мэдэгдэлд үндэслэн хүүхдэд хортой агуулгад 24 цагийн дотор хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авах;	Саналыг үндэслэлтэй гэж үзэж хуулийн төслийг өөрчлөн найруулсан.		
10.		Хуулийн төслийн "11.1.7. Насны баталгаажуулалт хийх үйл явцад хүүхдийн болон эцэг эхийн регистрийн дугаар, иргэний бүртгэлийн нарийвчилсан өгөгдлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаш дамжуулах, нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн баазад хадгалуулахыг хориглоно." (Үндэслэл: Хүүхдийн хувийн мэдээлэл алдагдахаас сэргийлнэ) гэсэн шинэ заалт нэмэх	ТУСГААГУЙ	11.1.3. насны баталгаажуулалт хийх зорилгоор ашигласан мэдээллийн нууцлалыг хангахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баримтлах;	Хуулийн төслийн 11.1.3-т уг зохицуулалт тусгагдсан болно.		

11.	Хуулийн төслийн "10.2.5. Монгол Улсаас бүртгэлтэй хүүхдийн хэрэглээнд контент санал болгох, донтуулах шинж чанартай алгоритмын ажиллагааг идэвхгүй болгох уян хатан тохиргоог (opt-out) хэрэглэгч болон эцэг эхэд олгох үүрэгтэй." (Үндэслэл: Хүүхдийг цахим сүлжээний донтолтоос сэргийлэх олон улсын жишиг заалт) гэсэн шинэ заалт нэмэх Хууль нь зөвхөн "хориглох, хязгаарлах" биш, эерэг контентыг дэмжих заалттай байх хэрэгтэй.	Хуулийн төслийн 6.3.3 ба 6.3.5 заалтууд давхардсан байна: * 6.3.3 дээр "хориотой, хүүхдэд хортой агуулгын харагдац, түгээлт... гомдол гаргах технологийн боломжийг бүрдүүлэх" гэсэн мөртлөө 6.3.5 дээр "хориотой, хүүхдэд хортой агуулгын мэдээлэх, гомдол гаргах, хаах технологийн боломжийг бүрдүүлэх" гэж бараг ижил утгаар давтан заажээ. Үүнийг нэгтгэж, нэгийг нь хасах шаардлагатай.	Хуулийн төслийн 6.3.3-д хүүхдэд аливаа агуулга санал болгох алгоритмыг хязгаарлах зохицуулалт тусгагдсан бол 6.3.5-д тухайн нийтийн сүлжээний гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх зохицуулалт тусгагдсан болно.	Хуулийн төслийн 6.3.3-т уг зохицуулалт тусгагдсан болно.	
12.	Хуулийн төслийн "13.1.5. Нийгмийн сүлжээнд хүүхдийн хөгжил, танин мэдэхүй, үндэсний өв соёл, цахим боловсролыг дэмжсэн үндэсний контент бүтээх үйл ажиллагааг бодлогоор дэмжих, урамшуулах журмыг баталж хэрэгжүүлэх." гэсэн шинэ заалт нэмэх	Хуулийн төслийн "13.1.5. Нийгмийн сүлжээнд хүүхдийн хөгжил, танин мэдэхүй, үндэсний өв соёл, цахим боловсролыг дэмжсэн үндэсний контент бүтээх үйл ажиллагааг бодлогоор дэмжих, урамшуулах журмыг баталж хэрэгжүүлэх." гэсэн шинэ заалт нэмэх	Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.1.1 дэх заалт, Соёлын тухай хуулийн 32.8 дахь хэсэгт заасан зохицуулалтад хамаарах тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1-д заасан шаардлагын дагуу хуулийн зөрчил, давхардал үүсэх тул саналыг тусгаггүй.	Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13.1.1 дэх заалт, Соёлын тухай хуулийн 32.8 дахь хэсэгт заасан зохицуулалтад хамаарах тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1-д заасан шаардлагын дагуу хуулийн зөрчил, давхардал үүсэх тул саналыг тусгаггүй.	
13.	Хуулийн төслийн 6.3.3 ба 6.3.5 заалтууд давхардсан байна: * 6.3.3 дээр "хориотой, хүүхдэд хортой агуулгын харагдац, түгээлт... гомдол гаргах технологийн боломжийг бүрдүүлэх" гэсэн мөртлөө 6.3.5 дээр "хориотой, хүүхдэд хортой агуулгын мэдээлэх, гомдол гаргах, хаах технологийн боломжийг бүрдүүлэх" гэж бараг ижил утгаар давтан заажээ. Үүнийг нэгтгэж, нэгийг нь хасах шаардлагатай.	Хуулийн төслийн 6.3.3 ба 6.3.5 заалтууд давхардсан байна: * 6.3.3 дээр "хориотой, хүүхдэд хортой агуулгын харагдац, түгээлт... гомдол гаргах технологийн боломжийг бүрдүүлэх" гэсэн мөртлөө 6.3.5 дээр "хориотой, хүүхдэд хортой агуулгын мэдээлэх, гомдол гаргах, хаах технологийн боломжийг бүрдүүлэх" гэж бараг ижил утгаар давтан заажээ. Үүнийг нэгтгэж, нэгийг нь хасах шаардлагатай.	Хуулийн төслийн 6.3.3-д хүүхдэд аливаа агуулга санал болгох алгоритмыг хязгаарлах зохицуулалт тусгагдсан бол 6.3.5-д тухайн нийтийн сүлжээний гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх зохицуулалт тусгагдсан болно.	Хуулийн төслийн 6.3.3-д хүүхдэд аливаа агуулга санал болгох алгоритмыг хязгаарлах зохицуулалт тусгагдсан болно.	
14.	Хуулийн төслийн 11.1.3-аас шууд 11.1.5 руу үсэрсэн байна: * Төслийн текстэд 11.1.4 гэсэн заалтын дугаар алгассан алдааг засах.	Хуулийн төслийн 11.1.3-аас шууд 11.1.5 руу үсэрсэн байна: * Төслийн текстэд 11.1.4 гэсэн заалтын дугаар алгассан алдааг засах.	Дугаарлалтыг зассан.	Дугаарлалтыг зассан.	
15.	Хуулийн төслийн 14.1.2. сургалтын хөтөлбөрт нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах, цахим орчны соёлтой хэрэглээний соёл төлөвшүүлэх агуулгыг үе шаттайгаар тусгах," гэж өөрчлөн найруулах	Хуулийн төслийн 14.1.2. сургалтын хөтөлбөрт нийгмийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах, цахим орчны соёлтой хэрэглээний соёл төлөвшүүлэх агуулгыг үе шаттайгаар тусгах," гэж өөрчлөн найруулах	14.1.2.цахим ур чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн сүлжээний аюулгүй байдлыг хангах, цахим орчны хэрэглээний соёлыг төлөвшүүлэх агуулгыг сургалтын хөтөлбөрт үе шаттайгаар тусгах.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж хуулийн төсөлд тусгасан.	
16.	Хууль зүй, дотоод хэргийн сайд 2026.06.19 01/3353	Хуулийн төслөөр тогтоож буй аливаа хязгаарлалтыг Хүүхдийн эрхийн тухай конвенцын 13 дугаар зүйлийн 1-д "Хүүхдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, хэвлэмэл буюу урлагийн бүтээлийн хэлбэрээр, хүүхдийн сонгосон мэдээллийн бусад арга хэрэгслээр эрх, өлж авах, дамжуулах эрх чөлөөг багтаана" гэж. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хорооны Хүүхдийн эрх ба цахим орчинтой холбоотой 2021 оны 25 дугаар ерөнхий тайлбарт "хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд өөрийн хүссэн мэдээллийн хэрэгслээр бүх төрлийн мэдээлэл, ойлголтыг хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтааг. Иймд цахим орчинд хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй	Хуулийн төслөөр тогтоож буй аливаа хязгаарлалтыг Хүүхдийн эрхийн тухай конвенцын 13 дугаар зүйлийн 1-д "Хүүхдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, хэвлэмэл буюу урлагийн бүтээлийн хэлбэрээр, хүүхдийн сонгосон мэдээллийн бусад арга хэрэгслээр эрх, өлж авах, дамжуулах эрх чөлөөг багтаана" гэж. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хорооны Хүүхдийн эрх ба цахим орчинтой холбоотой 2021 оны 25 дугаар ерөнхий тайлбарт "хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд өөрийн хүссэн мэдээллийн хэрэгслээр бүх төрлийн мэдээлэл, ойлголтыг хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтааг. Иймд цахим орчинд хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй	Хууль зүй, дотоод хэргийн сайд 2026.06.19 01/3353	

	интерийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарласан аливаа хязгаарлалт нь хуулиар тогтоосон, зайлшгүй, тохиромжтой байх" гэж тус тус заасантай нийцүүлэхэд анхаарах;					
17.	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д "харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч" гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 9.4-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийг ойлгох"-оор тусгажээ. Гэтэл Зөвшөөрлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйл нь зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон томдол гаргах асуудлыг зохицуулсан байх тул хуулийн төслийн 4.1.5-д заасныг тодруулж, дахин нягтлах;	ТУСГАСАН	4.1.5 "харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч" гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр заасан зүйлийн 9.4-т зөвшөөрөл бүхий этгээдийг;			
18.	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т тусгасан "эрсдэлд суурилсан байх" зарчмын агуулга тодорхойгүй байх тул тодорхой болгох;	ТУСГАСАН	5.1.3.эрсдэлээс сэргийлсэн байх;			
19	Хуулийн төслийн 6 дугаар зүйлд технологийн хамгаалалтын арга хэмжээний талаарх зохицуулалтыг тусгажээ. Ингэхдээ урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг ямар субьект хэрэгжүүлэх нь тодорхойгүй байх тул энэ талаар тодорхой тусгах;	ТУСГАСАН	Хуулийн төслийн 10.1.2, 10.1.7-д тусгасан.			
20.	Хуулийн төслийн зарим зохицуулалтыг хэрхэн, ямар субьект хэрэгжүүлэх нь тодорхойгүй, нарийвчилсан процесс байхгүй байх тул энэ талаар хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна. Тухайлбал, хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т заасан "танихгүй хэрэглэгчтэй харилцаа тогтоох, шууд дамжуулалт хийх боломжийг хязгаарлах", 9 дүгээр зүйлийн 9.2.5-д заасан "сургуулийн орчинд зохицуулалттай нийгмийн сүлжээ ашиглахыг хязгаарлах" арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, мөн тус арга хэмжээ техник, технологийн хувьд хэрэгжих боломжтой эсэхийг дахин нягталж, процессыг нарийвчлан тусгах;	ТУСГАСАН	Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т заасан зохицуулалтыг нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хэрэгжүүлэх талаар хуулийн төслийн 10.1.7-д, мөн хуулийн төслийн "9.2.5.сургуулийн орчинд нийгмийн сүлжээ ашиглахыг хязгаарлах," зохицуулалтыг боловсролын сургалтын байгууллага хэрэгжүүлэхээр тус тус тусгасан.			
21.	Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон бусад салбарын мэргэжилтний нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн, цахим хөгжил, харилцаа холбооны, боловсролын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Застийн газрын гишүүд хамтран батална" гэж тусгажээ. Дээрх асуудал нь Монгол Улсын Застийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 10-т заасан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй байх тул хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2-т "хууль зүйн асуудал эрхэлсэн Застийн газрын гишүүн" гэснийг хасах;	ТУСГАСАН	Хуулийн төслөөс уг зохицуулалтыг хасав.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж хуулийн төслөөс хассан.		
22.	Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т Харилцаа холбооны зохицуулах хөрөө нь "...	ХЭСЭГЧЛЭН ТУСГАСАН		Харилцаа холбооны тухай хуульд Харилцаа холбооны зохицуулах	АХ-ээр Энэ нэр томъёог дөрвөх	

	үүргээ биелүүлээгүй тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх"-ээр тусгажээ. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхтэй дээрх зохицуулалт нийцэхгүй байх тул "технологийн арга хэмжээ авах" гэдэгт ямар арга хэмжээг ойлгох, тус арга хэмжээг Зохицуулах хороо хэрэгжүүлэх бүрэн эрхтэй эсэхийг дахин нягтлах;			хорооны нийтлэг бүрэн эрхийг тогтоосон бөгөөд тодорхой салбарын харилцааг зохицуулсан тусгай хуулиар уг байгууллагад нэмэлт чиг үүрэг, бүрэн эрхийг хуульчлан олгохыг эрх зүйн хувьд үгүйсгэхгүй гэж үзэж байна. Тухайлбал, бүх шатны сонгуулийн тухай хуулиудаар Харилцаа холбооны зохицуулах хороонд Харилцаа холбооны тухай хуульд тусгайлан заагаагүй нэмэлт чиг үүргийг хуульчилсан байдаг. Иймд хуулийн төслөөр хүүхдийн нийгмийн сүлжээн дэх аюулгүй байдлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн тодорхой технологийн арга хэмжээ хэрэгжүүлэх чиг үүргийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хуулиар олгох боломжтой гэж үзсэн.	байрлал, томъёолох шаардлагатай эсэхийг шийдвэрлэх "технологийн арга хэмжээ" гэдэгт эрх бүхий байгууллагын шийдвэрийн хангах зорилгоор цахим сүлжээ, зорилгоор холбооны үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан тодорхой мэдээллийн нөөцөд хандах эрхийг хязгаарлах, домэйн нэр, IP хааг, URL түвшинд техникийн зохицуулалт хийх, хуульд заасан бусад техникийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг ойлгоно.
23.	Хуулийн төслийн 18 дугаар зүйлд нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдал зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг гаргах талаар тусгажээ. Ингэхдээ тус гомдол, мэдээллийг хэрхэн, ямар журмаар хүлээн авах, түүнийг шийдвэрлэх процесс нь тодорхойгүй байх тул гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шилжүүлэх процессыг нарийвчлан тусгаж, тодорхой хугацаа тогтоох;	ТУСГАСАН	Хуулийн төслийн 18.1-18.3-ыг саналын дагуу өөрчлөн найруулсан.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд найруулга хийсэн.	
24.	Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасныг "Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэж өөрчлөн найруулах;	ТУСГАСАН	19.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд найруулга хийсэн.	
25.	Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт болох эрх олгосон зохицуулалтыг тусгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 271 дүгээр зүйлд заасантай нийцүүлэх;	ТУСГАСАН	Хуулийн төслөөс уг зохицуулалт хасагдсан.		
26.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 271.3-т заасны дагуу захиргааны хэм хэмжээний акт гаргах хугацааг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тусгах;	ТУСГАСАН	Хуулийн төслөөс уг зохицуулалт хасагдсан.		
27.	Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт болох эрх олгосон зохицуулалтыг дахин нягтлах, Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр тогтоол, Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолд тус тус заасны дагуу захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж буй харилцааг хуульд тусгах арга хэмжээ авах;	ТУСГАСАН	Хуулийн төслөөс уг зохицуулалт хасагдсан.		Агуулгыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дагалдуулж оруулах эсэхийг

28.	Хуулийн төслийн үзэл баримтлалд, хуулийн төсөлтэй холбогдуулан Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулахаар тусгасан боловч хуулийн төслийг дагалдуулан эдгээр хуулийн төслийг боловсруулан ирүүлээгүй байгааг анхаарах;	ХЭСЭГЧЛЭН ТУСГАСАН			шийдвэрлэсний дараа тайлбар бичих
29.	Хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ. Хуулийн төсөлд шинээр нэмэхээр тусгасан зарим зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг хэт өндөр тогтоосон байгааг анхаарч, тухайн зөрчлийн нийгмийн хор аюулын шинжийг харгалзан, Зөрчлийн тухай хуульд заасан бусад ижил төрлийн зөрчилд оногдуулж байгаа торгох шийтгэлийн хэмжээтэй уялдуулах шаардлагатай байна. Тухайлбал, хуулийн төсөлд тусгасан харилцаа холбооны сүлжээний дугаарыг 16-аас доош насны хүүхдэд түүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар болон эцэг, эх, асран хамгаалагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаарын хамт баталгаажуулан олгох үүргээ биелүүлээгүй зөрчилд хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар тусгажээ. Түүнчлэн, хуулийн төсөлд нэг зөрчилд "хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох"-оор тусгасныг засаж, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу уялдуулж, өөрчлөх;	ТУСГАСАН	Хуулийн төслийн 2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 16 дахь хэсгийг хасаж, дараах агуулга бүхий зүйлийг нэмсэн. 2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын "хэрэглэгчийг иргэний бүртгэлийн дугаараар бүртгээгүй" гэснийг "хэрэглэгчийг хуульд заасан шаардлагын дагуу иргэний бүртгэлийн дугаараар бүртгээгүй" гэж өөрчилсүгэй."	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд найруулга хийсэн.	
30.	Зөрчлийн тухай хуулийн төсөлд тусгасан зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг тодорхой болгох. Тухайлбал, 13-16 насны хүүхдийн нийгмийн сүлжээний хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй" гэж тусгасны "урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээ" гэдэгт ямар арга хэмжээг хамааруулахыг хуулийн төсөлд нарийвчлан тодорхойлсныг үндсэн дээр зөрчлийн бүрэлдэхүүн болгон оруулах;	ТУСГАСАН	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Хоёрдугаар зүйлд дараах агуулгыг тусгасан. 15.Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.3 дахь хэсэгт заасан 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлээгүй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд найруулга хийсэн.	

				нэгжтэй хэмжээний торгоно.	тэнцэх төгрөгөөр		
31.		Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1-д заасны дагуу хуулийн төслийн төсвийн товчоог нэмэх;	ТУСГАСАН	Хуулийн төслийн гарчиг бүтцийн товчоог нэмсэн.	Хуулийн тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1-д заасны дагуу саналыг тусгав.		
32.		Хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-д заасан "хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл"-д тавигдах техникийн шаардлагыг хангах нь зүйтэй байна.	ТУСГАСАН		Хуулийн тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу саналыг тусгав.		
33.	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 2026.06.22 01/1873	Хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан нийгмийн сүлжээний эрсдэлийн үнэлгээг Монгол Улсын эдийн засгийн харьяат бус аж ахуйн нэгжид хэрхэн хийх талаар нэмж тусгах;	ТУСГААГУЙ		Энэ хуулийн төслийг байршил харгалзахгүй үйл ажиллагаа явуулж буй нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийг хамруулан боловсруулсан тул эдийн засгийн харьяалал харгалзахгүй эрсдэлийн үнэлгээг хийхээр тусгасан.		
34.		Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасан зохицуулалттай нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн хүлээх үүргийн хэрэгжилтийг хангуулахад Монгол Улсын эдийн засгийн харьяат бус аж ахуйн нэгж байгаа тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, харилцан ажиллах талаар нэмж тусгуулах саналтай байна.	ТУСГАСАН	10.1.Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч дараах эрх, үүрэгтэй байна:	Саналыг хуулийн төслийн 10.1-т нэгтгэн найруулсан.		
35.	Эрүүл мэндийн сайд 2026.06.23 01/3059	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг нэмж хуулийн төсөлд тусгах;	ТУСГАСАН	14.1 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг нэмж тусгав.		
36.		Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчдэд хүүхдийн нас баталгаажуулах, эцэг, эхийн хяналтын тохиргоо, хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх техникийн шаардлага тавих асуудлыг тодорхой тусгах;	ТУСГАСАН	8.1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн насны онцлогт нийцүүлэн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавих, хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалах үүрэгтэй;	Хуулийн төслийн 8 дугаар зүйлд Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүргийг, 10 дугаар зүйлд нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үүргийг нэмж тусгасан.		
37.		Нийгмийн сүлжээний платформын алгоритм, хиймэл оюун ухаанд суурилсан санал болгох систем нь хүүхдийн сэтгэцийн болон биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, хүчирхийлэл, амиа хорлолт, бэлгийн мөхлөг, донтох зан үйл өдөөх агуулгыг хүүхдэд санал болгох, түгээх,	ТУСГАСАН	6.3.3.хориотой, хүүхдэд хортой агуулгын харагдац, түгээлт, санал болгох алгоритмыг хязгаарлах;	Хуулийн төслийн 6.3.3-т уг зохицуулалт тусгагдсан болно.		

38.	давтамжтай харуулахыг хориглох гэсэн заалтын нэмж тусгах; Хүүхдийн цахим хэрэглээний эрүүл мэндийн нөлөөллийн үндэсний судалгааг тогтмол хийх талаар тусгах;	ТУСГАСАН	15.1.4.нийгмийн сүлжээнээс үүдэлтэйгээр Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан эрсдэлт нөхцөл бий болох тохиолдол, хүүхдийн нас, бие бялдар, сэтгэхүйн болон сэтгэл зүйн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй агуулга, үйлчилгээ, хэрэглээний хэв шинжид судалгаа, дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжилтийг хангах;	Хуулийн төслийг саналын дагуу өөрчлөн найруулсан.	
39.	Эцэг, эх, харгалзан дэмжигчийн эрх үүргийг тодорхой тусгаж өгөх;	ТУСГАСАН	8.1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн насны онцлогт нийцүүлэн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавих, хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалах үүрэгтэй; 4.1.6."хориотой агуулга" гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.15-д заасан агуулгыг; 4.1.2."насны баталгаажуулалт" гэж хэрэглэгчийн насыг итгэмжлэгдсэн эх сурвалжийн өгөгдөлд үндэслэн үйлчилгээ авах насны босгыг хангаж буй эсэхийг технологийн арга хэрэгслийг ашиглан баталгаажуулах цогц үйл ажиллагааг;	Хуулийн төслийн 8 дугаар зүйлд Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүргийг тусгав.	
40.	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт дараах томъёог тодорхойлж нэмж оруулах. - Цахим дарамт, цахим донтох зан үйл, сэтгэцэд сөрөг нөлөөтэй контент; - Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд эрсдэлтэй контент; - Нас баталгаажуулалт, эцэг, эхийн хяналт; - Эрүүл мэндэд хортой дижитал нөлөөлөл;	ХЭСЭГЧЛЭН ТУСГАСАН	4.1.6."хориотой агуулга" гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.15-д заасан агуулгыг; 4.1.2."насны баталгаажуулалт" гэж хэрэглэгчийн насыг итгэмжлэгдсэн эх сурвалжийн өгөгдөлд үндэслэн үйлчилгээ авах насны босгыг хангаж буй эсэхийг технологийн арга хэрэгслийг ашиглан баталгаажуулах цогц үйл ажиллагааг;	"Цахим дарамт, цахим донтох зан үйл, сэтгэцэд сөрөг нөлөөтэй контент, Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд эрсдэлтэй контент" гэсэн агуулга нь хүүхдэд хортой агуулгад хамаарч байгаа бөгөөд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.16 дахь заалтад туссан байна. "Нас баталгаажуулалт"-ыг хуулийн төслийн 4.1.2-д тусгав. Харин эцэг эхийн хяналтыг чиг үүргийг хуулийн төслийн 8 дугаар зүйлд тодорхой тусгасан тул нэр томъёоны тодорхойлолтыг нэмж тусгах шаардлагагүй. "Эрүүл мэндэд хортой дижитал нөлөөлөл" гэж агуулга хуулийн төсөлд тусгагдаагүй тул Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар энэхүү хуулийн төсөлд тусгах шаардлагагүй байна.	
41.	Монгол Улсын нутаг дэвсгэрт цахим үйлчилгээ үзүүлж, Монгол Улсын иргэн, хүүхдийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах,	ТУСГАСАН	3.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хэрэглэгчид нийгмийн	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	

42.	түгээх үйл ажиллагаа явуулж буй гадаадын нийгмийн сүлжээний платформ, үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү хуулийг нэгэн адил дагаж мөрдөнө гэж нэмж тусгах	ТүсГАСАН	сүлжээний үйлчилгээ үзүүлж буй этгээд нь энэхүү хуулийг нэгэн адил дагаж мөрдөнө. 6.1.Нийгмийн сүлжээнд энэ хуульд заасан урьдчилан сэргийлэх технологийн арга хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. 7.1.Харилцаа холбооны зохицуулах хороо нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд үндэслэн нийгмийн сүлжээн дэх хүүхдийн аюулгүй байдлад учруулж эрсдэлийн болзошгүй тогтоох түвшнийг зорилгоор эрсдэлийн үнэлтээ зохион байгуулна. 10.1.Нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч дараах эрх, үүрэгтэй байна:	Хуулийн төслийн 6, 7, 10 дугаар зүйлд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үүргийг тодорхой тусгасан.	
43.	Хуулийн төсөлд туссан хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах бодлого нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой болохыг дэмжиж байна.	ТУСГАСАН			
44.	Тусгай зөвшөөрөлгүй аж ахуй нэгж нийгмийн сүлжээ, цахим платформ, цахим контент болон цахим хаяг, сувгаар дамжуулан эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, витамин, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, жин бууруулах, биеийн галбир өөрчлөх үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдах, хэрэглэхийг шууд болон шууд бусаар уриалахыг хориглоно гэж нэмж тусгах.	ТУСГААГҮЙ		Хуулийн төслийн үзэл баримтлалд энэ талаарх харилцааг зохицуулахаар тусгаагүй тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.1-д заасны дагуу саналыг тусгаагүй болно.	
45.	Зам, тээврийн сайд 2026.06.23 01/3085	ТүсГАСАН	8.1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн насны онцлогт нийцүүлэн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавих, хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалах үүрэгтэй;	Хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргийг Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2, 26.2.4 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан үүрэгтэй уялдуулан боловсруулав.	
46.	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсаас 100,000-аас дээш хэрэглэгчтэй нийгмийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийж болно" гэж тус эрсдэлийн үнэлгээг үндэслэж харилцаа холбооны зохицуулах хорооноос мэдэгдэл хүргүүлэх,	ТУСГАСАН	7.1.Харилцаа холбооны зохицуулах хороо нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд үндэслэн нийгмийн сүлжээн дэх	Саналыг хуулийн төслийн 7 дугаар зүйлд тусгаж, өөрчлөн найруулав.	

	хуулийн төслийн 10.2-т заасан шаардлагыг 90 хоногт хангуулах зэрэг дотоодын нийгмийн сүлжээнд зориулсан зохицуулалт тусгагдсаныг олон улсын "tik tok, youtube, facebook" зэрэг хүүхдүүд өргөн ашигладаг платформуудтай хэрхэн уялдаж, Монгол улсад хүүхдийн цахим орчинд цахим хэрэглээг хэрхэн хянах, хүүхдэд зориулсан тохиргоог хэрхэн зөв идэвхжүүлэх талаар тодорхой зохицуулалтыг тусгах зэрэг болно.			хүүхдийн байдалд болзошгүй түвшнийг зорилгоор үнэлгээ байгуулна.	аюулгүй учруулж эрсдэлийн тогтоох эрсдэлийн зохион	
47.	Монгол Улсын шадар сайд Т.Доржанд 2026.06.23 ЗГ-3/507	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилго нь нийгмийн сүлжээнд хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, бодитоор хамгаалах технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино." гэж өөрчлөх. Нийгмийн сүлжээний нөлөөллөөс үүдэн гарах хүүхдэд учирч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан бодитой хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь энэ хуулиар хамгаалахаар зорьж буй харилцааны гол зорилго нь гэж үзэж байна. Иймд энэхүү агуулгыг хуулийн зорилт хэсэгт тусгах нь зүйтэй.	ТУСГААГУЙ			Хуулийн төсөлд тусгасан "технологийн хамгаалалт" нь олон улсад ашиглагддаг, хэрэгжихүйц, бодитой арга хэмжээ тул хүүхдэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгод нийцсэн болно. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1.4 дэх заалтад тусгасан нийтлэг шаардлагад нийцүүлэн саналыг тусгаагүй болно.
48.		Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "Хүүхдийн нийгмийн сүлжээнд хориотой, хүүхдэд хортой мэдээлэл илрэх тохиолдолд цахим сүлжээг нэн даруй хязгаарлаж, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэл, санаамж илгээх системийг бүрдүүлэх" агуулгаар зохицуулалт нэмэх. Энэхүү зохицуулалтын хүрээнд энэ төрлийн ухаалаг системийг нэвтрүүлснээр хүүхдийн цахим сүлжээнд хяналт тавих эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн шууд болон үр нөлөөтэй үүрэг хэрэгжих боломжтой. Мөн хүүхдэд эрсдэл учрахаас нь өмнө сэргийлэх зорилт биелэхэд чухал үр нөлөөтэй.	ТУСГААГУЙ			Хуулийн төслийн 8 дугаар зүйлд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх үүргийг тодорхойлсон. Мөн хуулийн төслийн 6.3-д заасан урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээ нь хүүхдэд эрсдэл учрахаас өмнө сэргийлэх зорилтыг хангаж байгаа болно. Харин нийгмийн сүлжээнд хориотой, хүүхдэд хортой мэдээлэл илрэх тохиолдол бүрт нийгмийн сүлжээг нэн даруй хязгаарлах нь хүний мэдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хөндөхөөр байгаа тул энэхүү санал нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцэхгүй болно.
49.		Хуулийн төслийн 8 дугаар зүйлд Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхдийн насны онцлогт нийцүүлэн нийгмийн сүлжээний хэрэглээнд хяналт тавих, хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс хамгаалахад хэрэгжүүлэх үүргүүдийг тусгасан байна. Хуулийн төслийн 8.2.1-д "Хүүхдийн ашиглаж буй нийгмийн сүлжээний талаар мэдлэгтэй байх, цахим ур чадвараа дээшлүүлэх сургалт, зөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагаас авах" гэж тусгажээ. Энэхүү үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлэх тухай хуулийн төслийн хүрээнд 9 дүгээр зүйлийн 9.2.1-д "Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдлэг олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, зөвлөмж өгөх" гэж Боловсролын байгууллагын чиг үүрэгт тусгагдсан	ТУСГААСАН	14.1.2.цахим ур чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн сүлжээний аюулгүй байдлыг хангах, цахим орчны хэрэглээний соёлыг төлөвшүүлэх агуулгыг сургалтын хөтөлбөрт үе шаттайгаар тусгах; 16.1.4.хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, олон нийт, мэргэжилтэнд зориулсан хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс урьдчилан	14.1.2.цахим ур чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн сүлжээний аюулгүй байдлыг хангах, цахим орчны хэрэглээний соёлыг төлөвшүүлэх агуулгыг сургалтын хөтөлбөрт үе шаттайгаар тусгах; 16.1.4.хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, олон нийт, мэргэжилтэнд зориулсан хүүхдийг нийгмийн сүлжээний эрсдэлээс урьдчилан	Хуулийн төслийн 14.1.2, 16.1.4-т тус тус тусгав.

	байна. Энэ төрлийн мэдлэг, мэдээлэл олгох сургалт, зөвлөгөөг дан ганц боловсролын байгууллагаас өгөх нь хангалтгүй хүртээмжгүй юм. Мэдээлэл, зөвлөгөө хүссэн хүн бүрд хүртээмжтэй, шаардлагатай тохиолдолд шууд зөвлөгөө, мэдээлэл нэн даруй авах боломжтой үйлчилгээний системийг бүрдүүлэх нь чухал юм. Тус дэмжлэгийг нийслэл, орон нутгийн түвшинд буюу шаталсан системтэйгээр боловсролын асуудал хариуцсан нэгжид мэдээлэл өгөх үүргийг нэмж тусгах шаардлагатай байна.			сэргийлэх, цахим ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	
50.	Хуулийн төслийн 18 дугаар зүйлд тусгагдсан гомдол, мэдээлэл хүлээн авах, шилжүүлэх ажиллагааны зохицуулалтыг илүү тодорхой, нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзэж байна	ТУСГАСАН	18.1.хүн, хуулийн этгээд нь нийгмийн сулжээнд хүүхдийн аюулгүй байдал зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд гаргана.	Хуулийн төслийн 18.1-18.3-ыг саналын дагуу өөрчлөн найруулсан.	
51.	Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ" гэснийг "Энэ хуулийн зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ." гэж өөрчлөх саналтай	ТУСГАСАН	18.2.Гомдол, мэдээллийг хүлээн авсан этгээд нь гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж, бүртгэл хөтөлнө. 18.3.Эрх бүхий этгээд нь хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчил шалтан шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шалгаж, тухайн үйлдэл, үйл ажиллагаа нь энэ хуульд заасан хүүхдийн эрх, аюулгүй байдлад харшилсан эсэх, эрсдэл учруулсан эсэхийг тогтоож шийдвэрлэнэ. 19.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	

52.	Эрчим хүчний сайд 2026.06.23 а/2591	Тусгайлан өгөх саналгүй.	ДЭМЖСЭН			
53.	Монгол Улсын Шадар сайд Н.Номтойбаяр 2026.06.25 ЗГ-2/605	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд хүүхдийн цахим аюулгүй байдлын боловсрол, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүс нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж, алслагдсан болон орон нутгийн бүсүүдийн хүүхэд, эцэг эх, багш нарт зориулсан цахим орчны эрсдэлийн талаарх сургалт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.	ТУСГААГҮЙ		Доорх агуулга бүхий зохицуулалт тусгагдсан болно. 15.1.1.нийгмийн сүлжээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих; 15.1.3.холбогдох төрийн байгууллагатай хамтран нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтэд чиглэсэн мэдлэг олгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;	АХ-ээр ярилцах шаардлагатай: - цахим аюулгүй байдлын стандарт?
54.		Хуулийн төсөлд хүүхдийн цахим аюулгүй байдлын стандартыг боловсруулж мөрдүүлэх, нас баталгаажуулах тогтолцоо болон хүүхдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг илүү нарийвчлан тусгах шаардлагатай байна. Түүнчлэн дээрх зохицуулалтыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна.	ХЭСЭГЧЛЭН ТУСГАСАН		"Цахим дарамт, цахим донтох зан үйл, сэтгэгдэл сөрөг нөлөөтэй контент, Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд эрсдэлтэй контент" гэсэн агуулга нь хүүхдэд хортой агуулгад хамаарч байгаа бөгөөд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.16 дахь заалтад туссан байна. Насны баталгаажуулалтын үйл явц нь технологийн хөгжлөөс шууд хамаарах бөгөөд хэрэгжүүлэх аргачлал, техникийн шийдэл нь цаг хугацааны явцад өөрчлөгдөх боломжтой харилцаа юм. Иймд уг үйл явцыг хуулийн түвшинд хэт нарийвчлан зохицуулах нь технологийн шинэчлэлд нийцэхгүй болох, хууль ойр ойрхон нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсгэх эрсдэлтэй. Хуулийн төсөлд насны баталгаажуулалтын үндсэн зарчим, оролцогчдын эрх, үүрэг, хүний хувийн мэдээллийг хамгаалах шаардлагыг тогтоосон бөгөөд хэрэгжилтийн техникийн дараалал, мэдээлэл солилцох аргачлал, аюулгүй байдлын шаардлага зэрэг нарийвчилсан зохицуулалтыг эрх бүхий байгууллагаас батлах журам болон техникийн стандартаар зохицуулах нь хууль тогтоох нийтлэг зарчимд нийцнэ.	
55.		Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээ, гаргах шийдвэрийн ил тод байдлыг хангах, хуулийн хэрэгжилтийн талаарх тайлан, статистик мэдээллийг олон	ТУСГАСАН	17.1.4. Энэ хуульд заасан технологийн арга хэмжээний нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	

		нийтэд тогтмол мэдээлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой тусгах нь зүйтэй байна. Энэ хүрээнд хүний эрхийг хүндэтгэсэн, хариуцлагатай хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, мөн иргэд, эцэг эх, хүүхдийн төлөөллийн оролцоог хангах механизмыг хуулийн төсөлд нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзэж байна.		үүргийн биелэлт, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлсэн байдал, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн талаарх тайлан, статистик мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хагас жил тутам олон нийтэд мэдээлэх.		
56.	Засгийн газрын хэрэг эрхлэх газар 2026.06.25 ХЭГ/3912	Холбогдох хуулиудтай нэр томъёоны нийцүүлэлтийг хийх (Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль); Хувийн мэдээллийн зориулалтын хязгаарлалт, хадгалах хугацаа, хариуцлагын тогтолцоог тодорхой зохицуулах;	ТУСГАСАН		Саналыг үндэслэлтэй гэж үзэж, бусад холбогдох хуулийн нэр томъёоны нийцүүлэлтийг хийсэн.	
57.			ТУСГААГҮЙ		Хуулийн төсөлд хэрэглэгчийн хувийн мэдээллийг нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч эсхүл төрийн байгууллага шинээр цуглуулах, хадгалах тогтолцоо бий болгоогүй бөгөөд насны баталгаажуулалтыг хүнийг тодорхойлох боломжгүй мэдээлэл (насны бүлгийн мэдээлэл)-ийг дамжуулах зарчмаар хэрэгжүүлэхээр зохицуулсан. Түүнчлэн хуулийн төслийн 11.1.2-т насны баталгаажуулалтад шаардлагатай мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй болгож солилцох техникийн болон зохион байгуулалтын нехцэлийг бүрдүүлэх, 11.1.3-т насны баталгаажуулалтын зорилгоор ашигласан мэдээллийн нууцлалыг хангахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баримтлахаар тус тус зохицуулсан. Иймд энэхүү хуулийн төслөөр хүний хувийн мэдээллийг шинээр цуглуулах, хадгалах, боловсруулах эрх зүйн харилцаа үүсэхгүй тул хувийн мэдээллийн зориулалтын хязгаарлалт, хадгалах хугацаа, хариуцлагын тогтолцоог давхар зохицуулах шаардлагагүй гэж үзэв.	
58.		Салбар дундын зөвлөлийн байгуулалт, бүрэлдэхүүн, чиг үүргийг тусгайлан зохицуулах;	ТУСГААГҮЙ		Хүүхэд хамгааллы тухай хуульд заасан Салбар дундын зөвлөлийн үйл ажиллагааг тус хуулийн төслөөр зохицуулах шаардлагагүй	
59.		Харилцаа холбооны тухай хууль болон дагалдах журмуудад зэрэгцэн шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг тодорхой зааж өгөх.	ТУСГААГҮЙ		Тус агуулга үзэл баримтлалын түвшинд тусгагдсан ба Хуулийн төсөлд Харилцаа холбооны тухай хууль болон дагалдах журмуудад зэрэгцэн шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.	

60.		нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь гадаадын улсад байрших, улс дамнасан гадаадын хуулийн этгээдийн хариуцсан цахим хэрэглүүр /аппликэйшн/ байж болох тул хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан үүрэг хэрэгжих эсэх, улмаар Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага тооцох боломжтой эсэх талаар нягтлах.	ТУСГАСАН	3.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хэрэглэгчид нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлж буй этгээд нь энэхүү хуулийг нэгэн адил дагаж мөрдөнө.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
61.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд 2026.06.25 01/3912	Тусгайлан өгөх саналгүй.	ДЭМЖСЭН			
62.	Гадаад харилцааны сайд 2026.06.16 01/3044	Төслийн 4.1.5-д "харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч" гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 9.4-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийг хэлнэ" гэсэн боловч тухайн эшилсэн заалт нь "9.4 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон томдол гаргах" харилцааг зохицуулж байх тул эшлэлийг тодорхой хийх.	ТУСГАСАН	4.1.5."харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч" гэж Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.4-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийг.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
63.		Төслийн 16.1.2-т тусгасан "мэргэжилтэн" гэдэг нь өргөн утгатай, төсөлд нэг удаа дурдагдсан байхаас гадна аль салбарын мэргэжилтэн гэдэг нь ойлгомжгүй байх тул нарийвчлан тодорхойлох,	ТУСГАСАН	16.1.2.нийгмийн сүлжээнээс үүдэлтэй эрсдэлийг судалж, дүн шинжилгээ хийх, нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах санал боловсруулж дээд шатны байгууллагад уламжлах;	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
64.		Зөрчлийн тухай хуульд дагалдуулан нэмэлт оруулахдаа "Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих" гэсэн зүйл нэмэх. Учир нь нэмэлт оруулахаар боловсруулсан Зөрчлийн тухай хуулийн 6.20 болон 14.1 дүгээр зүйл нь "хүүхдийн эрх зөрчих", "Харилцаа холбооны тухай хууль зөрчих" гэсэн өөр өөр харилцаанд хамаарч байна.				
65.		Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын дөрөвдүгээр тайланг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын Ажлын хэсгийн ээлжит 50 дугаар хуралдаанаар хэлэлцсэний мөрөөр Хүний эрхийн зөвлөлөөс зөвлөмжүүд ирүүлсэн ба тэднийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2026 оны 73 дугаар тогтоолоор баталсан. Ерөнхий төлөвлөгөөний 25, 26, 87, 164, 165 дахь мөрд тус тус тусгасан цахим орчинд жөндөрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, хүн худалдаалах гэмт хэрэг зэргээс хүүхдийг хамгаалах агуулгыг хуульд тусгах.	ТУСГААГҮЙ	Тус хуулийн төсөл нь нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч болон эрх бүхий байгууллагын хэрэгжүүлэх технологийн болон зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох зорилготой болно. Иймд дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангахтай холбоотой агуулгыг Хүүхэд хамгааллын тухай хуульд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд энэ хуулийн төслийн зохицуулах зүйл, хамрах хүрээнд шууд хамаарахгүй гэж үзэв.		
66.	Сангийн сайд 2026.06.24	Хуулийн төслийн үзэл баримтлалд "... хуулийн төсөлтэй холбогдуулан Хүүхэд хамгааллын тухай				

01/7789	хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна" гэж тусгасан байна.	хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна" гэж тусгасан байна.					
67.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 2026.06.17 01/2109	Тусгайлан өгөх саналгүй.	ДЭМЖСЭН				
68.	Батлан хамгаалахын сайд 2026.06.11 1а/ 2532	Хуулийн төслийн 3.1-д "Энэ хууль нь нийгмийн сүлжээнд хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцаанд хамаарна." гэснийг хуулийн төслийн 1.1-д заасантай нийцүүлэн "Энэ хууль нь нийгмийн сүлжээнд хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, аюулгүй байдлыг хангах, технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон харилцаанд хамаарна." гэж;	ТУСГАСАН	3.1.Энэ нийгмийн сүлжээнд хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон харилцаанд хамаарна.	нь хууль сүлжээнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, технологийн зохицуулалт хийхтэй холбогдсон харилцаанд хамаарна.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
69.		Хуулийн төслийн 6.3-т "Зохицуулалттай нийгмийн сүлжээнд 13-16 насны хүүхдийн хэрэглээнд дараах урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ." гэснийг хуулийн төслийн үзэл баримтлалын 2-т "Нийгмийн сүлжээнд 13 насанд хүрээгүй хүүхдийг бүртгэхийг хориглох, 13-16 насны хүүхдэд нийгмийн сүлжээг хязгаарлалттайгаар хэрэглүүлэх" гэж, хуулийн төслийн 6.2-т "Нийгмийн сүлжээг 13 насанд хүрээгүй хүүхдэд ашиглуулахыг хориглоно." гэж тус тус заасантай нийцүүлэн 6.3 дахь хэсгийг "Зохицуулалттай нийгмийн сүлжээнд 13- 16 насны хүүхэд хамрагдаж, хэрэглэнэ. Хэрэглээнд дараах урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ." гэж тус тус өөрчлөн найруулах;	ТУСГАСАН	6.2.Нийгмийн сүлжээнд 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	6.2.Нийгмийн сүлжээнд 13 буюу түүнээс дээш 16 нас хүрээгүй хүүхдийн хэрэглээнд урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
70.		Энэ хуулиар тогтоосон 13 насанд хүрээгүй хүүхэд болон 13-16 насны нийгмийн сүлжээг хязгаарлалттайгаар хэрэглэх хүүхдэд насанд хүрсэн өөрийн нэр дээр дугаар авч өгсөн, дугаараа хэрэглүүлсэн тохиолдолд хариуцлага тооцогчтой холбоотой хоригтосон болон иргэнийг үүрэгжүүлсэн зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах шаардлагатай байна.					АХ Эцэс эх, ирээдүйг төрөөх асуудлыг тусгах эсэх талаар Сайдас шийдвэр авна

71.	Харилцаа холбооны зохицуулах хороо	Хуулийн төслийн 7.7 дэх хэсэг дэх "Монгол Улсаас хандах хандалтыг хаах хүртэлх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" гэснийг "Монгол Улсаас хандах хандалтыг хаах хүртэлх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ" гэж өөрчлөх	ТУСГАСАН	7.7.Нийгмийн сүлжээнд хуульд заасан урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй нийгмийн сүлжээний үйлчилгээнд Монгол Улсаас хандах хандалтыг хаах хүртэлх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
72.		Хуулийн төслийн 10.2 дахь хэсгийн "ашиглана" гэдгийг "ашиглаж болно" гэж өөрчлөх	ТУСГАСАН	10.2.Хэрэглэгчийн насыг баталгаажуулахад харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчээс дамжуулсан насны бүлгийн мэдээллийг ашиглаж болно.	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
73.		Энэ хэсэг хуулийн төслийн 7.6 дахь хэсэгтэй давхцаж байгаа тул хасах	ТУСГАСАН		Саналын дагуу 10.3 дахь хэсгийг хасаж, давхардлыг арилгав.	
74.		Хуулийн төслийн 11.1.1 дэх заалтын "16-аас доош насны" гэдгийг "16 болон түүнээс доош насны" гэж өөрчлөх	ТУСГААГҮЙ		Хуулийн төсөлд 16 нас хүрсэн бол нийгмийн сүлжээг ашиглахыг хориглоогүй.	
75.		Хуулийн төслийн 17.1.2 дахь заалтын "эрх бүхий байгууллага, албан тушаалтны" гэснийг "эрх бүхий байгууллагын" гэж өөрчлөх.	ТУСГАСАН	17.1.2.нийгмийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай технологийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	
76.		Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг хасаж, дараах агуулга бүхий 3 дугаар зүйлийг нэмэх: "3 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын "хэрэглэгчийг иргэний бүртгэлийн дугаараар бүртгээгүй" гэснийг "хэрэглэгчийг дугаараар бүртгээгүй" гэснийг "хэрэглэгчийг хуульд заасан шаардлагын дагуу иргэний бүртгэлийн дугаараар бүртгээгүй" гэж өөрчилсүгэй."	ТУСГАСАН	Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг хасаж, дараах агуулга бүхий зүйлийг нэмсэн. 2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын "хэрэглэгчийг иргэний бүртгэлийн дугаараар бүртгээгүй" гэснийг "хэрэглэгчийг хуульд заасан шаардлагын дагуу иргэний бүртгэлийн дугаараар бүртгээгүй" гэж өөрчилсүгэй."	Саналыг үндэслэлтэй гэж үзэж, хуулийн төсөлд тусгасан.	

Хавсралт 1: Нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн түүвэр

№	Хуулийн нэр	Зүйл, заалт
1.	Хүүхэд хамгааллын тухай хууль	8 дугаар зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал 8.1.Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална. 8.2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана. 8.3.Хүүхдэд зориулсан мэдээ, мэдээлэл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн ажилтан энэ тухай гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ. 8.4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

		8.5.Арван зургаан насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 8.4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна. 8.6.Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.
2.	Хүний мэдээллийг тухай хууль хувийн хамгаалах	29 дүгээр зүйл.Хориглох зүйл 29.1.Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно. 29.2.Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно. 29.3.Мэдээллийг энэ хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.
3.	Кибер аюулгүй байдлын тухай хууль	15 дугаар зүйл.Цагдаагийн байгууллага 15.1.Цагдаагийн байгууллага кибер аюулгүй байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.1.1.кибер халдлага, зөрчилтэй холбоотой гэмт хэргийн мэдээллийг хүлээн авч, хуульд заасан ажиллагааг явуулах; 15.1.2.энэ хуулийн 15.1.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс гаргуулан авах;

		15.1.3.кибер аюулгүй байдлыг хангах асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөмж, шаардлага, сэрэмжлүүлэг хүргүүлэх; 15.1.4.кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, тоног төхөөрөмж, программ хангамжийг шалгах, судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах зорилгоор тоон шинжилгээний лаборатори ажиллуулах.
4.	Хэвлэл мэдээний эрх чөлөөний тухай хууль	3 дугаар зүйл.Мэдээлэлд хяналт тавихыг хориглох 3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй. 3.2.Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.
5.	Зар сурталчилгааны тухай хууль	6 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд тавих ерөнхий шаардлага 6.5.Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд дараах зүйлийг хориглоно: 6.5.5.Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.8.хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчилах. 7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа 7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.

	7.2.Дараахь зар сурталчилгааг зүй бус зар сурталчилгаанд тооцно: 7.2.2.бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа; 7.3.Дараахь зүйлийн талаар хэрэглэгчийг төөрөгдүүлсэн зар сурталчилгааг бодит байдалд үл нийцсэнд тооцно: 7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно: 7.4.1.бусдын бүтээгдэхүүнийг гутаан доромжилсон; 7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан; 7.4.6.хүнлэг ёс, ёс суртахуун, Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг зан заншлын ёс горимыг зөрчсөн. 7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно. 7.6.Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно. 7.7.Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно. 12 дугаар зүйл.Интернэтээр түгээх зар сурталчилгаа 12.1.Зар сурталчилгаа түгээгч нь бусдын эзэмшилд байгаа интернэтийн хуудсанд өөрийн зар сурталчилгаагаа зөвшөөрөлгүй байрлуулахыг хориглоно.
--	--

	16 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд хүүхдийн эрхийг хамгаалах 16.1.Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд дараахь зүйлийг хориглоно: 16.1.1.эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн нэр хүндийг бууруулах; 16.1.2.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахыг эцэг, эх болон бусад этгээдээс шаардахыг хүүхдэд шууд зөвлөх, ухуулах, бусад хэлбэрээр нөлөөлөх; 16.1.3.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авсан, эсхүл аваагүйгээс бусад хүүхдээс давуутай буюу дор байдалд орно гэсэн ойлголтыг хүүхдэд бий болгох; 16.1.4.хүүхдийг аюултай орон зай, нөхцөл байдалд дүрсэлсэн дүрс, дуу авиа, эсхүл үг хэллэгийг зар сурталчилгаанд ашиглах; 16.1.5.тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэхэд шаардагдах мэдлэг, дадлага, туршлагын төвшинг бууруулж буюу өсгөж сурталчлах; 16.1.6 бүтээгдэхүүний үнийн талаар буруу ойлголт хүүхдэд бий болгох. 16.1.7.Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 3.1.8-д зааснаас бусад нялх, балчир хүүхдэд зориулж үйлдвэрлэсэн хүнс болон хооллох хэрэгслийг сурталчлах; 16.1.8.чихэр, давс, транс болон ханасан тос ихээр агуулсан хоол, хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаанд хүүхэд оролцуулах.
6. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль	5 дугаар зүйл.Садар самууныг сурталчлахыг хориглох 5.1.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно. 5.2.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.

	7 дугаар зүйл.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам 7.2.3. 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдах. 8 дугаар зүйл.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйл 8.1.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих урлаг, үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн, бусад үзвэрийг үзүүлэхэд дараахь зүйлийг хориглоно: 8.1.3. 18 насанд хүрээгүй хүнд үзүүлэх.
7.	Эрүүгийн хууль 16.8 дугаар зүйл.Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 1.Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 16.9 дүгээр зүйл.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах 1.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.кибер орчныг ашиглаж;

	2.2.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 26.1 дүгээр зүйл.Цахим мэдээлэлд хууль бусаар халдах 1.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж компьютерийн өгөгдөл, системд нэвтэрсэн, танилцсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж, сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан; компьютерийн өгөгдлийг нуусан, хандалтад хязгаарлалт тогтоосон, компьютерийн системд санаатайгаар хууль бусаар мэдээлэл дамжуулсан, үйл ажиллагааг хязгаарласан; мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсний улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
8.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 32 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг 32.4.Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ.

9.	Мансууруулах эм, сэтгэцэд бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль	13 дугаар зүйл. Хориглох зүйл 13.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараахь үйл ажиллагааг хориглоно: 13.1.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дуу, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерийн сүлжээг ашиглан сурталчлах;
10.	Хүүхдийн эрхийн тухай хууль	6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх 6.1. Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ: 6.1.5. хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах; 10 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг 10.1. Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ: 10.1.1. хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх; 10.1.2. хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх; 10.1.3. хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

		10.1.4.хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах; 10.1.5.хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах; 10.1.6.хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах; 10.1.7.хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах; 10.1.8.хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах; 10.1.9.хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх; 10.1.10.хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах; 10.1.11.хууль тогтоомжид заасан бусад.
	Бусад	
16.	Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	https://legalinfo.mn/mn/detail/7045
17.	“Цахим монгол” үндэсний хөтөлбөр	https://legalinfo.mn/mn/detail/9465
18.	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	https://legalinfo.mn/mn/detail/4698

19.	Үндэсний хөтөлбөр батлах тухай /Мэдээллийн аюулгүй байдал/	https://legalinfo.mn/mn/detail/4716
20.	Гэмт хэргийн тухай хуулийн төсөл	https://mojha.gov.mn/newmojha/?p=557
21.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	https://legalinfo.mn/mn/detail/6163